



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC

**IRIM**  
INDEPENDENT  
RESEARCH  
INSTITUTE OF  
MONGOLIA

# **БИЧИЛ УУРХАЙ БҮХИЙ АЙМГУУДЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД БИЧИЛ УУРХАЙГААС ОРУУЛЖ БУЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НӨЛӨӨЛӨЛ: ДАВТАН СУДАЛГАА**

## **Эцсийн тайлан**

12 сар 2016

## Агуулга

Агуулга.....	2
Хүснэгт, зургийн жагсаалт.....	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	8
ХУРААНГУЙ.....	9
1 Судалгааны зорилго, арга зүй.....	11
1.1 Судалгааны зорилго.....	11
1.2 Хамрах хүрээ, түүвэр.....	11
1.3 Судалгааны үе шат.....	13
1.4 Дүн шинжилгээний хүрээ.....	13
1.5 Судалгааны хязгаарлалтууд.....	15
2 ЭДИЙН ЗАСГИЙН ШУУД НӨЛӨӨ.....	16
2.1 Ажил эрхлэлт.....	17
2.1.1 Бичил уурхайчид болон ашигт малталын худалдаачдын бий болгосон ажлын байрны тоо.....	17
2.1.2 Бичил уурхайн үйл ажиллагаанаас олох орлого.....	28
2.1.3 Дүгнэлт.....	48
2.2 Татвар болон төлбөр хураамж.....	48
2.2.1 Татвар.....	49
2.2.2 Төлбөр, хураамж.....	53
2.2.3 Нийгмийн даатгал.....	57
2.2.4 Эрүүл мэндийн даатгал.....	61
2.2.5 Ашигт малтмал олборлохтой холбоотой бусад төлбөр хураамж.....	65
2.2.6 АМНАТ буюу Роялти.....	67
2.2.7 Татвар болон төлбөр хураамжийн нэгтгэл.....	68
2.3 Ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой худалдан авалт.....	71
2.3.1 БУЭ-ийн олборлолттой холбоотой худалдан авалт.....	71
2.3.2 АМХЭ-дийн АМХ-тай холбоотой худалдан авалт.....	75
2.3.3 БУЭ болон АМХЭ-дийн бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой худалдан авалтын нийлбэр дүн.....	77
2.3.4 Дүгнэлт.....	80
2.4 Олон нийтэд хандсан хөрөнгө оруулалт.....	80
2.5 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд хувь нэмрийн тойм.....	83
3 ЭДИЙН ЗАСГИЙН ШУУД БУС ХУВЬ НЭМЭР.....	86

3.1	Ажил эрхлэлт .....	91
3.2	Худалдан авалт .....	95
3.3	Татвар, төлбөр хураамж.....	100
3.4	Шууд бус нөлөөллийн тойм .....	102
4	ЭДИЙН ЗАСГИЙН ДАМ НӨЛӨӨ.....	106
4.1	Өрхийн хэрэглээ .....	106
4.2	Малчдын хэрэглээ .....	110
4.3	Дам нөлөөллийн тойм .....	111
5	БИЧИЛ УУРХАЙЧИД БОЛОН АМХ-ЫН ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ ҮРЖҮҮЛЭГЧИЙН НӨЛӨӨ ДҮГНЭЛТ .....	114
6	БИЧИЛ УУРХАЙ БҮХИЙ ОРОН НУТГУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ.....	118
7	БИЧИЛ УУРХАЙЧДЫН ЭРХЭЛЖ БУЙ БИЗНЕСИЙН ХЭЛБЭР, ТӨРӨЛ .....	122
8	ЗӨВЛӨМЖҮҮД.....	124
9	ХАВСРАЛТ 1. Хэрэглэгдэхүүн.....	126
10	ХАВСРАЛТ 2. Судалгаанд оролцсон БУЭ-ийн эрхэлж буй бизнесийн жагсаалт .....	152
11	ХАВСРАЛТ 3. Талбарын судлаачдын талбарын ажиглалтын нэгтгэл .....	154
12	ХАВСРАЛТ 4. Судалгааны гол үр дүнгүүд.....	155
12.1	ШУУД ХУВЬ НӨЛӨӨ .....	155
12.2	ШУУД БУС НӨЛӨӨ .....	156
12.3	ДАМ НӨЛӨӨ .....	157
12.4	ЭДИЙН ЗАСГИЙН НИЙТ НӨЛӨӨ .....	158

## Хүснэгт, зургийн жагсаалт

Дүрс 1 Мэдээлэл боловсруулах арга зүй.....	14
Дүрс 2 Эдийн засгийн шууд нөлөө ба түүний бүрэлдэхүүн хэсгүүд.....	16
Дүрс 3 Нийт БУЭ болон АМХЭ-дийн тоо, суурь ба давтан судалгаа.....	19
Дүрс 4 БУЭ өрхүүдийн ажил эрхэлдэг гишүүдийн эрхэлдэг ажил.....	21
Дүрс 5 АМХЭ өрхүүдийн ажил эрхэлдэг гишүүдийн эрхэлдэг ажил .....	22
Дүрс 6 БУЭ-дийн нийт ажилласан жил ба бичил уурхай эрхэлсэн хугацаа (ТХ=147) .....	23
Дүрс 7 АМХЭ-дийн нийт ажилласан жил ба АМХ эрхэлсэн хугацаа (ТХ=28) .....	23
8 - , 2016 .....	25
Дүрс 9 Албан ба албан бус БУЭ-дийн олборлолт хийдэг тохиолдол .....	25
Дүрс 10 БУ-н олборлолт ба АМХ-ны улирлын мөчлөг/Дүрс12/ .....	26
Дүрс 11 Олборлолт саарсан, эсвэл зогссон үед БУЭ-дийн эрхэлдэг ажлууд.....	27
Дүрс 12 Олборлолт саарсан, эсвэл зогссон үед АМХЭ-дийн эрхэлдэг ажлууд .....	27
Дүрс 13 Давхар ажил эрхэлдэг БУЭ-чдийн эрхэлдэг ажлууд (ТХ=38) .....	27
Дүрс 14 Давхар ажил эрхэлдэг АМХЭ-дийн эрхэлдэг ажлууд (ТХ=18).....	27
Дүрс 15 Албан ба албан бус БУЭ-дийн олборлолтоос олж буй сарын орлогын динамик Дүрс16 .....	28
Дүрс 16 БУЭ өрхүүдийн орлогын төрлүүд .....	30
Дүрс 17 Олборлолтын орлогын БУЭ өрхийн орлогод эзлэх хувь .....	30
Дүрс 18 Өрхийн олборлолтын сарын орлого ба өрхийн сарын нийт орлого, төгрөгөөр.....	30
Дүрс 19 Өрхийн сарын дундаж орлогын харьцуулалт, суурь ба давтан судалгаагаар .....	32
Дүрс 20 Өрхийн олборлолтын сарын дундаж орлогын харьцуулалт, суурь ба давтан судалгаагаар .....	32
Дүрс 21 Ашигт малтмалын борлуулалтын дамжлага.....	39
Дүрс 22 АМХЭ өрхүүдийн орлогын төрлүүд.....	40
Дүрс 23 АМХ-ны орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувь .....	40
Дүрс 24 Өрхийн АМХ-ны сарын орлого ба өрхийн сарын нийт орлого.....	41
Дүрс 25. Татвар төлөлтийн эзлэх хувь, судалгаанд оролцогчдын түвшинд.....	51
Дүрс 26 БУЭ ба АМХЭ-дийн орон нутагтаа хураамж төлөлтийн хувь, судалгаан оролцогчдын түвшинд.....	56
Дүрс 27. БУ болон АМХЭ-дийн НДШ төлөлт, судалгаанд оролцогчдын түвшинд.....	60
Дүрс 28. БУ болон АМХЭ-ийн ЭМД төлөлт, судалгаанд оролцогчдын түвшинд.....	64
Дүрс 29 Монголбанк алт худалдаж авсан ханш (Төгрөгөөр).....	67
Дүрс 30 Олборлолттой холбоотой худалдан авалтын зардлын төрлүүд .....	71
Дүрс 31 БУЭ-дийн худалдан авалтаа хийдэг газрууд .....	71
Дүрс 32 Худалдан авалтын зардлын төрлүүд ба худалдан авалтаа хийдэг газрууд .....	72
Дүрс 33 Олборлолттой холбоотой худалдан авалтын дундаж зардал, суурь ба давтан судалгаагаар .....	72
Дүрс 34 АМХ-тай холбоотой худалдан авалтын зардлын төрлүүд.....	75
Дүрс 35 АМХЭ-дийн худалдан авалтаа хийдэг газрууд.....	75
Дүрс 36 Худалдан авалтын зардлын төрлүүд ба худалдан авалтаа хийдэг газрууд .....	76
Дүрс 37 Эдийн засгийн шууд бус нөлөө ба түүний бүрэлдэхүүн хэсгүүд .....	86
Дүрс 38 Бизнесийн нийт орлого ба БУЭ-дийн оруулж буй орлого .....	87
Дүрс 39 БУ-н олборлолт ба АМХ-ны улирлын мөчлөг .....	89

Дүрс 40 Малчин өрхийн орлого ба БУЭ-дээс олж буй орлого.....	90
Дүрс 41 Судалгаанд хамрагдсан аймгуудын эдийн засгийн өсөлт, 2014 ба 2015 он.....	118
Дүрс 42 Сумдын эдийн засгийн өсөлт, 2015 он.....	118
Дүрс 43 Хүлд ба Мандал сумын ДНБ-ний 2014 ба 2015 оны гүйцэтгэлд салбаруудын эзлэх хувь .....	120
Дүрс 44 Өмнөговь ба Тариалан сумын ДНБ-ний 2014 ба 2015 оны гүйцэтгэлд салбаруудын эзлэх хувь.....	120
Дүрс 45 Үенч ба Булган сумын ДНБ-ний 2014 ба 2015 оны гүйцэтгэлд салбаруудын эзлэх хувь .....	121
Дүрс 46. БУЭ-дийн давхар эрхэлдэг аж ахуйн үйл ажиллагааны чиглэл.....	122
Дүрс 47. Бичил уурхай эрхлэгчдийн давхар эрхэлдэг бизнесийн үйл ажиллагааны чиглэл.....	122
Дүрс 48. Бичил уурхай эрхлэгчдийн бусад бизнесийн анхны санхүүжилтийн эх үүсвэр.....	123
Дүрс 49. БУЭ-дийн эрхэлж буй бусад бизнесийн анхны санхүүжилтийн эх үүсвэр, сумдаар ....	123
Хүснэгт 1. Бичил уурхайн салбарын нийт эдийн засгийн хувь нэмэр болон үржүүлэгч *.....	10
Хүснэгт 3 Судалгаанд хамрагдагсад.....	12
Хүснэгт 4 Албан ба албан бус бичил уурхай эрхлэгчид болон АМХЭ-дийн тоо, суурь ба давтан судалгаа.....	18
Хүснэгт 5 Албан ба албан бус БУЭ-дийн тооны өөрчлөлт, суурь ба давтан судалгааны зөрүүгээр .....	20
Хүснэгт 6 БУЭ өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн тоо ба ажил эрхэлдэг гишүүдийн тоо (ТХ=147).....	21
Хүснэгт 7 Нийт ажилласан жил, БУ болон АМХ эрхэлсэн хугацааны тодорхойлох статистикууд	24
Хүснэгт 8 БУЭ-дийн ашигт малтмалаа борлуулж буй үнэ, суурь ба давтан судалгаа.....	29
Хүснэгт 9 Өрхийн орлого ба орлогын төрлүүдийн тодорхойлох статистик.....	31
Хүснэгт 10 БУЭ өрхийн сарын нийт орлого ба өрхийн сарын олборлолтын орлого, судалгаанд оролцогчдын түвшинд (суурь ба давтан судалгаа).....	33
Хүснэгт 11 БУЭ-дийн олборлолтоос олж буй нийт орлого, сумын түвшинд (суурь ба давтан судалгаа).....	36
Хүснэгт 12 БУЭ-дийн өмнөх ба одоогийн орлогын харьцуулалт.....	37
Хүснэгт 13 Ашигт малтмалыг худалдан авдаг ба борлуулдаг үнэ болон дундаж ашиг.....	39
Хүснэгт 14 Өрхийн сарын нийт орлого ба өрхийн АМХ-наас олж буй сарын орлого, судалгаанд оролцогчдын түвшинд (суурь ба давтан судалгаа).....	42
Хүснэгт 15 АМХЭ-дийн худалдаанаас олж буй нийт орлого, сумын түвшинд, суурь ба давтан судалгаа.....	44
Хүснэгт 16 АМХЭ-дийн өмнөх ба одоогийн орлогын харьцуулалт.....	45
Хүснэгт 17 БУЭ болон АМХЭ-дийн БУ-н үйл ажиллагаанаас олж буй нийт орлого, түүвэр судалгааны түвшинд.....	46
Хүснэгт 18 БУЭ болон АМХЭ-дийн БУ-н үйл ажиллагаанаас олж буй нийт орлого, сумын түвшинд (мянган төгрөг).....	47
Хүснэгт 19 Ажил эрхлэлтээс үүдэлтэй эдийн засгийн шүүд нөлөө.....	48
Хүснэгт 20. БУЭ-дийн суманд төлж буй татвар, судалгаанд оролцогчдын түвшинд.....	49
Хүснэгт 21 АМХЭ-дийн сумандаа төлж буй татвар, судалгаанд оролцогчдын түвшинд.....	50
Хүснэгт 22. БУЭ-дийн төлсөн нийт татвар, сумын түвшинд.....	51

Хүснэгт 23. АМХЭ-дийн суманд төлсөн нийт татвар, сумын түвшинд .....	52
Хүснэгт 24. БУ болон АМХЭ-дийн нийт татвар төлөлт .....	52
Хүснэгт 25. БУЭ-дийн төлсөн хураамж, судалгаанд оролцогчдын түвшинд .....	53
Хүснэгт 26 АМХЭ-дийн төлж буй нийт хураамж, судалгаанд оролцогчдын түвшинд .....	54
Хүснэгт 27 БУЭ-дийн төлж буй нийт төлбөр, хураамж, сумын түвшинд.....	55
Хүснэгт 28 АМХЭ-дийн төлж буй нийт төлбөр, хураамж, сумын түвшинд. ....	56
Төлбөр хураамжийн дээрх дүнгүүдийг нэгтгэн дараах хүснэгтэд харуулав.Хүснэгт 29 БУ болон АМХЭ-дийн хураамж төлсөн хэмжээ .....	57
Хүснэгт 29 БУ болон АМХЭ-дийн хураамж төлсөн хэмжээ .....	57
Хүснэгт 30. БУЭ-дийн төлж буй НДШ, судалгаанд оролцогчдын түвшинд.....	57
Хүснэгт 31. АМХЭ-дийн төлж буй НДШ, судалгаанд оролцогчдын түвшинд .....	58
Хүснэгт 32 БУЭ-дийн төлж буй НДШ, сумын түвшинд.....	59
Хүснэгт 33 АМХЭ-дийн төлж буй НДШ, сумын түвшинд .....	59
Хүснэгт 34 БУЭ болон АМХ-ын төлсөн НДШ-ийн хэмжээ.....	60
Хүснэгт 35. БУЭ-дийн төлж буй ЭМД, судалгаанд оролцогчдын түвшинд .....	61
Хүснэгт 36. АМХЭ-дийн төлж буй ЭМД, судалгаанд оролцогчдын түвшинд.....	62
Хүснэгт 37. БУЭ-дийн төлж буй ЭМД, сумын түвшинд. ....	63
Хүснэгт 38 АМХЭ-дийн төлж буй ЭМД, сумын түвшинд.....	64
Хүснэгт 39 БУ болон АМХЭ-дийн ЭМД төлөлт, суурь болон давтан судалгааны нэгдсэн дүнг 2 түвшингөөр харицуулалт .....	65
Хүснэгт 40. БУЭ-дийн төлсөн газрын төлбөр, бусад хураамж, давтан судалгаанд оролцогчдын түвшинд.....	65
Хүснэгт 41 БУЭ-дийн төлсөн газрын төлбөр болон бусад хураамж, 2016 оны сумын түвшинд... 66	
Хүснэгт 42 БУЭ-дийн газрын төлбөр болон бусад хураамж төлөлт давтан судалгааны нэгдсэн дүнг 2 түвшингөөр харицуулалт .....	67
Хүснэгт 43. БУЭ-дийн татвар, төлбөр, хураамжийн нэгдсэн дүн, судалгаанд оролцогчдын түвшинд.....	68
Хүснэгт 44. АМХЭ-дийн төлсөн нийт татвар, төлбөр, хураамж, судалгаанд оролцогчдын түвшинд .....	68
Хүснэгт 45. БУЭ-дийн төлсөн татвар, төлбөр, хураамжийн нэгдсэн дүн, сумын түвшинд .....	69
Хүснэгт 46. АМХЭ-дийн төлсөн татвар, төлбөр, хураамжийн нэгдсэн дүн, сумын түвшинд.....	70
Хүснэгт 47 Татвар, төлбөр хураамж, НДШ болон ЭМД -н төлсөн нэгдсэн дүн.....	70
Хүснэгт 48 БУЭ-дийн олборлолттой холбоотой худалдан авалтын зардал, судалгаанд оролцогчдын түвшинд, суурь ба давтан судалгаагаар .....	73
Хүснэгт 49 БУЭ-дийн олборлолттой холбоотой худалдан авалтын зардал, сумын түвшинд, суурь ба давтан судалгаагаар.....	74
Хүснэгт 50 АМХЭ-дийн худалдан авалтын зардал, судалгаанд оролцогчид ба сумын түвшинд .77	
Хүснэгт 51 БУЭ болон АМХЭ-дийн БУ-н үйл ажиллагаатай холбоотой худалдан авалтын зардал, түүвэр судалгааны түвшинд .....	78
Хүснэгт 52 БУЭ болон АМХЭ-дийн БУ-н үйл ажиллагаатай холбоотой худалдан авалтын зардал, сумын түвшинд.....	79
Хүснэгт 53 БУ-н үйл ажиллагаатай холбоотой худалдан авалтын эдийн засгийн шууд нөлөө ....	80
Хүснэгт 54. ТББ-ын олон нийтэд хийсэн хөрөнгө оруулалт.....	81
Хүснэгт 55. БУЭ-дийн орон нутагт хийж буй хөрөнгө оруулалтын хэмжээ.....	81
Хүснэгт 56. АМХЭ-дийн олон нийтэд хийсэн хөрөнгө оруулалт .....	82

Хүснэгт 57 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд хувь нэмэр, судалгаанд оролцогчдын түвшинд.....	83
Хүснэгт 58 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд хувь нэмэр, сумдын түвшинд.....	84
Хүснэгт 59 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд хувь нэмрийн нэгдсэн дүн, суурь ба давтан судалгаагаар.....	85
Хүснэгт 60 Бизнесийн нийт орлого ба БУЭ-дийн оруулж буй нийт орлого, сумдаар.....	88
Хүснэгт 61 Малчин өрхүүдийн сарын нийт орлого ба БУЭ-дийн оруулж буй нийт орлого, сумдаар.....	90
Хүснэгт 62 Бизнес эрхлэгч ба малчин өрхийн БУЭ-дээс олж буй нийт орлого.....	91
Хүснэгт 63 Бизнес эрхлэгчдийн бий болгосон ажлын байрны тоо болон цалингийн зардал, судалгаанд оролцогчдын түвшинд.....	93
Хүснэгт 64 Бизнес эрхлэгчдийн бий болгосон ажлын байрны тоо болон цалингийн зардал, сумын түвшинд.....	94
Хүснэгт 65 Бизнес эрхлэгчдийн худалдан авалтын зардал, судалгаанд оролцогчдын түвшинд, мянган төгрөг.....	97
Хүснэгт 66 Бизнес эрхлэгчдийн худалдан авалтын зардал, сумдын түвшинд.....	99
Хүснэгт 67 Бизнес эрхлэгчдийн татвар төлөлт, судалгаанд оролцогчдын түвшинд.....	101
Хүснэгт 68 Бизнес эрхлэгчдийн татвар төлөлт, сумын түвшинд.....	102
Хүснэгт 69 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд бус хувь нэмэр, судалгаанд оролцогчдын түвшинд.....	103
Хүснэгт 70 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд бус хувь нэмэр, сумдын түвшинд.....	104
Хүснэгт 71 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд бус хувь нэмрийн нэгдсэн дүн, суурь ба давтан судалгаагаар.....	105
Хүснэгт 72. БУЭ ба АМХЭ өрхийн сарын дундаж зардал.....	106
Хүснэгт 73. БУЭ ба АМХЭ өрхийн сарын дундаж зардал-2015 .....	107
Хүснэгт 74. БУЭ ба АМХЭ-ийн дам нөлөөлөл-2016.....	108
Хүснэгт 75. БУЭ, АМХЭ дам нөлөөлөл-2015 .....	108
Хүснэгт 76. БУЭ болон АМХЭ -дийн дам нөлөөллийн нэгдсэн дүн.....	109
Хүснэгт 77. Малчдын дам нөлөөлөл, судалгаанд хамрагсадын түвшинд.....	110
Хүснэгт 78. Сумын эдийн засагт үзүүлэх дам нөлөөлөл, судалгаанд оролцогчдын түвшинд ....	111
Хүснэгт 79. Сумын эдийн засагт үзүүлэх дам нөлөөлөл, сумын түвшинд .....	112
Хүснэгт 80. Өрхийн эдийн засгийн дам нөлөөллийн тойм .....	113
Хүснэгт 81 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засгийн нөлөө ба үржүүлэгч, судалгаанд оролцогчдын түвшинд.....	115
Хүснэгт 82 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засгийн нөлөө ба үржүүлэгч, судалгаанд оролцогчдын түвшинд нэгдсэн дүн.....	116
Хүснэгт 83 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засгийн нөлөө ба үржүүлэгч, сумдын түвшинд .....	117
Хүснэгт 84 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засгийн нөлөө ба үржүүлэгч, сумдын түвшинд нэгдсэн дүн .....	117

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМ	Ашигт малтмал
АМХ	Ашигт малтмалын худалдаа
АМХЭ	Ашигт малтмалын худалдаа эрхлэгч
БУ	Бичил уурхай
БУЭ	Бичил уурхай эрхлэгч
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
МАА	Мал аж ахуй
НДШ	Нийгмийн даатгалын шимэтгэл
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТБУТ	Тогтвортой бичил уурхай төсөл
ХАА	Хөдөө аж ахуй
ХБЯ	Хагас бүтэцлэгдсэн ярилцлага
ЭМД	Эрүүл мэндийн даатгал



## ХУРААНГУЙ

Энэхүү судалгааг Швейцарын хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн захиалгаар 2016 онд хийж гүйцэтгэв. Уг судалгаа нь 2015 оны суурь судалгаанд хамрагдсан зорилтот 12 сумаас гадна Ховд, Увс аймгийн 5 сумын бичил уурхайн салбарын оролцогчдын сумын эдийн засагт үзүүлж буй хувь нэмрийг үнэлэх зорилготой.

Үүний тулд, бичил уурхайн салбарын орон нутаг дахь эдийн засгийн нийт хувь нэмрийг шууд нөлөө, шууд бус нөлөө, дам нөлөөлөл гэсэн гурван хэсэгт нарийвчлан тооцсон. Шууд нөлөөлөл нь ашигт малтмалын олборлолт, худалдаатай холбоотой мөнгө хөрөнгийг зарцуулалтыг хамрах бөгөөд үүнд хөдөлмөр эрхлэлтийг бий болгох, татвар, материал хангамж болон капитал хөрөнгө оруулалт зэргийг хамруулна. Шууд бус нөлөөлөл нь БУЭ болон АМХ-д ханган нийлүүлэлт хийж буй жижиг, дунд бизнесийн байгууллагууд, малчдын бичил уурхайтай холбоотой зарцуулалтыг хамарна. Харин дам нөлөө нь БУЭ болон АМХ өрхийн хэрэгцээнд зориулан бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг голчлон хамардаг.

Судалгааны мэдээллийг хагас бүтэцлэгдсэн ярилцлага хэлбэрээр цуглуулсан. Судалгаанд албан болон албан бус бичил уурхай эрхлэгчид (147), малчид (50), жижиг дунд бизнес эрхлэгчид (33), ашигт малтмалын худалдаачид (28) болон бичил уурхайчдын төрийн бус байгууллагууд (16) болон 17 сумын захиргааны албан хаагчид хамрагдсан.

Дараах хүснэгтээр 2016 онд хийгдсэн давтан судалгааны гол үр дүн буюу бичил уурхайн салбарын орон нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөөг нэгтгэн харуулав.

### Хүснэгт 1. Бичил уурхайн салбарын нийт эдийн засгийн хувь нэмэр болон үржүүлэгч \*

Аймаг	Эдийн засгийн хувь нэмэр, (мянган төгрөг)					Үржүүлэгч
	Сум	Шууд	Шууд бус	Дам	Нийт	
Баянхонгор	Баян-Овоо	606,930.0	1376.2	476,960.5	1,085,266.7	1.79
	Бөмбөгөр	62,034.0	8462.0	71,277.1	141,773.1	2.29
Говь-Алтай	Есөнбулаг	1,166,776.0	23068.8	1,062,541.6	2,252,386.4	1.93
Дорноговь	Айраг	211,545.0	14005.3	164,010.2	389,560.5	1.85
Дундговь	Хулд	283,533.0	11206.0	265,720.3	560,459.3	1.98
	Өлзийт	118,705.0	3800.9	160,374.2	282,880.1	2.38
Дархан-Уул	Шарын гол	504,699.0	47980.8	1,437,485.5	1,990,165.3	3.95
Сэлэнгэ	Мандал	3,497,150.0	45616.2	243,643.3	3,786,409.5	1.08
Төв	Заамар	1,105,407.0	12348.7	280,347.1	1,398,102.8	1.26
	Борнуур	309,269.0	2688.0	179,749.5	491,706.5	1.59
<b>Дэд нийлбэр</b>		<b>7,866,048.0</b>	<b>170,552.9</b>	<b>4,342,109</b>	<b>12,378,710.2</b>	<b>1.57</b>
Ховд	Булган	811,648.0	63487.5	717,552.1	1,592,687.6	1.96
	Үенч	276,577.0	18257.6	76,895.3	371,729.9	1.35
	Цэцэг	1,543,795.0	40117.8	1,302,375.7	2,886,288.5	1.87
Увс	Тариалан	120,180.0	4117.0	159,897.8	284,194.8	2.36
	Өмнөговь	310,490.0	20946.4	516,944.8	848,381.2	2.73
<b>Дэд нийлбэр</b>		<b>3,062,690.0</b>	<b>146,926.3</b>	<b>2,773,665.7</b>	<b>5,983,282</b>	<b>1.95</b>
<b>Нийт дүн</b>		<b>10,928,738</b>	<b>317,479</b>	<b>7,115,775</b>	<b>18,361,992.2</b>	<b>1.68</b>

Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

\* Тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй бүх албан ба албан бус бичил уурхайчид, ашигт малтмалын худалдаачдын нөлөөллийг тооцсон үр дүн.

2016 оны судалгааны дүнд гарсан эдийн засгийн хувь нэмрийг 2015 оны судалгааны үр дүнтэй харьцуулан, сүүлийн нэг жилийн хугацаанд гарсан өөрчлөлтийг дараах хүснэгтэд харьцуулан харуулав.

### Хүснэгт 2. Бичил уурхайн салбарын хувь нэмрийн өөрчлөлт

	Эдийн засгийн нийт хувь нэмэр, (мянган төгрөг)			Үржүүлэгч	
	2015 Суурь судалгаа	2016 Давтан судалгаа	Өөрчлөлт	2015	2016
<b>Нийт дүн</b>	<b>10,446,499.4</b>	<b>18,361,992.2</b>	<b>7,915,492.8</b>	<b>1.64</b>	<b>1.68</b>

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

Суурь судалгааны үр дүнгээр 10.4 тэрбум төгрөгийн хувь нэмрийн нийт зорилтот сумдад БУ болон АМХЭ –д үзүүлсэн бол давтан судалгаанд 18.3 тэрбум болж өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь 7.9 тэрбумаар өссөн гэсэн үг юм. Мөн нийт зорилтот сумдын эдийн засгийн үржүүлэгч мөн 1.68 болж өссөн байна.

# 1 Судалгааны зорилго, арга зүй

## 1.1 Судалгааны зорилго

Энэхүү судалгаа нь ТБУТ-ийн зорилтот аймгууд дахь хувираа ашигт малтмал олборлогч болон ашигт малтмалын худалдаачдын орон нутгийн эдийн засагт үзүүлж буй хувь нэмрийг тодорхойлох зорилготой. Энэ удаагийн давтан судалгаагаар 2015 онтой харьцуулахад дээрх хувь нэмэр хэрхэн өөрчлөгдсөнийг үнэлэх юм. Ингэхдээ дараах асуудлыг нарийвчлан тодруулахыг зорьсон:

1. БУЭ ба АМХЭ-дийн орон нутгийн эдийн засагт үзүүлж буй хувь нэмэр
2. БУЭ-ийн зүгээс орон нутагт хийж буй хөрөнгө оруулалтын төрөл, эзлэх хувь хэмжээ
3. БУЭ-ийн зүгээс үзүүлж буй нөлөөллийн үр шимийг хүртгэчид
4. БУЭ-ийн орлогыг төрөлжүүлэх боломж

Судалгааны дизайн нь “өмнөх болон дараах” үнэлгээний төрөлд суурилсан. Ингэснээр төслийн эхэнд суурь судалгааг хийх ба түүнээс хойш тодорхой хугацааны дараа яг ижил аргачлалаар судалгааг давтан хийж, төслийн явцад гарсан ахиц, өөрчлөлтийг үнэлнэ.

Суурь судалгаа X1	→	Давтан судалгаа X2	→	Өөрчлөлтүүд/ нөлөөлөл X2 – X1
----------------------	---	-----------------------	---	----------------------------------

## 1.2 Хамрах хүрээ, түүвэр

Бичил уурхайн салбарын талаарх үндэсний болон орон нутгийн хэмжээний хоёрдогч тоон мэдээлэл ховор тул бид тус салбарын оролцогч талуудыг түүвэрлэн, анхдагч тоон мэдээллийг хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар цуглуулсан. Тус ярилцлагыг 2016 оны 11 дүгээр сард, сонгон авсан 9 аймагт хийсэн. Эдгээр есөн аймгийг сонгохдоо ТБУТ-ийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж, суурь судалгаанд хамрагдсан сумд дээр Ховд аймгийн Булган, Үенч, Цэцэг сум, Увс аймгийн Тариалан, Өмнөговь сумыг тус тус нэмсэн бол, Говь-Алтай аймгийн Бигэр сум, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумыг хассан.

Дараах оролцогч талуудын төлөөллийг судалгаанд хамруулсан:

5. Бичил уурхайчид;
6. Ашигт малтмалын худалдаачид;
7. Орон нутгийн бизнес эрхлэгчид;
8. Малчид;
9. Орон нутгийн бичил уурхайчдын ТББ-ууд;
10. Орон нутгийн төрийн байгууллагын ажилтнууд;

Судалгаанд оролцогчдын тоог орон нутаг ба төрлөөр нь дараах хүснэгтэд харуулав.

## Хүснэгт 2 Судалгаанд хамрагдагсад

Аймаг	Сум	Албан БУЭ	Албан бус БУЭ	АМХЭ	БУ-н ТББ	Т байгууллагын ажилтан	Бизнес эрхлэгч	Малчин	Нийт
Баянхонгор	Баян-Овоо	5	4	2	1	1	2	3	18
	Бөмбөгөр	5	4	2	1	1	2	3	18
Говь-Алтай	Есөнбулаг	10	9	4	2	1	4	6	36
Дорноговь	Айраг	10	10	2	2	1	4	6	35
Дундговь	Хулд	8	2	1	1	1	2	3	18
	Өлзийт	10	0	1	1	1	2	3	18
Дархан	Шарын гол	4	4	2	1	1	2	4	18
Сэлэнгэ	Мандал	5	4	1	1	1	2	4	18
Төв	Заамар	5	5	2	1	1	2	3	19
	Борнуур	5	4	2	1	1	3	3	19
Ховд	Булган	5	0	2	1	1	1	2	12
	Үенч	2	3	2	1	1	1	2	12
	Цэцэг	3	3	1	0	1	2	2	12
Увс	Тариалан	5	4	2	1	1	2	3	18
	Өмнөговь	4	5	2	1	1	2	3	18
<b>Нийт</b>		<b>86</b>	<b>61</b>	<b>28</b>	<b>16</b>	<b>15</b>	<b>33</b>	<b>50</b>	<b>289</b>

### Судалгаанд хамрагдагчдыг сонгохдоо дараах арга зүйг баримталсан:

- )] Бичил уурхай эрхлэгчид. Тухайн сумын бичил уурхай дээр үйл ажиллагаа явуулж буй хүмүүсээс санамсаргүй сонгосон;
- )] Ашигт малтмалын худалдаачид. Орон нутгийн ТББ-уудын тусламжтайгаар ашигт малтмалын худалдаа эрхлэгчидтэй холбоо тогтоож, ярилцлагад хамруулсан.
- )] Орон нутгийн бизнес эрхлэгчид. Бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газарт болон түүнтэй ойролцоо бизнес эрхэлж буй иргэдээс сонгон ярилцлагад хамруулсан. Судалгаанд ихэвчлэн жижиг дэлгүүр, худалдаа эрхлэгчид хамрагдсан.
- )] Малчид. Судлаачид нь уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газруудад хамгийн ойр амьдарч буй малчдыг сонгохоор хичээсэн;
- )] Бичил уурхай эрхлэгчдийн ТББ. Сум бүрээс нэг ТББ-ыг сонгосон. Тэдгээр ТББ-ын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Монголын Бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбооноос (МБУНДХ) авсан.
- )] Төрийн байгууллагын ажилтнууд. Сумын ЗДТГ-т судалгааны танилцуулга, шаардлагатай мэдээллийг өгч, судалгаанд хамрагдах төрийн албан хаагчдыг томилуулсан.

### 1.3 Судалгааны үе шат

Судалгааны ажил дараах үе шатыг хамарсан. Үүнд:

- ) Хэрэглэгдэхүүн боловсруулах. Суурь судалгаанд ашигласан ярилцлагын асуултуудыг захиалагчтай зөвшилцөн, шинэчлэж сайжруулсан.
- ) Бичиг баримтын судалгаа. Орон нутаг дахь бичил уурхай эрхлэгчдийн тоог тогтоох, тэдний төлж буй татвар, төлбөр хураамжийн хэмжээг тооцохын тулд орон нутгийн захиргаа болон бичил уурхай эрхлэгчдийн ТББ-уудаас нэмэлт мэдээлэл цуглуулж, баримт бичгийн шинжилгээ хийв.
- ) Анхдагч мэдээлэл цуглуулах. Урьдчилан боловсруулсан төлөвлөгөө, аргачлалын дагуу бичил уурхайн оролцогч талуудаас ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан.
- ) Дүн шинжилгээ хийх. Бичиг баримтын судалгаа ба цуглуулсан анхдагч мэдээлэлд үндэслэн бичил уурхайн салбарын орон нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөөг сум бүрээр, нөлөөллийн төрөл бүрээр нарийвчлан үнэлсэн. Үр дүнг суурь судалгааны үр дүнтэй харьцуулсан.
- ) Тайлан бэлтгэх. Судалгааны үр дүнг нэгтгэн харуулсан тайланг Англи, Монгол хэл дээр бэлтгэсэн
- ) Танилцуулга хийх. Судалгааны үр дүнг ТБУТ-ийн хүрээнд зохиогдох хурал, уулзалтад танилцуулах

### 1.4 Дүн шинжилгээний хүрээ


**Эдийн засгийн нөлөөлөл**

Албан болон албан бус БУЭ-дийн үйл ажиллагааны эдийн засгийн үр нөлөөг үнэлэхдээ эдийн засгийн ямар нэг салбарын нийт эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцдог стандарт аргачлалыг ашигласан. Тухайлбал, бид бичил уурхайн салбар тухайн орон нутгийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг дараах хүрээнд нарийвчлан тооцсон.

- ) **Шууд нөлөөлөл** – Орон нутгийн захиргааны төвлөрүүлсэн орлого, БУЭ ба АМХ-дийн орлого, бичил уурхайчдад төлж буй цалин хөлс, нийтэд хандсан үйл ажиллагаанд зарцуулж буй бусад зардал;
- ) **Шууд бус нөлөөлөл** – БУЭ, АМХЭ-дтэй хийж буй бизнесийн үйл ажиллагааныхаа үр дүнд ханган нийлүүлэгчдийн (жижиг дунд бизнес эрхлэгчид, малчид) олж буй ашиг, төлж буй татвар, бий болгож буй ажлын байр;
- ) **Дам нөлөөлөл** – Ажилтнууд, ханган нийлүүлэгчид болон бусад тал өөрийн орлогоосоо зарцуулах замаар орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмэр, БУЭ, АМХЭ, тэдний ханган нийлүүлэгчдийн татварын орлогоор хийж буй төрийн худалдан авалт.

Шинжилгээний хүрээг дараах дүрс 1-т тоймлон харуулав.

### Дүрс 1 Мэдээлэл боловсруулах арга зүй



#### Нэмэлт мэдээлэл

Үүнээс гадна IRIM хүрээлэн доор дурдсан нэмэлт мэдээллүүдийг боловсруулсан:

#### Шууд нөлөөлөл:

- )] Албан болон албан бус БУЭ-ийн тоо;
- )] БУЭ-дйн жендэрийн харьцаа;
- )] БУ болон АМХЭ-дийн гэр бүлийн бусад гишүүдийн хөдөлмөр эрхлэлт
- )] АМ-ын олборлолт болон борлуулалтын үйл ажиллагааны улирлын өөрчлөлт;
- )] БУЭ-дийн мэдээлсэн ашигт малтмалын үнэ;
- )] АМХ-ын олж буй ашиг;
- )] Олон нийтэд зориулсан хөрөнгө оруулалт.

#### Шууд бус нөлөөлөл:

- )] Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бий болгож буй дагалдах ажлын байрууд;
- )] Бизнесийн үйл ажиллагаа, БУЭ-тэй хийх худалдааны улирлын өөрчлөлт;
- )] Уул уурхайн үйл ажиллагаанаас хамаарсан орлогын өөрчлөлт;
- )] БУЭ-дийн худалдан авалтын хэлбэр (бэлэн мөнгө, зээл гэх мэт).

#### Дам нөлөөлөл:

- )] БУЭ, АМХЭ, малчдын өрхийн түвшний зардал;

## 1.5 Судалгааны хязгаарлалтууд


Судалгааны хамрах хүрээтэй холбоотойгоор энэхүү судалгааны үр дүн дараах байдлаар хязгаарлагдаж байгааг дурдах нь зүйтэй. Үүнд:

- )] Судалгаа нь зөвхөн ТБУТ-ийн зорилтот сумдыг хамарсан тул БУ-н салбарын аймгийн ба улсын эдийн засагт үзүүлж буй хувь нэмрийг бүрэн тодорхойлж чадахгүй. Уг хувь нэмрийг зөвхөн зорилтот сумдын түвшинд тооцсон.
- )] Судалгааны ажлын төсвийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан БУЭ-д, ашигт малтмалын худалдаачид, орон нутгийн жижиг бизнес эрхлэгчид, малчдыг сум бүрээс цөөн тоогоор хамруулсан. Иймээс тус салбарын эдийн засгийн хувь нэмрийг ерөнхий нийлбэр дүнгээр үнэлэх нь алдаа багатай болно. Харин гол үр дүнгүүдийг аймаг, сумаар нь нарийвчлан харьцуулахад алдаа их гарна.
- )] БУ-н салбарын хувь нэмрийг тооцохдоо тухайн орон нутаг дахь нийт БУЭ-д, АМХЭ-дийн тоог сумын захиргаа, БУ-н ТББ-аас авсан. Гэхдээ ялангуяа албан бус БУЭ-д АМХЭ-дийн тоо тэр бүр найдвартай байж чадахгүйг анхаарах хэрэгтэй.
- )] БУ-н салбар тухайн сумын эдийн засгийн өсөлтөд яг хэдэн хувийн хувь нэмэр оруулж байгааг нарийн тооцох боломжгүй. Үүнийг тооцоход шаардлагатай нэмэлт мэдээллийг судалгааны явцад Үндэсний статистикийн хороо болон орон нутгийн захиргаанаас тодруулахыг оролдсон боловч хангалттай мэдээлэл олдоогүй. ҮСХ-ны хувьд одоогоор сумын түвшний эдийн засгийн өсөлт тооцдоггүй. Орон нутгийн захиргааны хувьд сумын эдийн засгийн салбаруудын үйлдвэрлэлийн статистик бүртгэл байдаггүй. Гэхдээ энэхүү үнэлгээ БУ-н салбар тухайн орон нутгийн эдийн засагт ямар хувь нэмэр оруулж байгааг мөнгөн дүнгээр хэмжиж буйгаараа чухал ач холбогдолтой юм.

## 2 ЭДИЙН ЗАСГИЙН ШУУД НӨЛӨӨ

Судалгааны энэ хэсэгт албан ба албан бус бичил үүрхэй эрхлэгчид болон ашигт малтмалын худалдаачдын орон нутгийн эдийн засагт оруулж байгаа шууд хувь нэмрийг тооцлоо. Эдийн засгийн шууд нөлөөг бичил үүрхэй эрхлэгчид болон ашигт малтмалын худалдаачдын ажил эрхлэлттэй холбоотой гаргасан зардал, олборлолт болон ашигт малтмал худалдаалахтай холбоотой худалдан авалтын зардал, орон нутагт төлсөн татвар, хураамж, орон нутаг болон олон нийтийн үйл ажиллагаанд зориулсан хөрөнгө оруулалтын зардлын нийлбэрээр тооцно. Доорх зурагт эдийн засгийн шууд нөлөөг тооцох бүрэлдэхүүн хэсгүүд болон тэдгээрийг тооцоход шаардагдах хүчин зүйлсийг нэгтгэн харууллаа.

**Дүрс 2 Эдийн засгийн шууд нөлөө ба түүний бүрэлдэхүүн хэсгүүд**



Эдийн засгийн шууд нөлөөний бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг дараах дэд бүлгүүдэд авч үзнэ.



## 2.1 Ажил эрхлэлт

Ажил эрхлэлтээс үүдэлтэй эдийн засгийн шууд нөлөө нь бичил уурхай эрхлэгчид болон АМХЭ-дийн бий болгосон ажлын байрны тоо болон тэдгээрийн ажил эрхлэлтэд гаргасан зардлаар хэмжигддэг. Гэхдээ БУЭ болон АМХЭ нь хувиараа хөдөлмөр эрхлэгч учраас тэр бүр бусдыг ажиллуулж, цалингийн зардал гаргаад байдаггүй. Иймээс ажил эрхлэлтэд гаргасан зардлыг БУЭ болон АМХЭ-дийн сарын орлого болон тэдний төлсөн цалингийн зардлаар (хэрвээ хэн нэгнийг цалинтайгаар ажиллуулдаг бол) төлөөлүүлэн авч үзлээ.

### 2.1.1 Бичил уурхайчид болон ашигт малталын худалдаачдын бий болгосон ажлын байрны тоо

Судалгаанд хамрагдсан 15 сумын хувьд бичил уурхайн ТББ-уудын өгсөн мэдээлэлд үндэслэн БУЭ болон АМХЭ-дийн бий болгосон ажлын байрны тоог гаргалаа. 2016 оны 11-р сарын байдлаар 15 суманд нийтдээ 3169 албан бичил уурхай эрхлэгч, 5745 албан бус бичил уурхай эрхлэгч, 74 ашигт малтмалын худалдаа эрхлэгч хөдөлмөр эрхэлж байна. Дараах хүснэгтэнд бичил уурхайчид болон ашигт малтмалын худалдаачдын тоог 2015, 2016 оны хувьд нэгтгэн харуулав.

**Хүснэгт 3 Албан ба албан бус бичил уурхай эрхлэгчид болон АМХЭ-дийн тоо, суурь ба давтан судалгаа**

Байршил		Суурь судалгаа-2015				Давтан судалгаа- 2016				Суурь-2015	Давтан-2016
		Албан БУЭ- дийн тоо	Албан бус БУЭ- дийн тоо	Нийт БУЭ- ийн тоо	АМХЭ- дийн тоо	Албан БУЭ- дийн тоо	Албан бус БУЭ-дийн тоо	Нийт БУЭ- ийн тоо	АМХЭ- дийн тоо	Нийт БУЭ болон АМХЭ-ийн тоо	Нийт БУЭ болон АМХЭ-ийн тоо
Аймаг	Сум										
Баянхонгор	Баян-Овоо	550	280	830	2	525	500	1025	2	832	1027
	Бөмбөгөр	45	50	95	12	45	45	90	8	107	98
Говь-Алтай	Есөнбулаг	400	750	1,150	5	400	650	1050	7	1,155	1,057
Дорноговь	Айраг	125	40	165	4	125	40	165	4	169	169
Дундговь	Хулд	350	300	650	1	380	0	380	1	651	381
	Өлзийт	280	108	388	4	120	0	120	1	392	121
Дархан-Уул	Шарын гол	346	500	846	5	300	400	700	6	851	706
Сэлэнгэ	Мандал	500	400	900	4	500	2500	3000	5	904	3,005
	Орхон туул(б)	120	180	300	1	-	-	-	-	301	-
Төв	Заамар	168	100	268	20	168	200	368	20	288	388
	Борнуур	83	65	148	4	126	180	306	2	152	308
<b>Дэд нийлбэр<sup>1</sup></b>		<b>2,967</b>	<b>2,773</b>	<b>5,740</b>	<b>62</b>	<b>2,689</b>	<b>4,515</b>	<b>7204</b>	<b>56</b>	<b>5,802</b>	<b>7,260</b>
Ховд	Булган(а)	-	-	-	-	100	250	350	5	-	355
	Үенч(а)	-	-	-	-	25	150	175	1	-	176
	Цэцэг(а)	-	-	-	-	155	550	705	3	-	708
Увс	Тариалан(а)	-	-	-	-	100	50	150	4	-	154
	Өмнөговь(а)	-	-	-	-	100	230	330	5	-	335
<b>Дэд нийлбэр<sup>2</sup></b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>480</b>	<b>1,230</b>	<b>1710</b>	<b>18</b>	<b>-</b>	<b>1,728</b>
<b>Нийт дүн</b>		<b>2,967</b>	<b>2,773</b>	<b>5,740</b>	<b>62</b>	<b>3,169</b>	<b>5,745</b>	<b>8,914</b>	<b>74</b>	<b>5,802</b>	<b>8,988</b>

Эх сурвалж: БУ-н ТББ-уудаас авсан судалгааны үр дүн

Тайлбар: (а) –Давтан судалгаанд шинээр нэмэгдсэн сумууд, (б)-Давтан судалгаанд хамрагдаагүй сум


1 Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд

2 Давтан судалгаанд шинээр нэмэгдсэн сумдын хувьд

2015 оны суурь судалгаанд хамрагдсан сумдтай<sup>3</sup> харьцуулахад бичил уурхайчид болон ашигт малтмалын худалдаачдын тоо эдгээр суманд нийтдээ 1759-өөр өссөн байна. Бичил уурхайчид болон ашигт малтмалын худалдаачдын тоо 5 суманд буурч, 4 суманд өссөн бол нэг суманд өөрчлөгдөөгүй байна (Дүрс 3). Хамгийн их өөрчлөлт Мандал суманд гарсан бөгөөд Гацууртын орд илэрсэнтэй холбоотойгоор албан бүс бичил уурхайчдын тоо эрс нэмэгдэж 2500-д хүрчээ.

Давтан судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумын хувьд 1710 БУЭ болон 18 АМХЭ үйл ажиллагаагаа явуулж байна.

**Дүрс 3 Нийт БУЭ болон АМХЭ-дийн тоо, суурь ба давтан судалгаа**



Эх сурвалж: БУ-н ТББ-үүдээс авсан судалгааны үр дүн

2015 ба 2016 оны БУЭ-дийн тооны хувьд мэдэгдэхүйц зөрүү үүссэн сумдын хувьд ТББ-уудын зүгээс дараах тайлбарыг өгсөн. Үүнд:

- )] **Дундговь аймгийн Хулд сум:** Хулд сумын ТББ-ын үйл ажиллагаа сайжирч, өргөжиж байгаагаас үүдэн гишүүдийн тоо нэмэгдэж байна. Албан бүс статустай байсан бичил уурхай эрхлэгчид ТББ-д элсэж байгаа ажээ. Түүнчлэн орон нутгийн удирдлага, ТББ, иргэдийн зүгээс албан бусаар бичил уурхай эрхлэхийг хүчтэй эсэргүүцсэний үр дүнд албан бүс бичил уурхай эрхлэгчид үйл ажиллагаа явуулахгүй байгаа ажээ.
- )] **Дундговь аймгийн Өлзийт сум:** Өнгөрсөн оны хувьд тогтмол олборлолт хийдэггүй иргэдийг ТББ-ын гишүүнээр бүртгэж авсан байсан. Харин одоо тогтвортой ажиллаж байгаа бичил уурхайчид л ТББ-д бүртгэлтэй үлдсэн байна. Иймээс бүртгэлтэй БУЭ-дийн тоо эрс буурсан. Түүнчлэн орон нутгийн удирдлага, ТББ, иргэдийн зүгээс албан бусаар бичил уурхай эрхлэхийг хүчтэй эсэргүүцсэний үр дүнд албан бүс бичил уурхай эрхлэгчид үйл ажиллагаа явуурахгүй байгаа ажээ.

<sup>3</sup> Баян-Овоо, Бөмбөгөр, Есөнбулаг, Айраг, Хулд, Өлзийт, Мандал, Шарын гол, Заамар, Борнуур (Орхонтуул сум давтан судалгаанд хамрагдаагүй тул хасч тооцов)

- )] **Сэлэнгэ аймгийн Мандал сум:** Суурь судалгаатай харьцуулахад албан БУЭ-дийн тоо өөрчлөгдөөгүй ч Гацууртын орд илэрсэнтэй холбоотойгоор албан бус БУЭ-дийн тоо эрс нэмэгдэж 2500-д хүрээд байна.
- )] **Төв аймгийн Борнуур сум:** 2015 оны 11-дүгээр сард ТББ-аа дахин шинэчилсэн. Үүнтэй холбоотойгоор бичил уурхай эрхлэгчдээ дахин бүртгэж авсан бөгөөд үүний үр дүнд бүртгэлтэй БУЭ-дийн тоо өссөн байна.

Хүснэгт 5-аас дүгнэхэд 2016 оны байдлаар судалгаанд хамрагдсан 15 сумын хувьд бичил уурхайчид болон ашигт малтмалын худалдаачид нийтдээ 8988 ажлын байрыг бий болгосон хэмээн дүгнэж болохоор байна. Гэхдээ суурь судалгаанд хамрагдсан 10 сумтай харьцуулахад 2016 онд эдгээр суманд нийтдээ албан БУЭ-дийн тоо 158-аар буурч, харин албан бус БУЭ-дийн тоо 1922-оор өссөн байна. Түүнчлэн АМХ-дийн тоо 5-аар буурсан байна. Иймд суурь харьцуулахад эдгээр суманд БУ-тай холбоотой ажлын байр 1759-өөр өссөн гэж дүгнэж болох юм. Дараах хүснэгтэнд албан ба албан бус бичил уурхайчид болон ашигт малтмалын худалдаачдын тооны өөрчлөлтийг сум тус бүрээр харууллаа. Албан бичил уурхай эрхлэгчдийн хувьд Борнуур суманд хамгийн олноор буюу 43 албан БУЭ нэмэгдсэн бол Өлзийт суманд хамгийн ихээр буюу 160-аар буурсан байна. Албан бус БУЭ-дийн хувьд Мандал суманд хамгийн олон буюу 2100 албан бус БУЭ нэмэгдсэн бол Хулдад хамгийн олноор буюу 300-аар буурчээ.

#### **Хүснэгт 4 Албан ба албан бус БУЭ-дийн тооны өөрчлөлт, суурь ба давтан судалгааны зөрүүгээр**

Аймаг	Сум	Албан БУЭ	Албан бус БУЭ	АМХЭ	Нийт өөрчлөлт
Баянхонгор	Баян-Овоо	-25	220	0	195
	Бөмбөгөр	0	-5	-4	-9
Говь-Алтай	Есөнбулаг	0	-100	2	-98
Дорноговь	Айраг	0	0	0	0
Дундговь	Хулд	30	-300	0	-270
	Өлзийт	-160	-108	-3	-271
Сэлэнгэ	Мандал	0	2100	1	2101
	Шарын гол	-46	-100	1	-145
Төв	Заамар	0	100	0	100
	Борнуур	43	115	-2	156
<b>Нийт өөрчлөлт</b>		<b>-158</b>	<b>1922</b>	<b>-5</b>	<b>1759</b>

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

**БУЭ болон АМХЭ өрхийн ажил эрхлэлт.** Судалгаанд оролцсон БУЭ өрхүүдэд нийт 614 хүн амьдарч байгаа бөгөөд эдгээрийн 372 буюу 61% нь хөдөлмөрийн насны хүмүүс ажээ. Нийт хөдөлмөрийн насны хүмүүсийн 267 буюу 72% нь одоогоор ажил эрхэлж байна.






Судалгаанд оролцсон 147 БУЭ өрхийн 50%-д хөдөлмөрийн насны бүх гишүүд нь ажил эрхэлж байгаа бол харин 36%-д хөдөлмөрийн насны 1 гишүүн нь, 10%-д хөдөлмөрийн насны 2 гишүүн нь, 3%-д хөдөлмөрийн насны 3 гишүүн нь, 1%-д нь хөдөлмөрийн насны 4 гишүүн нь ажил эрхлээгүй байна. Дараах хүснэгтэнд өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн тоо болон ажил эрхэлдэг гишүүдийн тоог харьцуулав.

### Хүснэгт 5 БУЭ өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн тоо ба ажил эрхэлдэг гишүүдийн тоо (ТХ=147)

Хөдөлмөрийн насны гишүүдийн тоо	Ажил эрхэлдэг гишүүдийн тоо				Нийт	
	1	2	3	4		
1	7				7	5%
2	29	57			86	59%
3	6	18	8		32	22%
4	2	7	5	1	15	10%
5	0	3	2	0	5	3%
6	0	2	0	0	2	1%
<b>Нийт</b>	<b>44</b>	<b>87</b>	<b>15</b>	<b>1</b>	<b>147</b>	<b>100%</b>
	<b>30%</b>	<b>59%</b>	<b>10%</b>	<b>1%</b>		

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


#### Тайлбар:

	Өрхийн хөдөлмөрийн насны бүх гишүүд нь ажил эрхэлдэг
	Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдээс 1 нь ажил эрхэлдэггүй
	Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдээс 2 нь ажил эрхэлдэггүй
	Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдээс 3 нь ажил эрхэлдэггүй
	Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдээс 4 нь ажил эрхэлдэггүй

Хүснэгт 6-аас харахад БУЭ өрхийн 30%-д нэг гишүүн, 59%-д хоёр гишүүн, 10%-д гурван гишүүн, 1%-д нь дөрвөн гишүүн ажил эрхэлдэг ажээ. БУЭ өрхөд дунджаар 1.8 хүн ажил эрхэлж байгаа бол хамгийн ихдээ 4, хамгийн багадаа 1 хүн ажил эрхэлж байна.

Эдгээр ажил эрхэлдэг гишүүдийн хичнээн нь ямар төрлийн ажил эрхэлдэг болохыг тэр дундаа өрхийн гишүүдийн хэд нь БУ эрхэлдэг болохыг авч үзье. Нийт ажил эрхэлж буй гишүүдийн 80% буюу 213 нь БУ эрхэлдэг бөгөөд тэдгээрийн 147 нь ярилцлага өгсөн бичил уурхай эрхлэгчид бол үлдсэн 66 нь бичил уурхай эрхэлдэг гэр бүлийн гишүүд ажээ. Өөрөөр хэлбэл, нийт судалгаанд оролцсон өрхүүдэд дунджаар 1.5 БУЭ ноогдож байна.

#### Дүрс 4 БУЭ өрхүүдийн ажил эрхэлдэг гишүүдийн эрхэлдэг ажил




Харин бусад ажил эрхэлж буй гишүүдийн 14% нь төрийн болон хувийн байгууллагад ажилладаг, 3% нь хувийн бизнес эрхэлдэг, 2% нь мал аж ахуй эрхэлдэг ажээ.

Олборлолтонд оролцдог өрх-ийн гишүүдийн олонх нь хоол хүнсээр хангах, хамт олборлолт хийдэг байна.

Судалгаанд оролцсон АМХЭ өрхүүдийн хувьд нийт 113 хүн амьдарч байгаа бөгөөд эдгээрийн 75 буюу 66% нь хөдөлмөрийн насны хүмүүс ажээ. Нийт хөдөлмөрийн насны хүмүүсийн 37 буюу 49% нь одоогоор ажил эрхэлж байна. АМХЭ өрхийн 71%-д нэг гишүүн, 25%-д хоёр гишүүн, 4%-д гурван гишүүн ажил эрхэлдэг ажээ. АМХЭ өрхөд дунджаар 1.3 хүн ажил эрхэлж байгаа бол хамгийн ихдээ 3, хамгийн багадаа 1 хүн ажил эрхэлж байна.

Эдгээр ажил эрхэлдэг гишүүдийн хичнээн нь ямар төрлийн ажил эрхэлдэг болохыг тэр дундаа өрхийн гишүүдийн хэд нь АМХ эрхэлдэг болохыг авч үзье.

**Дүрс 5 АМХЭ өрхүүдийн ажил эрхэлдэг гишүүдийн эрхэлдэг ажил**




Нийт ажил эрхэлж буй гишүүдийн 51% нь АМХ эрхэлдэг, 22% нь хувийн бизнес эрхэлдэг, 19% нь төрийн болон хувийн байгууллагад ажилладаг ажээ.

Нийтэд нь дүгнэхэд судалгаанд нийтдээ 147 БУЭ болон 28 АМХЭ-дийг хамруулсан ч 147 БУЭ-ийн гэр бүлд дахин 66 хүн БУ эрхэлж байна. Иймд нийтдээ 241 хүн энэ

салбарт ажиллаж байна.

**Нийт ажилласан жил, БУ болон АМХ эрхэлсэн хугацаа.** Судалгаанд хамрагдсан БУЭ-дийн 41% нь 10 хүртэлх жил, 37% нь 11-ээс 20 жил, 22% нь 20-иос дээш жил хөдөлмөр эрхэлж байгаа ажээ. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан БУЭ-д дунджаар 14 жил хөдөлмөр эрхэлж байгаа бол хамгийн ихдээ 34 жил, хамгийн багадаа 1 жил хөдөлмөр эрхэлж байна. Нийт ажилласан жилийг нь БУ эрхэлсэн хугацаатай нь харьцуулахад судалгаанд оролцсон нийт БУЭ-дийн 18% нь нийт ажилласан жилийнхээ ¼ хүртэлх хугацааг, 31% нь ½ хүртэлх хугацааг, 17% нь ¾ хүртэлх хугацааг, 34% нь нийт ажилласан жилийнхээ бараг бүхий л хугацааг ашигт малтмал олборлоход зориулсан байна. Тэр дундаа эдгээрийн 26% нь бичил уурхайгаас огт өөр ажил эрхэлж байгаагүй аж. Дараах зурагт судалгаанд оролцсон БУЭ-дийн нийт ажилласан жил болон БУ эрхэлсэн жилийг үзүүлэв.

### Дүрс 6 БУЭ-дийн нийт ажилласан жил ба бичил уурхай эрхэлсэн хугацаа (ТХ=147)




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан БУЭ-д дунджаар 8 жил БУ эрхэлж байгаа бол хамгийн ихдээ 20 жил, хамгийн багадаа 1 жил БУ эрхэлж байна. Түүнчлэн нийт БУЭ-дийн 47% нь 1-5 жил, 27% нь 6-10 жил, 16% нь 11-15 жил, 11% нь 16-20 жил БУ эрхэлж байна.

Судалгаанд хамрагдсан АМХЭ-дийн хувьд 31% нь 10 хүртэлх жил, 36% нь 11-ээс 20 жил, 25% нь 20-иос дээш жил хөдөлмөр эрхэлж байгаа ажээ. Түүнчлэн судалгаанд оролцсон АМХЭ-д дунджаар 16 жил, хамгийн ихдээ 35 жил, хамгийн багадаа 2 жил хөдөлмөр эрхэлж байна. Нийт ажилласан жилийг нь АМХ эрхэлсэн хугацаатай нь харьцуулахад судалгаанд оролцсон нийт АМХЭ-дийн 29% нь нийт ажилласан жилийнхээ ¼ хүртэлх хугацааг, 32% нь ½ хүртэлх хугацааг, 11% нь ¾ хүртэлх хугацааг, 29% нь нийт ажилласан жилийнхээ бараг бүхий л хугацааг АМХ хийхэд зориулсан байна. Тэр дундаа эдгээрийн 18% нь АМХ-аас өөр ажил эрхэлж байгаагүй аж. Дараах зурагт судалгаанд оролцсон АМХЭ-дийн нийт ажилласан жил болон АМХ хийсэн жилийг үзүүлэв.

### Дүрс 7 АМХЭ-дийн нийт ажилласан жил ба АМХ эрхэлсэн хугацаа (ТХ=28)



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Эх

Судалгаанд хамрагдсан ашигт малтмалын худалдаачид дунджаар 6 жил, хамгийн ихдээ 16 жил, хамгийн багадаа 1 жил АМХ хийж байгаа ажээ. Түүнчлэн АМХЭ-дийн 54% нь 1-5 жил, 32% нь 6-10 жил, 14% нь 11-16 жил ашигт малтмалын худалдаа эрхэлж байна. Дараах хүснэгтэнд БУЭ болон АМХЭ-дийн нийт ажилласан жил ба тухайн салбарт үйл ажиллагаа явуулсан хугацааны тодорхойлох статистикуудыг нэгтгэн харуулав.

**Хүснэгт 6 Нийт ажилласан жил, БУ болон АМХ эрхэлсэн хугацааны тодорхойлох статистикууд**

Тодорхойлох статистик	Бичил үүрхэй эрхлэгч (ТХ=147)		Ашигт малтмалын худалдаа эрхлэгч (ТХ=28)	
	Нийт ажилласан жил	БУ эрхэлсэн жил	Нийт ажилласан жил	АМХ эрхэлсэн жил
Дундаж	14	8	16	6
Медиан	13	6	16	5
Хамгийн их давтагдсан утга	10	5	10	5
Хамгийн их утга	34	20	35	16
Хамгийн бага утга	1	1	2	1
1-5 жил	13%	47%	11%	54%
6-10 жил	29%	27%	28%	32%
11-15 жил	16%	16%	11%	14%
16-20 жил	22%	11%	25%	-
20+ жил	22%	-	25%	-

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

**БУЭ болон АМХЭ-дийн 2016 онд үйл ажиллагаагаа явуулсан хугацаа.** Судалгаанд оролцсон Бичил үүрхэй эрхлэгчид 2016 онд дунджаар 5 сар олборлолт хийсэн бол хамгийн ихдээ 12 сар олборлолт хийжээ. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 6%<sup>4</sup> нь 2016 онд огт олборлолт хийгээгүй байна. Албан ба албан бусаар нь ангилан үзэхэд албан БУЭ-д дунджаар 4.6 сар олборлолт хийсэн бол албан бус БУЭ-д 5.2 сар олборлолт хийжээ.

Нийт БУЭ-дийн 42% нь 1-3 сарын турш, 26% нь 4-6 сарын турш, 8% нь 7-9 сарын турш, 18% нь жилд 10-12 сарын турш олборлолт хийжээ. Дүрс 8-д албан ба албан бус БУЭ-дийн 2016 онд олборлолт хийсэн нийт хугацааг харьцуулан үзүүлэв.

---


4 Нийт 9 БУЭ байгаа бөгөөд эдгээрийн 6 нь албан БУЭ, 3 нь албан бус БУЭ байна.



8

-

, 2016




Эндээс албан ба албан бус БУЭ-ээс үл хамааран 70 орчим хувь нь жилд 6 хүртэл сар олборлолт хийдэг гэж дүгнэж болохоор байна.

Судалгаанд хамрагдсан АМХЭ-дийн хувьд 2016 онд дунджаар 5.5 сар АМ-ын арилжаагаа хийсэн бол хамгийн ихдээ 12 сарын турш АМХ-гаа

борлуулжээ. Харин хоёр АМХЭ 2016 онд ашигт малтмал огт борлуулаагүй байна. АМХЭ-дийн 32% нь 1-3 сарын турш, 25% нь 4-5 сарын турш, 18% нь 7-9 сарын турш, 18% нь 12 сарын турш ашигт малтмал борлуулсан байна.

Судалгаанд хамрагдсан БУЭ-дийн 55% нь байнгын бичил үүрхай эрхэлдэг, 35% нь улирлын чанартайгаар БУ эрхэлдэг<sup>5</sup>, 22% нь гэнэтийн цугларалтаар буюу нөөц олдсон үед л олборлолт хийдэг гэсэн бол үлдсэн 3% нь ажлынхаа хажуугаар болон амралтаараа л олборлолт хийдэг гэжээ. Дараах зурагт БУЭ-д ямар тохиолдолд олборлолт хийдгийг албан ба албан бус БУЭ-дээр харьцуулан харуулав.

**Дүрс 9 Албан ба албан бус БУЭ-дийн олборлолт хийдэг тохиолдол**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


<sup>5</sup> Улирлын чанартай бичил үүрхай эрхэлдэг хүмүүсийн олонх буюу 57% нь зун, 23% нь хавар, 20% нь өвлийн улиралд олборлолт хийдэг ажээ.

Дүрс 9-аас дүгнэхэд албан ба албан бус БУЭ-дийн олборлолт хийдэг тохиолдолд онцын ялгаа байхгүй ч албан БУЭ-дийн олборлолт хийх хандлага арай илүү тогтворжсон бол албан бус БУЭ-д гэнэтийн тохиолдлуудад илүү идэвхтэй үйл ажиллагаагаа явуулах хандлагатай ажээ.

Судалгаанд хамрагдсан АМХЭ-дийн хувьд 34% нь байнгын АМХ эрхэлдэг, 47% нь улирлын чанартайгаар АМХ хийдэг, 13% нь гэнэтийн цугларалтаар буюу нөөц олдсон үед л АМХ хийдэг, 6% нь ажлынхаа хажуугаар АМХ хийдэг гэжээ.

АМ олборлох болон худалдах ажиллагаа нь улирлаас нэлээдгүй хамааралтай байдаг. БУ-д болон ашигт малтмалын худалдаачид үйл ажиллагаанд нь улирал хэрхэн нөлөөлдгийг үнэлсэн бөгөөд үүнийг Дүрс 10-т харуулав. Энэхүү үнэлгээнээс дүгнэхэд БУЭ болон АМХЭ-дийн үйл ажиллагааны улирлын мөчлөг бараг давхцаж байгаа бөгөөд ашигт малтмал олборлох, худалдах үндсэн үйл ажиллагаа зун эрчимжиж, намар тогтворжиж, өвөл зогсож, хавар саардаг гэсэн дүр зураг ажиглагдаж байна.


**Дүрс 10 БУ-н олборлолт ба АМХ-ны улирлын мөчлөг/Дүрс12/**




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Олборлолт саарсан эсвэл зогссон үед БУЭ-дийн тал нь ямар нэгэн ажил эрхэлдэггүй бол үлдсэн 50% нь төрөл бүрийн ажлууд хийдэг ажээ. Тухайлбал, 20 гаруй хувь нь хувийн бизнес эрхэлдэг, 10% нь мал малладаг, нөгөө 10% нь өөр газар ашигт малтмал олборлохоор явдаг гэжээ. АМХЭ-дийн хувьд энэ үед 32% нь ажил эрхэлдэггүй бол 57% нь хувийн бизнес эрхэлдэг ажээ.

**Дүрс 11 Олборлолт саарсан, эсвэл зогссон үед БУЭ-дийн эрхэлдэг ажлууд**




**Дүрс 12 Олборлолт саарсан, эсвэл зогссон үед АМХЭ-дийн эрхэлдэг ажлууд**




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

**БУЭ болон АМХЭ-дийн давхар ажил эрхлэлт.** Судалгаанд оролцсон БУЭ-дийн 26% нь давхар ажил эрхэлдэг, харин 74% нь давхар ажил эрхэлдэггүй ажээ. Албан ба албан бусаар ангилбал мөн л ангилал түс бүрийн 26% нь давхар ажил эрхэлдэг ажээ. Харин АМХЭ-дийн хувьд 64% нь давхар ажил эрхэлдэг бол үлдсэн 36% нь ямар нэгэн давхар ажил эрхэлдэггүй аж. Дараах зурагт давхар ажил эрхэлдэг БУЭ болон АМХЭ-дийн эрхэлдэг ажлыг үзүүлээ. Эдгээр БУЭ болон АМХЭ голдуу хувийн бизнес эрхэлдэг ажээ.

**Дүрс 13 Давхар ажил эрхэлдэг БУЭ-чдийн эрхэлдэг ажлууд (ТХ=38)**



**Дүрс 14 Давхар ажил эрхэлдэг АМХЭ-дийн эрхэлдэг ажлууд (ТХ=18)**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


## 2.1.2 Бичил уурхайн үйл ажиллагаанаас олох орлого

### **Бичил уурхай эрхлэгчдийн орлого**

БУЭ-дийн олборлолтын сарын дундаж орлого. 2016 оны байдлаар судалгаанд хамрагдсан БУЭ-д олборлолтоосоо сард дунджаар 595,750 төгрөгний орлого олж байгаа бол хамгийн ихдээ 2 сая төгрөг, хамгийн багадаа 30,000 төгрөгний орлого олжээ. БУЭ-ийн 29% нь 300,000 төгрөг ба түүнээс доош хэмжээний орлогыг, 31% нь 300-500 мянган төгрөгний орлогыг, 12% нь 500-700 мянган төгрөгний орлогыг, 8% нь 700-900 мянган төгрөгний орлогыг, 14% нь 900-1100 мянган төгрөгийг, 6% нь 1.1 сая төгрөгөөс дээш хэмжээний орлогыг сард олборлолтоосоо олжээ.

Дараах зурагт албан ба албан бус БУЭ-дийн олборлолтоос олдог сарын орлогын динамикийг үзүүлэв. Албан БУЭ-дийн олборлолтын орлого албан бус БУЭ-дийнхээс их байна. Тодруулбал, албан бичил уурхай эрхлэгчид олборлолтоос сард дунджаар 644,117 төгрөгний орлого олж байхад албан бус бичил уурхай эрхлэгчид дунджаар 528,360 төгрөгний орлого сард олж байна. Албан БУЭ-д албан бус БУЭ-дээс сард дунджаар 115,000 төгрөгөөр илүү орлогыг олж байна.

**Дүрс 15 Албан ба албан бус БУЭ-дийн олборлолтоос олж буй сарын орлогын динамик Дүрс16**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд оролцсон 147 БУЭ олборлолтоос нийтдээ 91.98 сая төгрөгний орлогыг сард олж байна.

Тэд олборлосон 1 грамм алтаа дунджаар 67,700 төгрөгөөр, 1 кг гянтболдыг дунджаар 10,000 төгрөгөөр, 1 тонн жоншийг дунджаар 110,890 төгрөгөөр тус тус борлуулж байна.

Дараах хүснэгтэнд БУЭ-дийн АМ-аа борлуулж буй үнийг суурь судалгаатай харьцуулан сум тус бүрээр харууллаа. Суурь судалгаатай харьцуулахад Өлзийт болон Шарын голоос бусад бүх суманд ашигт малтмалын үнэ өссөн байна. Ялангуяа Хулд, Борнуурт ашигт малтмалын үнэ 50-иас дээш хувиар өсжээ.

### Хүснэгт 7 БУЭ-дийн ашигт малтмалаа борлуулж буй үнэ, суурь ба давтан судалгаа

Байршил		Ашигт малтмалын төрөл	Хэмжээ	Ашигт малтмалын дундаж үнэ		Үнийн өөрчлөлтийн хувь
Аймаг	Сум			Суурь судалгаа	Давтан судалгаа	
Баянхонгор	Баян-Овоо	Алт	Нэг грамм	56,133	60,013	7%
	Бөмбөгөр	Алт	Нэг грамм	56,000	60,570	8%
Говь-Алтай	Есөнбулаг	Алт	Нэг грамм	60,330	71,226	18%
Дорноговь	Айраг	Жонш	Нэг тонн	101,818	143,300	41%
Дундговь	Хулд	Жонш	Нэг тонн	83,571	132,700	59%
	Өлзийт	Жонш	Нэг тонн	49,375	27,500	-44%
Сэлэнгэ	Мандал	Алт	Нэг грамм	56,500	73,000	29%
	Шарын гол	Алт	Нэг грамм	60,480	56,375	-7%
Төв	Заамар	Алт	Нэг грамм	53,000	71,850	36%
	Борнуур	Алт	Нэг грамм	54,750	83,444	52%
Ховд	Булган	Алт	Нэг грамм	-	55,000	-
	Үенч	Алт	Нэг грамм	-	58,000	-
	Цэцэг	Алт	Нэг грамм	-	60,000	-
		Гянтболд	Нэг кг	-	10,000	-
Увс	Тариалан	Алт	Нэг грамм	-	57,444	-
	Өмнөговь	Алт	Нэг грамм	-	71,000	-

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан алтны БУЭ-дийн олонх нь олборлосон алтаа сумынхаа АМХЭ-д тушаадаг ажээ. Тодруулбал, 65% нь сумын АМХЭ-дэд, 28% нь аймгийн АМХЭ-дэд, 7% нь хотын АМХЭ-дэд АМ-аа тушаадаг ажээ. Харин жонш олборлогчдын хувьд 51% нь сумын АМХЭ-дэд, 5% нь аймгийн АМХЭ-дэд, 30% нь сумын АМХ эрхэлдэг ААН-д, 9% нь аймгийн АМХ эрхэлдэг ААН-д тушаадаг ажээ.

**БУЭ өрхийн сарын орлого ба олборлолтын орлого.** 2016 оны байдлаар судалгаанд хамрагдсан БУЭ өрхийн сарын дундаж орлого 1,032,260 төгрөг байгаа бөгөөд энэ нь улсын дундаж өрхийн орлоготой (2015 онд 1,047,300 төгрөг) бараг адил байна. Суурь судалгаатай харьцуулахад<sup>6</sup> БУЭ өрхүүдийн сарын дундаж орлого 261,656 төгрөгөөр өссөн байна.

БУЭ өрхүүдээс хамгийн ихдээ 6.7 сая, хамгийн багадаа 100,000 төгрөгний орлогыг сардаа олдог ажээ. БУЭ өрхүүдийн 10% нь нь 300,000 төгрөг ба түүнээс доош хэмжээний орлогыг, 20% нь 300-500 мянган төгрөгний орлогыг, 20% нь 500-700 мянган төгрөгний орлогыг, 11% нь 700-900 мянган төгрөгний орлогыг, 12% нь 900-1100 мянган төгрөгийг, 14% нь 1.1-1.6 сая төгрөгийг, 14% нь 1.6 сая төгрөгөөс дээш хэмжээний орлогыг сард нийтдээ олдог ажээ.


Судалгаанд хамрагдсан өрхүүд нийтдээ 151.7 сая төгрөгний орлогыг сард олж байна. Энэхүү нийлбэр орлогыг бүтцээр нь задалбал 66%-ийг БУ-н олборлолтын орлого, 15%-ийг цалин, 13%-ийг хувийн бизнесийн орлого, 4%-ийг тэтгэвэр, 2%-ийг тэтгэмж бүрдүүлж байна.

Түүнчлэн олборлолтын орлогоос гадна судалгаанд оролцсон БУЭ өрхүүд 30% нь цалингийн орлоготой, 21% нь хувийн бизнесийн орлоготой, 15% нь тэтгэмж авдаг, 12% нь тэтгэвэрийн


<sup>6</sup> Суурь судалгаанд оролцсон БУЭ өрхүүдийн сарын дундаж орлого 770,604 төгрөг байв.

орлоготой ажээ. Дүрс 16-д БУЭ өрхүүдийн хичнээн нь ямар төрлийн орлоготой болохыг харууллаа. Харин судалгаанд оролцсон БУЭ өрхүүдийн 38%-д өрхийн нийт орлогын дийлэнх хэсэг буюу 91-ээс дээш хувь нь зөвхөн бичил уурхайн олборлолтын орлогоос бүрддэг аж. Дүрс 17-д олборлолтын орлого өрхийн нийт орлогын хэдэн хувийг эзэлдгийг үзүүлэв.

**Дүрс 16 БУЭ өрхүүдийн орлогын төрлүүд**




**Дүрс 17 Олборлолтын орлогын БУЭ өрхийн орлогод эзлэх хувь**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Дүрс 17-өөс харахад судалгаанд хамрагдсан БУЭ өрхүүдийн 70 гаруй хувь нь өрхийн сарын орлогынхоо талаас илүү хэсгийг БУ-н олборлолтоос олж байна. Дараах зурагт өрхийн сарын нийт орлого ба олборлолтын орлогыг харьцуулав.

**Дүрс 18 Өрхийн олборлолтын сарын орлого ба өрхийн сарын нийт орлого, төгрөгөөр**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Дараах хүснэгтэнд БУЭ өрхийн сарын орлого ба орлогын төрлүүдийн тодорхойлох статистикуудыг нэгтгэн үзүүлэв.

### Хүснэгт 8 Өрхийн орлого ба орлогын төрлүүдийн тодорхойлох статистик


Тодорхойлох статистик	БУ-н олборлолтын орлого (147 ө )	Цалин (44)	Хадгаламжийн х (7)	Хувийн бизнесийн орлого (31 ө )	Тэтгэвэр (18)	Тэтгэмж (22)	Бусад орлого (7)	Ө сарын нийт орлого
	Төг/сар	Төг/сар	Төг/сар	Төг/сар	Төг/сар	Төг/сар	Төг/сар	Төг/сар
Дундаж	693,542	502,852	108,658	622,581	322,056	137,636	138,571	1,032,262
Медиан	500,000	455,000	45,000	400,000	250,000	80,000	100,000	700,000
Хамгийн их давтагдсан утга	500,000	600,000	-	300,000	250,000	60,000	80,000	1,000,000
Хамгийн их утга	6,000,000	1,500,000	350,000	5,000,000	800,000	600,000	300,000	6,700,000
Хамгийн бага утга	25,000	50,000	1,950	100,000	20,000	20,000	60,000	100,000

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


Суурь судалгаатай харьцуулахад өрхийн сарын дундаж орлого 261,656 төгрөгөөр, өрхийн олборлолтын сарын дундаж орлого 191,913 төгрөгөөр тус тус өсжээ. Өрхийн сарын орлого болон олборлолтын орлогын энэхүү өсөлтийн нэлээд хэсэг нь давтан судалгаанд шинээр орсон өндөр орлоготой өрхүүд бүхий сумдаас шалтгаалан өссөн ч суурь судалгаанд хамрагдсан 6 суманд өрхийн нийт орлого болон олборлолтын орлого өссөн байна. Ялангуяа, Мандал суманд өрхийн олборлолтын орлого 4.4 дахин, Заамарт 2.3 дахин өсжээ. Түүнчлэн Есөнбулагт өрхийн олборлолтын орлого 65%-иар, Борнуурт 20%-иар, Өлзийтөд 17%-иар, Баян-Овоод 0.4%-иар өссөн байна.

Хэдийгээр дээрх сумдад орлого өссөн ч 4 суманд өрхийн дундаж орлого болон олборлолтын дундаж орлого буурчээ. Тодруулбал, Бөмбөгөрт 33%-иар, Шарын голд 24%-иар, Хулдад 17%-иар, Айрагт 8%-иар өрхийн олборлолтын дундаж орлого буурсан байна. Шарын гол, Бөмбөгөр, Айраг суманд олборлолтын орлого буурсан гол шалтгаан нь зөвшөөрөлтэй газаргүй болсон, газартай ч гэсэн АМ-ын нөөцгүй болсонтой холбоотой ажээ. Харин Хулдын хувьд зөвшөөрөлтэй жонш худалдаж авах хувь худалдаачин болон ААН одоогоор байхгүй байгаа учраас АМ-аа борлуулж чадахгүй байгаа бөгөөд энэ нь БУЭ-дийн орлогод сэргөөр нөлөөлж байна.

**Дүрс 19 Өрхийн сарын дундаж орлогын харьцуулалт, суурь ба давтан судалгаагаар**



**Дүрс 20 Өрхийн олборлолтын сарын дундаж орлогын харьцуулалт, суурь ба давтан судалгаагаар**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Хүснэгт 10-д судалгаанд хамрагдсан БУЭ өрхүүдийн өрхийн сарын орлого, өрхийн олборлолтын сарын орлогын тоон мэдээллийг суурь болон давтан судалгаагаар нэгтгэн харууллаа. Давтан судалгаанд хамрагдсан нийт БУЭ өрхүүд татвар, хураамжаа төлөөд 147.3 сая төгрөгийн орлогыг сард олж байгаа бөгөөд үүний 95.4 сая төгрөг нь БУ олборлолтоос орж байна. Иймд судалгаанд хамрагдсан 147 БУЭ өрх эдийн засагт БУ эрхлэлтээрээ дамжуулан **95.4 сая** төрөгний хувь нэмрийг эдийн засагт оруулж байна.

Энэхүү хувь нэмрийн хичнээн нь орон нутгийн эдийн засагт шингэн үлдэж буйг тодорхойлох нь чухал юм. Судалгаанд хамрагдсан БУЭ-дийн 90% нь тухайн орон нутгийн иргэд учраас ойролцоогоор 85.8 сая төгрөг орон нутагт үлдэж байна хэмээн үзэж болно.

Түүнчлэн 147 БУЭ өрхийн 95.4 сая төрөгний цэвэр орлогыг суурь судалгаанд хамрагдсан 96 БУЭ өрхийн нийт цэвэр орлоготой харьцуулахад **48.9 сая** төгрөгөөр их байна. Энэхүү өсөлтийн 30.4 сая нь давтан судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумаас хамрагдсан БУЭ-дийн цэвэр орлого бол үлдсэн 18.5 сая төгрөг нь суурь судалгаанд хамрагдсан сумдаас судалгаанд оролцсон бичил уурхай эрхлэгчдийн тооны өөрчлөлт болон өрхийн олборлолтын дундаж орлогын өсөлтөөс үүдэн бий болжээ. Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд өрхийн олборлолтын дундаж орлого өнгөрсөн жилээс 138,944 төгрөгөөр өссөн байна<sup>7</sup>.

7 Хүснэгт 10: Суурь судалгаанд өрхийн олборлолтын дундаж орлого 521,629 төгрөг байсан бол давтан судалгаагаар эдгээр сумын өрхийн олборлолтын дундаж орлого 640,573 төгрөг гэж гарчээ.



**Хүснэгт 9 БУЭ өрхийн сарын нийт орлого ба өрхийн сарын олборлолтын орлого, судалгаанд оролцогчдын түвшинд (суурь ба давтан судалгаа)**

Байршил		Суурь судалгаа-2015 (ТХ=96)						Давтан судалгаа-2016 (ТХ=147)					
		Өрхийн сарын олборлолтын орлого			Өрхийн сарын нийт орлого			Өрхийн сарын олборлолтын орлого			Өрхийн сарын нийт орлого		
Аймаг	Сум	Дундаж (төгрөг)	Нийт дүн (мянган төгрөг)	Цэвэр дүн(а) (мянган төгрөг)	Дундаж (төгрөг)	Нийт дүн (мянган төгрөг)	Цэвэр дүн(а) (мянган төгрөг)	Дундаж (төгрөг)	Нийт дүн (мянган төгрөг)	Цэвэр дүн(а) (мянган төгрөг)	Дундаж (төгрөг)	Нийт дүн (мянган төгрөг)	Цэвэр дүн(а) (мянган төгрөг)
Баянхонгор	Баян-Овоо	395,125	3,161.0	2,936.6	457,750	3,662.0	3,395.9	396,875	3,175.0	2,892.5	542,001	4,336.0	4,053.5
	Бөмбөгөр	490,286	3,432.0	3,357.9	974,286	6,820.0	6,700.0	330,000	3,300.0	2,794.7	498,001	4,980.0	4,474.8
Говь-Алтай	Есөнбулаг	328,000	1,640.0	1,085.2	620,000	3,100.0	2,492.0	542,105	10,300.0	9,791.9	756,947	14,400.0	13,891.9
	Бигэр	316,364	3,480.0	3,886.5	523,637	5,760.0	6,124.0	-	-	-	-	-	-
Дорноговь	Айраг	701,674	11,226.8	11,058.2	967,874	15,486.0	15,230.1	645,556	11,600.0	11,429.2	835,800	16,700.0	16,529.2
Дундговь	Хулд	1,185,913	9,487.3	8,979.2	1,585,251	12,682.0	11,942.7	980,000	9,800.0	9,185.2	1,463,002	14,600.0	13,985.2
	Өлзийт	587,363	4,698.9	4,143.3	943,251	7,546.0	6,695.2	661,111	5,950.0	5,270.7	1,068,401	10,700.0	10,020.7
Дархан-Уул	Шарын гол	512,000	2,560.0	2,472.7	760,000	3,800.0	3,694.6	391,250	3,130.0	3,016.8	590,125	4,721.0	4,607.8
Сэлэнгэ	Мандал	219,083	1,314.5	1,291.1	548,332	3,290.0	3,258.5	966,667	8,700.0	8,643.5	1,501,883	13,500.0	13,443.5
	Орхонтуул	393,480	1,967.4	1,903.9	682,400	3,412.0	3,327.8	-	-	-	-	-	-
Төв	Заамар	366,750	2,934.0	2,848.5	578,750	4,630.0	4,454.0	879,500	8,795.0	8,355.8	1,362,500	13,600.0	13,160.8
	Борнуур	338,250	2,706.0	2,590.1	473,750	3,790.0	3,656.1	405,556	3,650.0	3,614.5	840,000	7,560.0	7,524.5
Дэд нийлбэр <sup>8</sup>		501,629	48,608	46,553	770,439	73,978	70,971	640,573	68,400.0	64,994.8	930,539	105,097.0	101,691.9

8 Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд

Ховд	Булган	-	-	-	-	-	-	850,000	4,250.0	4,057.7	2,233,200	11,200.0	11,007.6
	Үенч	-	-	-	-	-	-	1,080,000	5,400.0	5,175.3	1,438,000	7,190.0	6,965.4
	Цэцэг	-	-	-	-	-	-	2,500,000	15,000.0	14,881.3	2,700,000	16,200.0	16,081.3
Увс	Тариалан	-	-	-	-	-	-	355,556	3,200.0	2,890.8	686,167	6,175.5	5,866.3
	Өмнөговь	-	-	-	-	-	-	400,000	3,600.0	3,453.9	651,111	5,860.0	5,713.9
Дэд нийлбэр9		-	-	-	-	-	-	784,401	31,450	30,459	1,370,338	46,625.5	45,634.5
Нийт дүн		501,629	48,608	46,553	770,439	73,978	70,971	693,542	99,850.0	95,454.1	1,032,262	151,722.5	147,326.6

Эх сурвалж: Сүүрь ба давтан судалгааны үр дүн

Тайлбар: - дундаж утга; (а)-цэвэр дүн гэдэг бүх татвар, хураамжийг төлсний дараах орлого юм.

Судалгаанд хамрагдсан сумдын БУ-н олборлолтоос олж буй нийт орлого. Энэ хэсэгт сумын түвшинд олборлолтын нийт орлогыг тооцно. Ингэхдээ БУЭ-ийн сарын дундаж орлого болон ТББ-уудаас авсан БУЭ-дийн нийт тоонд үндэслэн олборлолтоос олж буй нийт орлогыг судалгаанд оролцсон сум тус бүрээр тоймлон тооцно. Энэхүү тооцооллыг хийхдээ тухайн сумын БУЭ-дийн дундаж орлогыг тухайн сумаас судалгаанд хамрагдсан БУЭ-дийн дундаж орлогоор төлөөлүүлэн авлаа.

Хүснэгт 11-д судалгаанд хамрагдсан сумдын БУ-н олборлолтоос олж буй нийт орлогыг суурь ба давтан судалгааны хувьд харуулав. Давтан судалгаанд хамрагдсан 15 суманд БУ-н олборлолт эрхэлж байгаа нийт 8917 БУЭ сард олборлолтоосоо 5.7 тэрбум төгрөгний цэвэр орлого олж байна. Үүнийг суурь судалгаанд хамрагдсан 11 сумын 5740 БУЭ-дийн цэвэр орлоготой харьцуулахад 3 тэрбум төгрөгөөр их байна. Энэхүү өсөлтийн 1.65 тэрбум нь давтан судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумын БУЭ-дийн цэвэр орлого бол үлдсэн 1.4 тэрбум нь суурь судалгаанд хамрагдсан сумдын бичил уурхай эрхлэгчдийн тооны болон олборлолтын дундаж орлогын өөрчлөлтөөс үүдэн бий болжээ (Хүснэгт 11).

**Хүснэгт 10 БУЭ-дийн олборлолтоос олж буй нийт орлого, сумын түвшинд (суурь ба давтан судалгаа)**

Байршил		Суурь судалгаа-2015				Давтан судалгаа-2016			
		Олборлолтын сарын дундаж орлого (төгрөг)(a)	БУЭ-дийн тоо(b)	Олборлолтын орлого, сард		Олборлолтын сарын дундаж орлого (төгрөг)(a)	БУЭ-дийн тоо(b)	Олборлолтын орлого, сард	
Нийт дүн (мянган төгрөг)(c)	Цэвэр дүн (мянган төгрөг)(c)			Нийт дүн (мянган төгрөг)(c)	Цэвэр дүн (мянган төгрөг)(d)				
Баянхонгор	Баян-Овоо	395,125	830	327,953.7	327,952.3	418,750	1025	429,218.7	393,026.5
	Бөмбөгөр	490,286	95	46,577.2	44,827.3	325,000	90	29,250	24,197.5
Говь-Алтай	Есөнбулаг	328,000	1150	377,200.0	344,422.70	547,368	1050	574,736.8	539,170.9
Дорноговь	Айраг	701,674	165	115,776.2	115,775.7	601,053	165	99,173.7	93,538
Дундговь	Хулд	1,185,913	650	770,843.4	768,154.6	560,000	380	212,800	183,596
	Өлзийт	587,363	388	227,896.8	227,888.6	695,000	120	83,400	75,249
Дархан-Уул	Шарын гол	512,000	846	433,152.0	433,148.5	320,000	700	224,000	204,193.5
Сэлэнгэ	Мандал	219,083	900	197,174.7	185,619.2	744,444	3000	2,233,333.2	2,190,970.2
	Орхонтуул	393,480	300	118,044.0	118,042.6	-	-	-	-
Төв	Заамар	366,750	268	98,289.0	95,066.7	820,000	368	301,760	278,672.7
	Борнуур	338,250	148	50,061.0	50,060.7	400,000	306	122,400	119,681.2
Дэд нийлбэр <sup>10</sup>		501,629	5,740	2,762,968	2,710,959	566,645	7,204	4,310,072	4,102,296
Ховд	Булган	-	-	-	-	1,250,000	350	437,500	424,036.9
	Үеңч	-	-	-	-	720,000	175	126,000	118,138
	Цэцэг	-	-	-	-	1,333,333	708	943,999.7	927,196.5
Увс	Тариалан	-	-	-	-	377,778	150	56,666.6	51,514.2
	Өмнөговь	-	-	-	-	411,111	330	135,666.6	129,640.7
Дэд нийлбэр <sup>11</sup>		-	-	-	-	822,058	1,713	1,699,833	1,650,526
Нийт дүн		501,629	5,740	2,762,968	2,710,959	595,750	8917	6,009,905.5	5,752,822.1

Эх сурвалж нь ТББ-ууд; (c) - БУЭ-ийн олборлолтын дундаж орлого ба БУЭ-ийн тооны үржвэр; (d)-цэвэр дүн гэдэг бүх татвар, хураамжийг төлсний дараах орлого буюу нийт орлогоос татвар, хураамжийг хассан дүн юм.

Тайлбар:  -дундаж утга; (a)-БУЭ-ийн олборлолтын дундаж орлого; (b)-Албан ба албан бус БУЭ-дийн тоо.

10 Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд

11 Давтан судалгаанд шинээр нэмэгдсэн сумдын хувьд

**БУ эрхлэлтийн үр өгөөж.** Судалгаанд хамрагдсан БУЭ-дийн 61% нь БУ эрхлэхээсээ өмнө өөр ажил эрхэлдэг байсан бол 39% нь өмнө нь өөр ажил эрхлэдэггүй байжээ. Өөрөөр хэлбэл, өмнө нь ажил эрхэлдэггүй байсан эдгээр 57 иргэн БУ-н ачаар ажлын байртай болж чаджээ.

Өмнө нь ажил эрхэлдэг байсан 90 БУЭ-ээс 47% нь мэргэжлийнхээ чиглэлээр ажилладаг байсан бол 53% нь мэргэжлийнхээ дагуу ажилладаггүй байсан байна. Эдгээрийн 31% нь хувийн байгууллагад, 38% нь төрийн байгууллагад ажилладаг, 31% нь хувиараа эрхлэх аж ахуй эрхэлдэг байжээ. Түүнчлэн эдгээр БУЭ-дийн 40% нь 300 мянга хүртэлх төгрөгний цалинтай, 37% нь 300-500 мянган төгрөгний цалинтай, 20% нь 500-1000 мянган төгрөгний цалинтай байсан байна. Харин одоо эдгээр 90 БУЭ олборлолтоосоо дунджаар сард 629,000 төгрөгний орлого олж байна. Доорх хүснэгтэнд өмнө нь ажил эрхэлдэг байсан БУЭ-дийн өмнөх болон одоогийн орлогыг харьцууллаа. Эдгээр БУЭ-дийн 40% нь 300 мянга хүртэлх төгрөгний орлоготой байсан бол одоо 24% нь л 300 мянга хүртэлх төгрөгний орлоготой байна. Өөрөөр хэлбэл, 16% нь БУ эрхэлснээрээ орлогоо нэмэгдүүлж чадсан байна. Нийтдээ эдгээр 90 БУЭ-дийн 38% нь БУ эрхэлснээрээ орлогоо нэмэгдүүлж чадсан гэж дүгнэж болохоор байна.

#### Хүснэгт 11 БУЭ-дийн өмнөх ба одоогийн орлогын харьцуулалт

Цалингийн интервал (төгрөг)	БУЭ-дийн эзлэх хувь	
	Өмнөх орлогын хувьд	Одоогийн орлогын хувьд
300,000 хүртэлх	40%	24%
300-500 мянга	37%	34%
500 мянга-1 сая	20%	36%
1 саяас дээш	3%	6%

Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

#### Дүгнэлт. Энэ хэсгийн гол үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэвэл:

- )] Давтан судалгаанд хамрагдсан БУЭ-д олборлолтоосоо сард дунджаар 595,750 төгрөгний орлого олж байна. Харин албан БУЭ-дийн олборлолтын орлого албан бус БУЭ-дийнхээс их байна. Тодруулбал, албан бичил үүрхэй эрхлэгчид олборлолтоос сард дунджаар 644,117 төгрөгний орлого олж байхад албан бус БУЭ-д дунджаар 528,360 төгрөгний орлого сард олж байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан БУЭ өрхийн сарын дундаж орлого 1,032,260 төгрөг байгаа бөгөөд энэ нь улсын дундаж өрхийн орлоготой (2015 онд 1,047,300 төгрөг) бараг адил байна. Суурь судалгаатай харьцуулахад БУЭ өрхүүдийн сарын дундаж орлого 261,655 төгрөгөөр өссөн байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан БУЭ өрхийн олборлолтын сарын дундаж орлого 693,542 төгрөг байгаа бөгөөд энэ нь суурь судалгааны өрхийн олборлолтын дундаж орлогоос 191,913 төгрөгөөр өссөн байна.
- )] Давтан судалгаанд оролцсон БУЭ өрхүүд олборлолтын орлогоос гадна 30% нь цалингийн орлоготой, 21% нь хувийн бизнесийн орлоготой, 15% нь тэтгэмж авдаг, 12% нь тэтгэвэрийн орлоготой ажээ.
- )] Давтан судалгаанд хамрагдсан БУЭ өрхүүдийн 70 гаруй хувь нь өрхийн сарын орлогынхоо талаас илүү хэсгийг БУ-н олборлолтоос олж байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан 147 БУЭ өрх БУ эрхлэлтээрээ дамжуулан сард 95.4 сая төгрөгний цэвэр орлогыг олж, орон нутгийн эдийн засагт хувь нэмрээ оруулж байна.

- )] Давтан судалгаанд хамрагдсан 15 суманд БУ-н олборлолт эрхэлж байгаа нийт 8917 БУЭ сард олборлолтоосоо 5.7 тэрбум төгрөгний цэвэр орлого олж, орон нутгийнхаа эдийн засагт хувь нэмэр оруулж байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан БУЭ-дээс өмнө нь ажил эрхэлдэггүй байсан 57 иргэн БУ эрхэлснээрээ ажлын байртай болжээ. Түүнчлэн өмнө нь ажил эрхэлдэг байсан 90 БУЭ-ийн 38% нь БУ эрхэлснээрээ орлогоо нэмэгдүүлж чаджээ.

### ***Ашигт малтмалын худалдаа эрхлэгчдийн орлого***

**АМХЭ-дийн ашигт малтмалын сарын дундаж орлого.** Давтан судалгаанд хамрагдсан АМХЭ-д хамгийн ихдээ 200, хамгийн багадаа 2 БУЭ-ээс АМ худалдаж авдаг ажээ. Тэдний 21% нь 5 ба түүнээс доош БУЭ-ээс, 36% нь 6-10 БУЭ-ээс, 14% нь 11-15 БУЭ-ээс, 11% нь 16-40 БУЭ-ээс, 14% нь 41-ээс дээш БУЭ-ээс АМ худалдан авч байна. Гэхдээ судалгаанд оролцсон АМХЭ-дийн 70 гаруй хувь нь зөвхөн 1-2 олборлолтын цэгтэй худалдаа хийдэг бол 10% нь 3-4 олборлолтын цэгтэй, нэг АМХЭ 10 цэгтэй худалдаа хийдэг байна.

2016 оны байдлаар судалгаанд хамрагдсан АМХЭ-д АМХ-аас сард дунджаар 1,413,813 төгрөгний орлого олж байгаа бол хамгийн ихдээ 6 сая төгрөг, хамгийн багадаа 100,000 төгрөгний орлого олжээ. АМХЭ-дийн 39% нь 300,000 төгрөг ба түүнээс доош хэмжээний орлогыг, 29% нь 300-500 мянган төгрөгний орлогыг, 11% нь 500-1000 мянган төгрөгний орлогыг, 4% нь 1-2 сая төгрөгний орлогыг, 10% нь 2-5 сая төгрөгийг, 7% нь 5 сая төгрөгөөс дээш хэмжээний орлогыг сард АМХ-наас олж байна.

Судалгаанд оролцсон 22 АМХ<sup>12</sup> арилжаанаасаа сард нийтдээ 31.5 сая төгрөгний орлогыг олж байна.

Тэд 1 грамм алтыг дунджаар 72,775 төгрөгөөр БУЭ-дээс аваад 77,760 төгрөгөөр борлуулдаг, 1 кг гянтболдыг дунджаар 10,000 төгрөгөөр БУЭ-дээс худалдан аваад 11,000 төгрөгөөр борлуулдаг, 1 тонн жоншийг дунджаар 13,750 төгрөгөөр БУЭ-дээс худалдаж аваад 183,750 төгрөгөөр борлуулж байна.

Түүнчлэн 2016 оны байдлаар судалгаанд хамрагдсан алтны худалдаа эрхлэгч нэг грамм алтнаас дунджаар 4,775 төгрөгний ашиг олсон бол хамгийн ихдээ 15,000 төгрөг, хамгийн багадаа 1,000 төгрөгний ашиг олжээ. Жоншны худалдаа эрхлэгч нэг тонн жоншноос дунджаар 45,000 төгрөгний ашиг олсон бол хамгийн ихдээ 70,000 төгрөг, хамгийн багадаа 30,000 төгрөгний ашиг олсон байна. Харин гянтболдын худалдаа эрхлэгч нэг кг гянтболдноос дунджаар 1000 төгрөгний ашиг олжээ. Дараах хүснэгтэнд АМХЭ-дийн ашигт малтмалаа худалдан авдаг болон борлуулдаг дундаж үнийг дундаж ахиуц ашгийн хамтаар сум тус бүрээр харууллаа.

---

12 6 АМХ эрхлэгч АМХ-наас олдог орлогоо хэлэхээс татгалзсан

### Хүснэгт 12 Ашигт малтмалыг худалдан авдаг ба борлуулдаг үнэ болон дундаж ашиг


Байршил		АМ-ын төрөл	Хэмжээ	Ашигт малтмалын дундаж үнэ		Дундаж ахиуц ашиг(а)
Аймаг	Сум			БУЭ-дээс авдаг үнэ	Зардаг үнэ <sup>13</sup>	
Баянхонгор	Баян-Овоо	Алт	Нэг грамм	82,500	84,000	1,500
	Бөмбөгөр	Алт	Нэг грамм	68,000	69,500	1,500
Говь-Алтай	Есөнбулаг	Алт	Нэг грамм	79,000	82,000	3,000
Дорноговь	Айраг	Жонш	Нэг тонн	182,500	222,500	40,000
Дундговь	Хулд	Жонш	Нэг тонн	160,000	190,000	30,000
	Өлзийт	Жонш	Нэг тонн	30,000	100,000	70,000
Дархан-Уул	Шарын гол	Алт	Нэг грамм	75,000	87,500	10,000
Сэлэнгэ	Мандал	Алт	Нэг грамм	75,500	81,000	5,500
Төв	Заамар	Алт	Нэг грамм	76,783	87,500	10,500
	Борнуур	Алт	Нэг грамм	71,500	75,500	4,180
Ховд	Булган	Алт	Нэг грамм	63,000	75,000	12,000
	Үенч	Алт	Нэг грамм	59,000	63,000	4,000
	Цэцэг	Гянтболд	Нэг кг	10,000	11,000	1,000
Увс	Тариалан	Алт	Нэг грамм	70,000	72,000	2,000
	Өмнөговь	Алт	Нэг грамм	74,500	75,000	2,500

Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Тайлбар: (а)-Ахиуц ашиг нь зөвхөн ашигт малтмалаа зах зээл дээр борлуулсан үнэ ба БУЭ-дээс худалдан авсан үнийн зөрүүгээр тодорхойлогдоно.

Судалгаанд хамрагдсан АМХЭ-дийн 63% нь АМ-аа хотын АМХЭ-дэд, 18% нь аймгийн АМЭ-дэд, 9% нь Монголбанкинд, 9% нь өөр сумын АМЭ-дэд, үлдсэн 3% нь Монголд байгаа гадаадын иргэнд борлуулдаг аж. Судалгаанд хамрагдсан БУЭ болон АМХЭ-дийн ашигт малтмалаа борлуулдаг шат дамжлагыг дараах схемээр нэгтгэн үзүүлээ.

#### Дүрс 21 Ашигт малтмалын борлуулалтын дамжлага



<sup>13</sup> 2016 оны 12-р сарын байдлаар Монголбанкны алтны дундаж ханш 92,110 төгрөг байна.

**АМХЭ өрхийн сарын орлого ба АМХ-ны орлого.** 2016 оны байдлаар судалгаанд хамрагдсан АМХЭ өрхийн сарын дундаж орлого 2,355,148 төгрөг ба медиан орлого 1,290,000 төгрөг байна. Өрхийн сарын медиан орлогыг<sup>14</sup> улсын дундаж өрхийн орлоготой (2015 онд 1,047,300 төгрөг) харьцуулахад даруй 243,000 төгрөгөөр их байна. Суурь судалгаатай харьцуулахад<sup>15</sup> АМХЭ өрхүүдийн сарын медиан орлого суурь судалгааны өрхийн сарын дундаж орлоготой бараг ижил байна.

АМХЭ өрхүүдээс хамгийн ихдээ 13.1 сая, хамгийн багадаа 370,000 төгрөгний орлогыг сардаа олдог ажээ. АМХЭ өрхүүдийн 7% нь нь 500,000 төгрөг ба түүнээс доош хэмжээний орлогыг, 36% нь 500-1000 мянган төгрөгний орлогыг, 7% нь 1-1.5 сая төгрөгийг, 21% нь 1.5-2 сая төгрөгийг, 7% нь 2-3 сая төгрөгийг, 18% нь 3 сая төгрөгөөс дээш хэмжээний орлогыг сард нийтдээ олдог ажээ<sup>16</sup>.



Судалгаанд хамрагдсан өрхүүд нийтдээ 69.8 сая төгрөгний орлогыг сард олж байна. Энэхүү нийлбэр орлогыг бүтцээр нь задалбал 51%-ийг АМХ-ны орлого, 40%-ийг хувийн бизнесийн орлого, 3%-ийг тэтгэвэр бүрдүүлж байна.

Түүнчлэн АМХ-ны орлогоос гадна судалгаанд оролцсон АМХЭ өрхүүдийн 57% нь хувийн бизнесийн орлоготой, 18% нь тэтгэвэрийн орлоготой, 14% нь хадгаламжийн хүүгийн нэмэлт орлогыг олдог ажээ (Дүрс 22)

Харин судалгаанд оролцсон АМХЭ өрхүүдийн 27%-д өрхийн нийт орлогын дийлэнх хэсэг буюу 91-ээс дээш хувь нь зөвхөн АМХ-ны орлогоос бүрддэг аж. Дүрс 23-д АМХ-ны орлого өрхийн нийт орлогын хэдэн хувийг эзэлдгийг үзүүлэв.

**Дүрс 22 АМХЭ өрхүүдийн орлогын төрлүүд**

**Дүрс 23 АМХ-ны орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувь**



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Дүрс 24-аас харахад судалгаанд хамрагдсан БУЭ өрхүүдийн 50 гаруй хувь нь өрхийн сарын орлогынхоо талаас илүү хэсгийг АМХ-наас олж байна. Дараах зурагт өрхийн сарын нийт орлого ба АМХ-ны орлогыг харьцуулав.


14 Цөөн тооны өрх өндөр орлоготой байгаа учраас өрхийн медиан орлогыг харьцуулалтанд ашиглана.

15 Суурь судалгаанд оролцсон АМХЭ өрхүүдийн сарын дундаж орлого 1,310,466 төгрөг байв.

16 4% нь өрхийн сарын орлогоо хэлэхээс татгалзсан.



### Дүрс 24 Өрхийн АМХ-ны сарын орлого ба өрхийн сарын нийт орлого



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Хүснэгт 14-т судалгаанд хамрагдсан АМХЭ өрхүүдийн өрхийн сарын орлого, өрхийн АМХ-ны сарын орлогын тоон мэдээллийг суурь болон давтан судалгаагаар нэгтгэн харууллаа. Давтан судалгаанд хамрагдсан 28 АМХЭ өрх татвар, хураамжаа төлөөд 61.9 сая төгрөгийн орлогыг сард олж байгаа бөгөөд үүний 34.8 сая төгрөг нь АМХ-наас орж байна. Иймд судалгаанд хамрагдсан АМХЭ өрхүүд эдийн засагт ашигт малтмалын худалдаагаараа дамжуулан 34.8 сая төгрөгний хувь нэмрийг эдийн засагт оруулж байна (Хүснэгт 14).

Энэхүү хувь нэмрийн хичнээн нь орон нутгийн эдийн засагт шингэн үлдэж буйг тодорхойлох нь чухал юм. Судалгаанд хамрагдсан АМХЭ-дийн 93% нь тухайн орон нутгийн иргэд учраас ойролцоогоор 32.4 сая төгрөг орон нутагт үлдэж байна хэмээн үзэж болно.

Түүнчлэн 28 АМХЭ өрхийн 34.8 сая төгрөгний цэвэр орлогыг суурь судалгаанд хамрагдсан 15 АМХЭ өрхийн нийт цэвэр орлого болох 13.7 сая төгрөгтэй харьцуулахад 21.1 сая төгрөгөөр их байна. Энэхүү өсөлтийн 18.2 сая нь давтан судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумаас хамрагдсан АМХЭ-дийн цэвэр орлого бол үлдсэн 2.9 сая төгрөг нь суурь судалгаанд хамрагдсан сумдаас судалгаанд оролцсон АМХЭ-дийн тооны өөрчлөлт болон өрхийн АМХ-наас олж буй дундаж орлогын өсөлтөөс үүдэн бий болжээ. Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд өрхийн АМХ-наас олж буй сарын дундаж орлого суурь судалгаатай харьцуулахад 167,000 төгрөгөөр өсжээ.

**Хүснэгт 13 Өрхийн сарын нийт орлого ба өрхийн АМХ-наас олж буй сарын орлого, судалгаанд оролцогчдын түвшинд (суурь ба давтан судалгаа)**

Байршил		Суурь судалгаа-2015 (ТХ=15)						Давтан судалгаа-2016 (ТХ=28)					
		Өрхийн АМХ-наас олж буй сарын орлого			Өрхийн сарын нийт орлого			Өрхийн АМХ-наас олж буй сарын орлого			Өрхийн сарын нийт орлого		
Аймаг	Сум	Дундаж (төгрөг)	Нийт дүн (мянган төгрөг)	Цэвэрдүн(а) (мянган төгрөг)	Дундаж (төгрөг)	Нийт дүн(мянган төгрөг)	Цэвэрдүн (а)(мянган төгрөг)	Дундаж (төгрөг)	Нийт дүн (мянган төгрөг)	Цэвэр дүн(а)(мянган төгрөг)	Дундаж (төгрөг)	Нийт дүн (мянган төгрөг)	Цэвэр дүн(а) (мянган төгрөг)
Баянхонгор	Баян-Овоо	110,000	110.0	110.0	1,100,000	1,100.0	1,100.0	675,000	1,350.0	1,242.8	675,000	1,350.0	1,242.8
	Бөмбөгөр	569,618	1,144.0	1,139.2	1,100,000	2,200.0	2,157.0	300,000	600.0	568.3	650,000	1,300.0	1,268.3
Говь-Алтай	Есөнбулаг	732,345	1,520.0	1,464.7	1,300,000	2,600.0	2,503.4	1,225,000	2,450.0	2,270.0	997,722	3,990.8	3,810.9
	Бигэр	599,333	600.0	599.3	600,000	600.0	599.3	-	-	-	-	-	-
Дорноговь	Айраг	876,634	1,050.0	876.6	1,500,000	1,500.0	1,252.3	1,000,000	2,000.0	1,309.6	1,750,000	3,500.0	2,809.6
Дундговь	Хулд	122,496	200.0	122.5	2,000,000	2,000.0	1,224.9	500,000	500.0	441.1	900,000	900.0	841.2
	Өлзийт	198,426	219.7	198.4	407,000	407.0	367.4	5,000,000	5,000.0	4,783.3	5,800,000	5,800.0	5,583.3
Дархан-Уул	Шарын гол	1,499,170	1,500.0	1,499.2	1,500,000	1,500.0	1,499.2	350,000	700.0	700.0	1,965,000	3,930.0	3,930.0
Сэлэнгэ	Мандал	1,186,549	1,200.0	1,186.5	1,200,000	1,200.0	1,186.5	3,000,000	3,000.0	2,947.0	13,100,000	13,100.0	1,3047.0
	Орхонтуул	609,600	650.0	609.6	650,000	650.0	609.6	-	-	-	-	-	-
Төв	Заамар	2,447,923	4,900.0	4,895.8	1,225,000	4,900.0	4,895.8	675,000	1350.0	1350.0	1,575,000	3,150.0	3,150.0
	Борнуур	1,000,000	1,000.0	1,000.0	1,000,000	1,000.0	1,000.0	500,000	1,000.0	995.0	550,000	1,100.0	1,095.0
Дэд нийлбэр <sup>17</sup>		829,341	14,093.8	13,701.9	1,310,466	19,657.0	18,395.6	997,058	17,950	16,607	2,137.89	38,121	36,778.1
Ховд	Булган	-	-	-	-	-	-	750,000	1,500.0	1,385.4	2,000,000	4,000.0	3,885.4
	Үенч	-	-	-	-	-	-	1,750,000	3,500.0	3,391.0	3,265,500	6,531.0	6,422.0
	Цэцэг	-	-	-	-	-	-	2,000,000	2,000.0	2,000.0	2,000,000	2,000.0	2,000.0
Увс	Тариалан	-	-	-	-	-	-	2,510,000	5,020.0	5,020.0	2,685,000	5,370.0	5,370.0
	Өмнөговь	-	-	-	-	-	-	3,250,000	6,500.0	6,470.0	3,784,000	7,568.0	7,538.0
Дэд нийлбэр <sup>18</sup>		-	-	-	-	-	-	2,057,777	18,520	18,266	2,629,888	25,469	25,215.4
Нийт дүн		829,341	14,093.8	13,701.9	1,310,466	19,657.0	18,395.6	1,364,231	36,470.0	34,873.7	2,355,148	63,589.8	61,993.6

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн Тайлбар: -дундаж утга; (а)-цэвэр дүн гэдэг бүх татвар, хураамжийг төлсний дараах орлого юм.

17 Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд

18 Давтан судалгаанд шинээр нэмэгдсэн сумдын хувьд

**Судалгаанд хамрагдсан сумдын АМХ-наас олж буй нийт орлого.** Энэ хэсэгт сумын түвшинд АМХ-наас олж буй нийт орлогыг авч үзнэ. Ингэхдээ АМХЭ-дийн сарын дундаж орлого болон ТББ-уудаас авсан АМХЭ-дийн нийт тоонд үндэслэн АМХ-наас олж буй нийт орлогыг судалгаанд оролцсон сум тус бүрээр тоймлон тооцно. Энэхүү тооцооллыг хийхдээ тухайн сумын АМХЭ-дийн дундаж орлогыг тухайн сумаас судалгаанд хамрагдсан АМХЭ-дийн дундаж орлогоор төлөөлүүлэн авлаа.

Хүснэгт 15-т судалгаанд хамрагдсан сумдын АМХ-наас олж буй нийт орлогыг суурь ба давтан судалгааны хувьд харуулав. Давтан судалгаанд хамрагдсан 15 суманд АМХ эрхэлж байгаа нийт 74 АМХЭ сард арилжаанаасаа 88 сая төгрөгний цэвэр орлого олж байна. Үүнийг суурь судалгаанд хамрагдсан 11 сумын 62 АМХ эрхлэгчийн цэвэр орлоготой харьцуулахад 7 сая төгрөгөөр өсжээ. Хэдийгээр ерөнхий дүнгээрээ өссөн ч суурь судалгаанд хамрагдаж байсан 10 сумын АМХ-ны цэвэр орлого суурь судалгаанаас 30 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь АМХЭ-дийн тоо болон зарим сумдад АМХ-ны сарын дундаж орлого буурсантай холбоотой юм (Хүснэгт 15).

**Хүснэгт 14 АМХЭ-дийн худалдаанаас олж буй нийт орлого, сумын түвшинд, суурь ба давтан судалгаа**

Байршил		Суурь судалгаа-2015			Давтан судалгаа-2016			
		АМХ-ны сарын дундаж орлого (төгрөг)(a)	АМХЭ-дийн тоо(b)	АМХ-ны орлого, сард	АМХ-ны сарын дундаж орлого (төгрөг)(a)	АМХЭ-дийн тоо(b)	АМХ-ны орлого, сард	
Цэвэр дүн (төгрөг)(d)	Нийт дүн (төгрөг)(c)			Цэвэр дүн (төгрөг)(d)				
Баянхонгор	Баян-Овоо	110,000	2	220,000	675,000	2	1,350,000	1,242,833
	Бөмбөгөр	569,618	12	6,835,410	300,000	8	2,400,000	2,273,200
Говь-Алтай	Есөнбулаг	732,345	5	3,661,723	1,225,000	7	8,575,000	7,945,210
	Бигэр	599,333	NA	NA	NA	-	-	-
Дорноговь	Айраг	876,634	4	3,506,536	1,000,000	4	4,000,000	2,619,320
Дундговь	Хулд	122,496	1	122,496	500,000	1	500,000	441,160
	Өлзийт	198,426	4	793,704	5,000,000	1	5,000,000	4,783,333
Дархан-Уул	Шарын гол	1,499,170	5	7,495,850	350,000	6	2,100,000	2,100,000
Сэлэнгэ	Мандал	1,186,549	4	4,746,196	3,000,000	5	15,000,000	14,735,000
	Орхонтуул	609,600	1	609,600	-	-	-	-
Төв	Заамар	2,447,923	20	48,958,460	675,000	20	13,500,000	13,500,000
	Борнуур	1,000,000	4	4,000,000	500,000	2	1,000,000	995,000
<b>Дэд нийлбэр<sup>19</sup></b>		<b>829,341</b>	<b>62</b>	<b>80,949,975</b>	<b>997,058</b>	<b>56</b>	<b>53,425,000</b>	<b>50,635,056</b>
Ховд	Булган	-	-	-	750,000	5	3,750,000	3,463,400
	Үенч	-	-	-	1,750,000	1	1,750,000	1,695,500
	Цэцэг	-	-	-	2,000,000	3	6,000,000	6,000,000
Увс	Тариалан	-	-	-	2,510,000	4	10,040,000	10,040,000
	Өмнөговь	-	-	-	3,250,000	5	16,250,000	16,175,000
<b>Дэд нийлбэр<sup>20</sup></b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2,057,777</b>	<b>18</b>	<b>37,790,000</b>	<b>37,373,900</b>
<b>Нийт дүн</b>		<b>829,341</b>	<b>62</b>	<b>80,949,975</b>	<b>1,364,231</b>	<b>74</b>	<b>91,215,000</b>	<b>88,008,956</b>

Эх сурвалж ТББ-үүд; (c)- АМХЭ-дийн АМХ-ны дундаж орлого ба АМХЭ-дийн тооны үржвэр; (d)-цэвэр дүн гэдэг бүх татвар, хураамжийг төлсний дараах орлого буюу нийт орлогоос татвар, хураамжийг хассан дүн юм.

Тайлбар:   -дундаж утга; (a)-АМХЭ-дийн АМХ-ны дундаж орлого; (b)-

19 Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд

20 Давтан судалгаанд шинээр нэмэгдсэн сумдын хувьд

**АМХ эрхэлсний үр өгөөж.** Судалгаанд хамрагдсан АМХЭ-дийн 85% нь АМХ эрхлэхээсээ өмнө өөр ажил эрхэлдэг байсан бол 14% нь өмнө нь өөр ажил эрхлэдэггүй байжээ. Өөрөөр хэлбэл, өмнө нь ажил эрхэлдэггүй байсан эдгээр 4 иргэн АМХ эрхэлснээр ажилтай болж чаджээ.

Өмнө нь ажил эрхэлдэг байсан 24 АМХЭ-ээс 50% нь мэргэжлийнхээ чиглэлээр ажилладаг байсан бол нөгөө 50% нь мэргэжлийнхээ дагуу ажилладаггүй байсан байна. Эдгээрийн 21% нь хувийн байгууллагад, 38% нь төрийн байгууллагад ажилладаг, 41% нь хувиараа эрхлэх аж ахуй эрхэлдэг байжээ. Түүнчлэн эдгээр АМХЭ-дийн 25% нь 300 мянга хүртэлх төгрөгний цалинтай, 42% нь 300-500 мянган төгрөгний цалинтай, 25% нь 500-1000 мянган төгрөгний цалинтай, 8% нь 2 саяас дээш төгрөгний цалинтай байсан байна. Харин одоо эдгээр 24 АМХЭ арилжаанаасаа дунджаар сард 1,489,400 төгрөгний орлого олж байна. Доорх хүснэгтэнд өмнө нь ажил эрхэлдэг байсан АМХЭ-дийн өмнөх болон одоогийн орлогыг харьцууллаа. Эдгээр АМХЭ-дийн 25% нь 300 мянга хүртэлх төгрөгний орлоготой байсан бол одоо 17% нь л 300 мянга хүртэлх төгрөгний орлоготой байна. Өөрөөр хэлбэл, 8% нь АМХ эрхэлснээрээ орлогоо нэмэгдүүлж чадсан байна. Нийтдээ эдгээр 24 АМХЭ-дийн 50 гаруй хувь нь АМХ эрхэлснээрээ орлогоо нэмэгдүүлж чадсан гэж дүгнэж болохоор байна.

#### Хүснэгт 15 АМХЭ-дийн өмнөх ба одоогийн орлогын харьцуулалт

Цалингийн интервал (төгрөг)	АМХЭ-дийн эзлэх хувь	
	Өмнөх орлогын хувьд	Одоогийн орлогын хувьд
300,000 хүртэлх	25%	17%
300-500 мянга	42%	29%
500 мянга-1 сая	25%	12%
1 -2 сая	-	4%
2 саяас дээш	8%	17%

Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

**Дүгнэлт.** Энэ хэсгийн гол үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэвэл:

- )] Давтан судалгаанд хамрагдсан АМХЭ өрхийн сарын дундаж орлого 2,355,148 төгрөг ба медиан орлого 1,290,000 төгрөг байна. Өрхийн сарын медиан орлогыг улсын дундаж өрхийн орлоготой (2015 онд 1,047,300 төгрөг) харьцуулахад даруй 243,000 төгрөгөөр их байна. Суурь судалгаатай харьцуулахад АМХЭ өрхүүдийн сарын медиан орлого суурь судалгааны өрхийн сарын дундаж орлоготой бараг ижил байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан АМХЭ өрхийн АМХ-наас олох сарын дундаж орлого 1,364,231
- )] Төгрөг, харин суурь судалгаанд хамрагдаж байсан АМХЭ өрхүүдийн АМХ-наас олох сарын дундаж орлого 997,058 төгрөг байна. Энэ нь суурь судалгааны өрхийн АМХ-ны сарын дундаж орлогоос 167,717 төгрөгөөр өссөн байна.
- )] Давтан судалгаанд оролцсон АМХЭ өрхүүд АМХ-ны орлогоос гадна 57% нь хувийн бизнесийн орлоготой, 18% нь тэтгэвэрийн орлоготой, 14% нь хадгаламжийн хүүгийн нэмэлт орлогыг олдог ажээ.
- )] Давтан судалгаанд хамрагдсан АМХЭ өрхүүдийн 50 гаруй хувь нь өрхийн сарын орлогынхоо талаас илүү хэсгийг АМХ-наас олж байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан 28 АМХЭ өрх АМХ-аараа дамжуулан 34.8 сая төгрөгний орлогыг олж, орон нутгийн эдийн засагт хувь нэмрээ оруулж байна.

- Давтан судалгаанд хамрагдсан 15 суманд АМХ эрхэлж байгаа нийт 74 АМХЭ сард арилжаанаасаа 88 сая төгрөгний цэвэр орлого олж, орон нутгийнхаа эдийн засагт хувь нэмэр оруулж байна.
- Давтан судалгаанд хамрагдсан АМХЭ-дээс өмнө нь ажил эрхэлдэггүй байсан 4 иргэн АМХ эрхэлснээрээ шинээр ажилтай болжээ. Түүнчлэн өмнө нь ажил эрхэлдэг байсан 24 АМХЭ-дийн 50 гаруй хувь нь АМХ эрхэлснээрээ орлогоо нэмэгдүүлж чаджээ.

### БУЭ болон АМХЭ-дийн орлогын нийлбэр дүн

Хүснэгт 17-д давтан ба суурь судалгаанд хамрагдсан БУЭ болон АМХЭ-дийн БУ-н үйл ажиллагаанаас олж буй нийт орлогыг сум бүрээр харуулав. Давтан судалгаанд хамрагдсан БУЭ-д (147) болон АМХЭ-д (28) БУ-н үйл ажиллагаанаас нийтдээ 130.3 сая төгрөгийг сард олж байна. Энэ нь судалгаанд хамрагдсан БУЭ болон АМХЭ-дийн ажил эрхлэлтээрээ дамжуулан эдийн засагт оруулж буй хувь нэмэр юм.

Суурь судалгаатай харьцуулахад БУЭ болон АМХЭ-дийн орлогын нийлбэр дүн 70 саяар өссөн бөгөөд үүний 48.7 сая нь давтан судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумын БУЭ болон АМХЭ-дийн БУ-н үйл ажиллагаанаас олж буй цэвэр орлого бол үлдсэн 21.3 сая төгрөг нь суурь судалгаанд хамрагдсан сумдын БУЭ болон АМХЭ-дийн тооны болон дундаж орлогын өөрчлөлтөөс үүдэн бий болжээ (Хүснэгт 17).

### Хүснэгт 16 БУЭ болон АМХЭ-дийн БУ-н үйл ажиллагаанаас олж буй нийт орлого, түүвэр судалгааны түвшинд

Байршил		Суурь судалгаа-2015				Давтан судалгаа-2016			
Аймаг	Сум	БУЭ болон АМХЭ-дийн тоо	БУ-н үйл ажиллагааны цэвэр орлого, сард			БУЭ болон АМХЭ-дийн тоо	БУ-н үйл ажиллагааны цэвэр орлого, сард		
			БУЭ (мянган)	АМХЭ (мянган)	Нийт (мянган)		БУЭ (мянган)	АМХЭ (мянган)	Нийт (мянган)
Баянхонгор	Баян-Овоо	9	2,936.6	110	3,046.6	11	2,892.5	1,242.8	4,135.3
	Бөмбөгөр	10	3,357.9	1,139.2	4,497.1	11	2,794.7	568.3	3,363.0
Говь-Алтай	Есөнбулаг	10	1,085.2	1,464.7	2,549.9	23	9,791.9	2,270.0	12,061.9
	Бигэр	9	3,886.5	599.3	4,485.8	-	-	-	-
Дорноговь	Айраг	17	11,058.2	876.6	11,934.8	22	11,429	1,309.6	12,738.8
Дундговь	Хулд	9	8,979.2	122.5	9,101.7	11	9,185.2	441.1	9,626.3
	Өлзийт	9	4,143.3	198.4	4,341.7	11	5,270.7	4,783.3	10,054.0
Дархан-Уул	Шарын гол	6	2,472.7	1,499.2	3,971.9	11	3,016.8	700.0	3,716.8
Сэлэнгэ	Мандал	7	1,291.1	1,186.5	2,477.6	12	8,643.5	2,947.0	11,590.5
	Орхонтуул	6	1,903.9	609.6	2,513.5	-	-	-	-
Төв	Заамар	10	2,848.5	4,895.8	7,744.3	10	8,355.8	1,350.0	9,705.8
	Борнуур	9	2,590.1	1,000.0	3,590.1	10	3,614.5	995.0	4,609.5
<b>Дэд нийлбэр<sup>21</sup></b>		<b>111</b>	<b>46,553</b>	<b>13,702</b>	<b>60,255</b>	<b>132</b>	<b>64,995</b>	<b>16,607</b>	<b>81,601.9</b>
Ховд	Булган	-	-	-	-	7	4,057.7	1,385.4	5,443.1
	Үенч	-	-	-	-	7	5,175.3	3,391.0	8,566.3
	Цэцэг	-	-	-	-	7	14,881	2,000.0	16,881.3

<sup>21</sup> Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд

Увс	Тариалан	-	-	-	-	11	2,890.8	5,020.0	7,910.8
	Өмнөговь	-	-	-	-	11	3,453.9	6,470.0	9,923.9
<b>Дэд нийлбэр<sup>22</sup></b>		-	-	-	-	<b>43</b>	<b>30,459</b>	<b>18,266</b>	<b>48,725</b>
<b>Нийт дүн</b>		<b>111</b>	<b>46,553</b>	<b>13,702</b>	<b>60,255</b>	<b>175</b>	<b>95,454</b>	<b>34,874</b>	<b>130,328</b>

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

Хүснэгт 18-д судалгаанд хамрагдсан сумдын БУЭ болон АМХЭ-дийн бичил уурхайн үйл ажиллагаанаас олж буй нийт орлогыг суурь ба давтан судалгааны хувьд харуулав. Давтан судалгаанд хамрагдсан 15 суманд бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа 8917 бичил уурхай эрхлэгч болон 74 АМХЭ сард БУ-н үйл ажиллагаанаасаа 5.8 тэрбум төгрөгний цэвэр орлого олж байна. Үүнийг суурь судалгаанд хамрагдсан 11 сумын 7805 БУЭ болон 62 АМХЭ-ийн цэвэр орлоготой харьцуулахад 2.1 тэрбум төгрөгөөр их байна. Энэхүү өсөлтийн 1.7 орчим тэрбум нь давтан судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумын БУЭ болон АМХЭ-дийн цэвэр орлого бол үлдсэн 0.4 тэрбум нь суурь судалгаанд хамрагдсан сумдын БУЭ болон АМХЭ-дийн тооны болон БУ-н үйл ажиллагааны дундаж орлогын өөрчлөлтөөс үүдэн бий болжээ (Хүснэгт 18).

**Хүснэгт 17 БУЭ болон АМХЭ-дийн БУ-н үйл ажиллагаанаас олж буй нийт орлого, сумын түвшинд (мянган төгрөг)**

Байршил		Суурь судалгаа-2015				Давтан судалгаа-2016			
		БУЭ болон АМХЭ-дийн тоо	БУ-н үйл ажиллагааны цэвэр орлого, сард			БУЭ болон АМХЭ-дийн тоо	БУ-н үйл ажиллагааны цэвэр орлого, сард		
Аймаг	Сум		БУЭ (мянган т)	АМХЭ (мянган т)	Нийт (мянган т)		БУЭ (мянган т)	АМХЭ (мянган т)	Нийт (мянган т)
Баянхонгор	Баян-Овоо	832	327,952	220	328,172	1,027	393,027	1,243	394,269
	Бөмбөгөр	107	44,827	6,835	51,662	98	24,198	2,273	26,471
Говь-Алтай	Есөнбулаг	851	433,149	7,496	440,644	706	204,194	2,100	206,294
Дорноговь	Айраг	169	115,776	3,507	119,282	169	93,538	2,619	96,157
Дундговь	Хулд	651	768,155	122	768,277	381	183,596	441	184,037
	Өлзийт	392	227,889	794	228,682	121	75,249	4,783	80,032
Дархан-Уул	Шарынгол	1,155	344,423	3,662	348,085	1,057	539,171	7,945	547,116
Сэлэнгэ	Мандал	NA	NA	NA	NA	NA	NA	NA	NA
	Орхонтуул	904	185,619	4,746	190,365	3,005	2,190,970	14,735	2,205,705
Төв	Заамар	301	118,043	610	118,652	-	-	-	-
	Борнуур	288	95,067	48,958	144,025	388	278,673	13,500	292,173
<b>Дэд нийлбэр<sup>23</sup></b>		<b>5,802</b>	<b>2,710,959</b>	<b>80,950</b>	<b>2,791,909</b>	<b>7,206</b>	<b>4,102,296</b>	<b>50,634.0</b>	<b>4,152,931</b>
Ховд	Булган	-	-	-	-	355	424,037	3,463	427,500

22 Давтан судалгаанд шинээр нэмэгдсэн сумдын хувьд

23 Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд

	Үенч	-	-	-	176	118,138	1,696	119,834
	Цэцэг	-	-	-	708	927,197	6,000	933,197
Увс	Тариалан	-	-	-	154	51,514	10,040	61,554
	Өмнөговь	-	-	-	335	129,641	16,175	145,816
Дэд нийлбэр <sup>24</sup>		-	-	-	<b>1,728</b>	<b>1,650,526</b>	<b>37,374</b>	<b>1,687,900</b>
Нийт дүн		<b>5,802</b>	<b>2,710,959</b>	<b>80,950</b>	<b>2,791,909</b>	<b>8,988</b>	<b>5,752,822</b>	<b>88,009</b>

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

### 2.1.3 Дүгнэлт

Дараах хүснэгтэнд БУЭ болон АМХЭ-дийн ажил эрхлэлтээрээ дамжуулан бий болгож буй эдийн засгийн шууд нөлөөг тоймлон харууллаа. Давтан судалгаанд хамрагдсан 15 сумын бичил уурхай эрхлэгчид болон ашигт малтмалын худалдаа эрхлэгчид нийтдээ 8,988 ажлын байрыг бий болгож, ойролцоогоор 5.8 тэрбум төгрөгийн орлогыг БУ-н үйл ажиллагаанаас сард олж байна. Харин давтан судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчид болон ашигт малтмалын худалдаачид 175 ажлын байрыг бий болгож, ойролцоогоор 130.3 сая төгрөгийн орлогыг БУ-н үйл ажиллагаанаас сард олж байна.

#### Хүснэгт 18 Ажил эрхлэлтээс үүдэлтэй эдийн засгийн шууд нөлөө

Тооцооллын түвшин	Суурь судалгаа-2015		Давтан судалгаа-2016	
	Ажлын байр	БУ-н үйл ажиллагааны цэвэр орлого, сард (мянган төгрөг)	Ажлын байр	БУ-н үйл ажиллагааны цэвэр орлого, сард (мянган төгрөг)
Сумын түвшинд	5802	2,791,908.8	8988	5,840,831.1
Судалгаанд оролцогчдын түвшинд	145	60,255.0	175	130,327.8

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

## 2.2 Татвар болон төлбөр хураамж

Татвар, төлбөр хураамж хэлбэрээр хийгдэж буй эдийн засгийн шууд нөлөөллийг судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн сумандаа төлж буй татвар, төлбөр хураамж, нийгмийн даатгалын шимтгэл (НДШ), эрүүл мэндийн даатгал (ЭМД), олборлолттой холбоотой бусад төлбөр зэргийг үндэслэсэн. Давтан судалгаанд үр дүнг ашиглан БУ болон АМХЭ-дийн тухайн сумандаа сард төлж буй дээрх татвар, төлбөр, хураамж, шимтгэл болон даатгал зэргийг сум бүрээр дундаж мөнгөн дүнг гаргасан. Харин сумын хэмжээнд оруулж буй шууд нөлөөллийг тухайн сумын нийт БУЭ болон АМХ-ын тоон мэдээллийг ашиглан тооцож гаргасан.

Давтан судалгаанд БУ-н ТББ, албан болон албан бус БУЭ, АМХЭ-дээс ХБЯ-н аргаар мэдээлэл цуглуулсан. БУ болон АМХЭ-ийн тухайн сумандаа сард төлдөг татвар, төлбөр хураамж, НДШ, ЭМД болон олборлолттой холбоотой төлбөрийн нийт хэмжээг доорх хүснэгтүүдэд харьцуулан харуулсан. Сумын төрийн байгууллагуудад БУ болон АМХЭ-дийн тоо бүртгэл болон тэдний хэдий хэмжээний татвар, хураамж сумандаа төлж буй талаарх мэдээлэл хангалтгүй байсан. Харин сумын хэмжээний БУЭ болон АМХЭ-дийн тоон мэдээллийг тухайн сумын БУ-н ТББ-ын мэдээлэлд үндэслэн

<sup>24</sup> Давтан судалгаанд шинээр нэмэгдсэн сумдын хувьд



тооцсон. Харин татвар хураамжийн дундаж мөнгөн дүнг БУЭ болон АМХЭ-дийн ярилцлагыг үндэслэн гаргасан.

## 2.2.1 Татвар

Суурь судалгаагаар, албан бус БУЭ суманд огт татвар төлдөггүй гэсэн үр дүн гарсан бол давтан судалгаагаар энэ байдал өөрчлөгдсөн байна. Давтан судалгаанд хамрагдсан нийт БУЭ 2016 онд сумандаа сард нийт 1,624,900 төгрөгийн татвар төлсөн байна. Үүний 150,500 төгрөг буюу 9%-ийг албан бус БУЭ-д төлсөн байна. Судалгаанд хамрагдсан сумдын албан БУЭ өөрсдийн бүртгэлтэй ТББ-аар дамжуулан сар бүр дунджаар 21,380 төгрөгийн татвар орон нутагт төлдөг байна.

Хүснэгт 20-д суурь болон давтан судалгаанд хамрагдсан нийт БУЭ сумандаа сард хэдий хэмжээний татвар төлснийг харьцуулан харуулав. Давтан судалгаанд Ховд, Увс аймгийн 5 сум шинээр нэмэгдсэн боловч судалгаанд оролцогчдын төлсөн нийт татвар суурь үеийнхтэй ойролцоо байсан.

### Хүснэгт 19. БУЭ-дийн суманд төлж буй татвар, судалгаанд оролцогчдын түвшинд.

		Албан болон албан бус БУЭ					
		2015 /N=96/			2016 /N=147/		
Аймаг	Сум	БУЭ тоо	Сарын дундаж татварын хэмжээ (төгрөг)	Сарын нийт татварын хэмжээ (төгрөг)	БУЭ тоо	Сарын дундаж татварын хэмжээ (төгрөг)	Сарын нийт татварын хэмжээ (төгрөг)
Баянхонгор	Баян-Овоо	8	89,500	716,000	9	15,213	121,700
	Бөмбөгөр	8	6,000	48,000	9	6,500	65,000
Говь-Алтай	Есөнбулаг	8	9,417	37,666	19	13,053	248,000
	Бигэр	8	1,745	19,200	0	NA	NA
Дорноговь	Айраг	16	5,067	76,000	20	4,050	81,000
Дундговь	Хулд	8	33,125	265,000	10	42,200	422,000
	Өлзийт	8	53,000	424,000	10	53,300	533,000
Дархан-Уул	Шарын гол	5	7,600	38,000	8	625	5,000
Сэлэнгэ	Мандал	6	0	0	9	889	8,000
	Орхонтуул	5	200	1,000	0	NA	NA
Төв	Заамар	8	1,250	10,000	10	0	0
	Борнуур	8	1,375	11,000	9	0	0
Ховд	Булган	-	-	-	5	24,140	120,700
	Үенч	-	-	-	5	1,600	8,000
	Цэцэг	-	-	-	6	0	0
Увс	Тариалан	-	-	-	9	1,389	12,500
	Өмнөговь	-	-	-	9	0	0
<b>Нийт</b>		<b>96</b>	<b>1,645,866</b>		<b>147</b>	<b>1,624,900</b>	

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

Хамгийн өндөр татвар төлж буй БУЭ жоншны орд бүхий сумдын БУЭ-д байна. Суурь судалгаанд мөн энэ байдал ажиглагдаж байсан. Харин алтны орд бүхий Есөнбулаг болон Баян-Овоо сумд бусад алтны орд бүхий сумдаас орон нутагтаа төлж буй татвар өндөр байна. Баян-Овоо сумын татвар төлөлт суурь үзүүлэлтээс буурсан нь давтан судалгаанд оролцсон БУЭ-дийн 41 хувь нь албан бус БУЭ байсантай холбоотой. Харин Есөнбулаг сум нь аймгийн төвийн сум бөгөөд 2016 онд аймгийн төвийн БУЭ-дийг зохион байгуулалтад оруулах ажил хийснээр татвар төлөлт өсжээ. Давтан судалгаанд нэмэгдэж орсон сумдын хувьд Булган сумын БУЭ-ийн татвар төлөлт өндөр байна. Булган сумын удирдлагын өгсөн мэдээллээр 2015 онд 1,300,000 төгрөгийн татварыг БУЭ-д төлжээ. Харин Өмнөговь сумын БУЭ-д 2015 онд 1,606,420 төгрөгийн татвар төлжээ.

Давтан судалгаанд нэмэгдсэн Тариалан сумын БУЭ-дийн хувьд 2016 оны 3-р улирлын байдлаар 1,548,500<sup>25</sup> төгрөгийн татварыг сумандаа төлжээ. Харин суурь болон давтан судалгаанд хамрагдсан сумдаас Хулд сумын БУЭ-д 2016 онд 29,210,500<sup>26</sup> төгрөг төлсөн байна.

Суурь судалгаагаар жоншны орд бүхий сумдын АМХ бусад орд бүхий сумдаас татвар төлөлт илүү байсан бол давтан судалгаанд адил дүр зураг харагдаж байна. Энэ нь жоншны АМХЭ сумтай гэрээ байгуулж харилцан үүрэг хүлээж ажилладагтай холбоотой. Харин бусад ашигт малтмалын орд бүхий сумдад АМХЭ-дийн орлого тогтворгүй, хэлбэлздэгтэй холбоотойгоор АМХЭ-ээс татвар төвлөрүүлж чаддаггүй гэж сумдын удирдлагууд тайлбарлаж байв.

### Хүснэгт 20 АМХЭ-дийн сумандаа төлж буй татвар, судалгаанд оролцогчдын түвшинд

		АМХЭ					
		2015 /N=15/			2016 /N=28/		
Аймаг	Сум	АМХЭ- дийн тоо	Сарын дундаж татварын хэмжээ (төгрөг)	Сарын нийт татварын хэмжээ (төгрөг)	АМХЭ- дийн тоо	Сарын дундаж татварын хэмжээ (төгрөг)	Сарын нийт татварын хэмжээ (төгрөг)
Баянхонгор	Баян-Овоо	1	0	0	2	25,000	50,000
	Бөмбөгөр	2	0	0	2	0	0
Говь-Алтай	Есөнбулаг	2	20,833	41,600	4	12,500	50,000
Дорноговь	Айраг	1	50,000	50,000	2	150,000	300,000
Дундговь	Хулд	1	5,000	5,000	1	55,000	55,000
	Өлзийт	1	16,700	16,700	1	167,000	167,000
Дархан-Уул	Шарын гол	1	0	0	2	0	0
Сэлэнгэ	Мандал	1	0	0	1	53,000	53,000
	Орхонтуул	1	0	0	-	-	-
Төв	Заамар	2	15,000	30,000	2	0	0
	Борнуур	1	0	0	2	0	0
Ховд	Булган	-	-	-	2	0	0
	Үенч	-	-	-	2	0	0
	Цэцэг	-	-	-	1	0	0
Увс	Тариалан	-	-	-	2	0	0
	Өмнөговь	-	-	-	2	0	0
<b>Нийт</b>		<b>14</b>	<b>143,300</b>		<b>28</b>	<b>675,000</b>	

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

Суурь судалгаанд хамрагдсан зорилтот сумдын АМХЭ-дийн сарын нийт татвар төлөлт 143,332 төгрөг байсан бол давтан судалгаанд 675,000 төгрөг болж өссөн байна. Татвар төлөлт ингэж нэмэгдсэн нь Айраг, Хулд, Өлзийт сумдын АМХЭ-дийн төлсөн татвар эрс нэмэгдсэн, өнгөрсөн жил татвар төлөөгүй байсан Баян-Овоо, Мандал сумын АМХ энэ жил татвар төлсөн зэргээс шалтгаалжээ.


Өмнө дурдсанчлан, жоншны орд бүхий сумдад бусад сумтай харьцуулахад орон нутагт үзүүлэх шууд нөлөө их хэвээр байна. Үүнд, Өлзийт сумын БУЭ-дийн олборлосон жоншийг нэг иргэн дангаараа худалдан авдаг болсон, түүнтэй сумын удирдлага гэрээ байгуулж ажиллаж байгаа нь тогтвортой байдлын нэг сайн түршлага болж байна.

25 Тариалан сумын удирдлагатай хийх ХБЯ, БУЭ-н 2016 оны 3-р улирлын байдлаар төлсөн татварын мэдээлэл

26 Хулд сумын удирдлагатай хийх ХБЯ, БУЭ-н 2016 оны 3-р улирлын байдлаар төлсөн татварын мэдээлэл

Суурь судалгаанд оролцсон БУЭ-дийн 46.9 хувь, АМХЭ-дийн 33.3 хувь нь татвар төлж байсан. Харин давтан судалгаанд БУЭ-дийн 36.7 хувь, АМХЭ-дийн 25 хувь нь тухайн орон нутагтаа татвар төлжээ. Өөрөөр хэлбэл, татвар төлөлт буурсан байх магадлалтай байна.

### Дүрс 25. Татвар төлөлтийн эзлэх хувь, судалгаанд оролцогчдын түвшинд



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Суурь судалгаатай харьцуулахад давтан судалгаанд оролцсон татвар төлдөг БУЭ-дийн хувь буурсан нь “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч

иргэний орлогын албан татвар”-ын тухай хуулийн өөрчлөлттэй холбоотой. Мөн олборлолтын мөчлөг буурсан, сумын төрийн албан хаагчид солигдсон, орон нутгийн зүгээс БУЭ-дэд өгөх газаргүй болсон зэрэг нь үүнд нөлөөлсөн байж болох юм.

БУЭ-дийн орон нутагт төлсөн татварыг сумын түвшинд тооцсон үр дүнг дараах хүснэгтэд харуулав. 2016 онд сумын хэмжээнд төлсөн нийт татвар буурсан нь дээр дурдсан шалтгаантай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар”-ын тухай хуулийн зарим зүйл заалт өөрчлөлтөөр, БУЭ орлогын татвараа жилийн эцэст нэг удаа төлдөг болсон. Иймээс 2016 оны татварын орлого оны эцэст нэмэгдэх төлөвтэй байна.

### Хүснэгт 21. БУЭ-дийн төлсөн нийт татвар, сумын түвшинд.

		Албан болон албан бус БУЭ					
		2015 /N=5740/			2016 /N=8917/		
Аймаг	Сум	БУЭ-дийн тоо	Сарын дундаж татварын хэмжээ (төгрөг)	Сарын нийт татварын хэмжээ (төгрөг)	БУЭ-дийн тоо	Сарын дундаж татварын хэмжээ (төгрөг)	Сарын нийт татварын хэмжээ (төгрөг)
Баянхонгор	Баян-Овоо	830	89,500	74,285,000	1,025	15,213	15,592,813
	Бөмбөгөр	95	6,000	570,000	90	6,500	585,000
Говь-Алтай	Есөнбулаг	1,150	9,417	10,829,550	1,050	13,053	13,705,263
Дорноговь	Айраг	165	5,067	836,055	165	4,050	668,250
Дундговь	Хулд	650	33,125	21,531,250	380	42,200	16,036,000
	Өлзийт	388	53,000	20,564,000	120	53,300	6,396,000
Дархан-Уул	Шарын гол	846	7,600	6,429,600	700	625	437,500
Сэлэнгэ	Мандал	900	0	0	3,000	889	2,666,667
	Орхонтүүл	300	200	60,000	-	-	-
Төв	Заамар	268	1,250	335,000	368	0	0
	Борнуур	148	1,375	203,500	306	0	0
Ховд	Булган	-	-	-	350	24,140	8,449,000
	Үенч	-	-	-	175	1,600	280,000
	Цэцэг	-	-	-	708	0	0
Увс	Тариалан	-	-	-	150	1,389	208,333
	Өмнөговь	-	-	-	330	0	0
<b>Нийт</b>		<b>5,740</b>	<b>135,643,955</b>		<b>8,917</b>	<b>65,024,826</b>	

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

Судалгаанд оролцогчдын түвшинд АМХЭ-дийн татвар төлөлт суурь үеэс нэмэгдсэн. Энэ нь татвар төлсөн дундаж дүн нэмэгдсэн, давтан судалгаанд 5 сум нэмэгдсэн зэрэгтэй холбоотой.

### Хүснэгт 22. АМХЭ-дийн суманд төлсөн нийт татвар, сумын түвшинд

		АМХЭ					
		2015 /N=62/			2016 /N=74/		
Аймаг	Сум	АМХЭ-дийн тоо	Сарын дундаж татварын хэмжээ (төгрөг)	Сарын нийт татварын хэмжээ (төгрөг)	АМХЭ-дийн тоо	Сарын дундаж татварын хэмжээ (төгрөг)	Сарын нийт татварын хэмжээ (төгрөг)
Баянхонгор	Баян-Овоо	2	0	0	2	25,000	50,000
	Бөмбөгөр	12	0	0	8	0	0
Говь-Алтай	Есөнбулаг	5	20,833	104,165	7	12,500	87,500
	Бигэр	0	0	0	0	-	-
Дорноговь	Айраг	4	50,000	200,000	4	150,000	600,000
Дундговь	Хулд	1	5,000	5,000	1	55,000	55,000
	Өлзийт	4	16,700	66,800	1	167,000	167,000
Дархан-Уул	Шарын гол	5	0	0	6	0	0
Сэлэнгэ	Мандал	4	0	0	5	53,000	265,000
	Орхонтүүл	1	0	0	0	-	-
Төв	Заамар	20	15,000	300,000	20	0	0
	Борнуур	4	0	0	2	0	0
Ховд	Булган	-	-	-	5	0	0
	Үенч	-	-	-	1	0	0
	Цэцэг	-	-	-	3	0	0
Увс	Тариалан	-	-	-	4	0	0
	Өмнөговь	-	-	-	5	0	0
<b>Нийт</b>		<b>62</b>	<b>675,965</b>		<b>74</b>	<b>1,224,500</b>	

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

Давтан судалгаанд шинээр нэмэгдсэн сумдын АМХЭ орон нутагтаа ямар нэг татвар төлөхгүй байна. Жоншноос бусад орд бүхий сумдын АМХЭ-дийн татвар төлөлт давтан судалгааны үед нэмэгдсэн байна. Жоншны орд бүхий Айраг сумын АМХ хамгийн өндөр татварыг сумандаа тогтвортой төлж байгаа бол Хулд, Өлзийт сумдад БУ эрхлэх зөвшөөрөл бүхий олборлолтын газар байхгүйгээс татварын орлого харьцангуй бага байна.

### Хүснэгт 23. БУ болон АМХЭ-дийн нийт татвар төлөлт

	Он	БУ болон АМХЭ-ын тоо	Сарын нийт татвар төлөлт /сараар/
Сумын түвшинд	2015	5802	136,319,920 ₮
	2016	8991	66,249,326 ₮
Судалгаанд хамрагдагчдын түвшинд	2015	111	1,789,166 ₮
	2016	175	2,299,900 ₮

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

## 2.2.2 Төлбөр, хураамж

Эдийн засагт үзүүлж буй шууд нөлөөллийг нарийн тооцохын тулд БУЭ-дийн суманд төлж буй татвараас гадна бусад төлбөр, хураамжийг тооцох хэрэгтэй. БУ болон АМХЭ-д тухайн сумын төрийн байгууллага болон ТББ-уудад төлсөн төлбөр, хураамжийг тооцон доорх хүснэгтэд харуулав. Судалгаанд хамрагдсан нэг албан БУЭ өөрийн бүртгэлтэй ТББ-даа сард дунджаар 18,839 төгрөг төлдөг байна. Давтан судалгаанд хамрагдсан ТББ-ууд гишүүдээсээ сард дунджаар 371,250 төгрөгийн хураамж авдаг байна. Уг хураамжийг нөхөн сэргээлт, гэнэтийн осол, эмзэг бүлгийн уурхайчдын эрүүл мэнд болон амьжиргааг дэмжих, дээвэр холбооны хураамж зэрэгт зориулдаг. Гэвч зарим ТББ бүртгэлтэй БУЭ-дээсээ хураамж авч чадахгүй байгаа бөгөөд энэ нь цаашид тогтвортой ажиллахад бэрхшээл учруулж байна.

Суурь судалгаанд оролцсон БУЭ орон нутагтаа нийт 333,332 төгрөгийн хураамж төлсөн бол давтан судалгаанд оролцогч БУЭ-д 257,336 төгрөгийн хураамж төлжээ.

### Хүснэгт 24. БУЭ-дийн төлсөн хураамж, судалгаанд оролцогчдын түвшинд

		Албан ба албан бус БУЭ					
		2015 /N=96/			2016 /N=147/		
Аймаг	Сум	БУЭ-дийн тоо	Сарын дундаж хураамжийн хэмжээ (төгрөг)	Сарын нийт хураамжийн хэмжээ (төгрөг)	БУЭ-дийн тоо	Сарын дундаж хураамжийн хэмжээ (төгрөг)	Сарын нийт хураамжийн хэмжээ (төгрөг)
Баянхонгор	Баян-Овоо	8	6,500	52,000	9	9,135	73,083
	Бөмбөгөр	8	5,750	46,000	9	9,209	92,085
Говь-Алтай	Есөнбулаг	8	1,250	5,000	19	2,838	53,917
	Бигэр	8	-	-	0	-	-
Дорноговь	Айраг	16	6,250	100,000	20	-	-
Дундговь	Хулд	8	708	5,666	10	200	2,000
	Өлзийт	8	8,500	68,000	10	417	4,167
Дархан-Уул	Шарын гол	5	6,000	30,000	8	-	-
Сэлэнгэ	Мандал	6	167	1,000	9	-	-
	Орхонтуул	5	1,533	7,666	0	-	-
Төв	Заамар	8	-	-	10	-	-
Суманд оруулсан биет хөрөнгө оруулалтад орон нутгийн тохижилт (зам засвар, хог цэвэрлэгээ, мод тарих), ойн арга хэмжээ, захиргааны байрны засвар, цэцэрлэг барих зардал, иргэдэд гэр орон өгөх, малчин өрхүүдийн усны эх үүсвэрийг шийдэх, малын хороо барих, сумын газар тариаланд шуудуу татах зэрэг ажлууд орж байна. Олон нийтэд дэмжлэг үзүүлэх хөрөнгө оруулалтад сургууль, эмнэлэгийн засвар, сургалтын төлбөр, хичээлийн хэрэгсэл бэлэглэх, соёлын төвийн хандив, сайн үйлсийн аян зохион байгуулах (өвчтэй хүмүүст хандив, малжуулах хандив), бүлгийн эх засварлах хандив, барилга засвар зэрэг багтаж байна. Харин сургалт болон БУЭ-дийн аюулгүй ажиллагааны хөрөнгө оруулалтад БУЭ-дэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалт, хувцас хэрэгсэл, алтны албажуулсан худалдааны сургалт, нөхөн сэргээлтийн сургалт, ТББ-ын менежмент, эсгий урлал, бизнес төсөл бичих сургалт, оёдлын сургалт зэрэг багтаж байна.



Доорх хүснэгтүүдэд ТББ, БУЭ, АМХЭ-дийн зүгээс сумандаа оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг төрлөөр нь харуулав.

Хүснэгт 54. ТББ-ын олон нийтэд хийсэн хөрөнгө оруулалт

		ТББ-ын хөрөнгө оруулалт (мянган төгрөг)					
Аймаг	Сум	Биет х орлуулалт	Н	Сургалт	БУЭ-дийн аюулг ажиллагаа	Олон нийтэд дэмжлэг у	НИЙТ ДҮН
	Бөмбөгөр	1,440	0	400	0	0	1,840
Говь-Алтай	Есөнбулаг	300	40,000	0	0	534	40,834
Дорноговь	Айраг	10,250	19,100	2,000	405	750	32,505
Дундговь	Хулд	0	0	0	0	0	0
	Өлзийт	0	20,000	0	0	0	20,000
Сэлэнгэ	Мандал	2,350	0	0	400	700	3,450
Дархан	Шарын гол	0	400	0	0	0	400
Төв	Заамар	0	3,000	0	0	1,800	4,800
	Борнуур	0	0	1,370	0	71,300	72,670
Ховд	Булган	2,500	40,000	1,500	0	0	44,000
	Үенч	0	22,000	180	1,200	0	23,380
	Цэцэг	0	0	0	0	0	0
Увс	Тариалан	0	0	0	0	1,500	1,500
	Өмнөговь	0	0	0	0	0	0
<b>НИЙТ ДҮН</b>		<b>18,520</b>	<b>194,500</b>	<b>5,450</b>	<b>2,005</b>	<b>76,584</b>	<b>297,059</b>

Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

Давтан судалгаанд хамрагдсан ТББ-ын тухайн сумдад оруулсан нийт хөрөнгө оруулалт 297 сая төгрөг байгаа бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтынхаа дийлэнхийг нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд зарцуулжээ.

Хүснэгт 55. БУЭ-дийн орон нутагт хийж буй хөрөнгө оруулалтын хэмжээ

		БУЭ-ийн хөрөнгө оруулалт (төгрөг)					
Аймаг	Сум	Биет хөрөнгө орлуулалт	Нөхөн сэргээлт	Олон нийтэд дэмжлэг үзүүлэх	Хандив, тусламж	Бусад	НИЙТ ДҮН
	Бөмбөгөр	0	72,000	0	80,000	0	152,000
Говь-Алтай	Есөнбулаг	0	NA	318,000	236,000	0	554,000
Дорноговь	Айраг	450,000	44,500,000	150,000	280,000	0	45,380,000
Дундговь	Хулд	0	0	0	100,000	0	100,000
	Өлзийт	0	0	0	400,000	0	400,000
Сэлэнгэ	Мандал	0	0	42,000	60,000	0	102,000
Дархан	Шарын гол	0	35,000	0	0	0	35,000
Төв	Заамар	0	0	13,000,000	310,000	0	13,310,000
	Борнуур	0	0	2,100,000	25,000	0	2,125,000
Ховд	Булган	0	1,400,000	2,000,000	100,000	0	3,500,000
	Үенч	0	0	0	0	0	0

	Цэцэг	0	0	0	800,000	0	800,000
Увс	Тариалан	60,000	0	113,000	740,000	0	913,000
	Өмнөговь	0	23,000	0	0	0	23,000
<b>НИЙТ ДҮН</b>		<b>510,000</b>	<b>46,030,000</b>	<b>17,823,000</b>	<b>3,286,000</b>	<b>2,000,000</b>	<b>69,649,000</b>

Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

### Хүснэгт 56. АМХЭ-дийн олон нийтэд хийсэн хөрөнгө оруулалт

		АМХЭ-дийн олон нийтэд хийсэн хөрөнгө оруулалт (төгрөг)			
Аймаг	Сум	Биет хөрөнгө оруулалт	Олон нийтэд дэмжлэг үзүүлэх	Хандив, тусламж	НИЙТ ДҮН
Баянхонгор	Баян-Овоо	-	-	-	-
	Бөмбөгөр	-	-	100,000	100,000
Говь-Алтай	Есөнбулаг	-	-	1,500,000	1,500,000
	Бигэр	-	-	-	-
Дорноговь	Айраг	900,000	200,000	100,000	1,200,000
Дундговь	Хулд	-	-	4,000,000	4,000,000
	Өлзийт	1,500,000	-	3,000,000	4,500,000
Дархан	Шарын гол	-	-	-	-
Сэлэнгэ	Мандал	-	-	400,000	400,000
	Орхонтуул	-	-	-	-
Төв	Заамар	150,000	-	-	150,000
	Борнуур	-	-	60,000,000	60,000,000
Ховд	Булган	-	-	800,000	800,000
	Үенч	-	3,000,000	500,000	3,500,000
	Цэцэг	-	-	-	-
Увс	Тариалан	-	-	-	-
	Өмнөговь	-	-	400,000	400,000
<b>НИЙТ ДҮН</b>		<b>2,550,000</b>	<b>3,200,000</b>	<b>70,800,000</b>	<b>76,550,000</b>

Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

Давтан судалгаанд хамрагдсан БУЭ-д 69,649,000 төгрөг, АМХ-д 76,550,000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг сумандаа тус тус хийсэн бөгөөд эдгээр нь нөхөн сэргээлт, хандив, тусламж үзүүлэхэд зарцуулагддаг байна.

Дээрх хүснэгтүүдээс үзэхэд, сум тус бүрт хийгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээ ялгаатай байна. Тухайлбал, Төв аймгийн Борнуур сумын ТББ олон нийтэд дэмжлэг үзүүлэх хөрөнгө оруулалт хамгийн их хийж байгаа бол Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Ховд аймгийн Булган сумын ТББ нөхөн сэргээлтэд хамгийн их хөрөнгө оруулж байна.

БУЭ-дийн хувьд Дорноговь аймгийн Айраг сумын бичил үүрхайчид нөхөн сэргээлтийн үйл ажиллагаандаа хамгийн их хөрөнгө оруулалт хийдэг бол Төв аймгийн Заамар сумын БУЭ-д олон нийтэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд ихээхэн хөрөнгө оруулжээ. Харин Төв аймгийн Борнуур сумын АМХЭ-д хандив, тусламжинд нилээд их хөрөнгө оруулжээ.

## 2.5 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд хувь нэмрийн тойм

**Судалгаанд оролцогчдын түвшинд.** Хүснэгт 57-д БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд хувь нэмрийг судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн хувьд сүм бүрээр нэгтгэн харууллаа. Давтан судалгаанд хамрагдсан БУЭ болон АМХЭ-д 175 ажлын байрыг бий болгож, ойролцоогоор 130.3 сая төгрөгийн орлогыг БУ-н үйл ажиллагаанаас олж, 101.1 сая төгрөгийг худалдан авалтанд зарцуулж, 5.8 сая төгрөгийн татвар төлж байна. Нийтдээ тэд сард 237.2 сая төгрөгийн шууд хувь нэмрийг эдийн засагт оруулж байна (Хүснэгт 57).

Түүнчлэн БУЭ-д болон АМХЭ-д орон нутгийн эдийн засаг, олон нийтэд чиглэсэн хөрөнгө оруулалт, хандив тусламжийг нэлээдгүй үзүүлдэг бөгөөд 2016 онд судалгаанд хамрагдсан БУЭ-д болон АМХЭ-д нийтдээ 146.1 сая төгрөгийг нийгмийн хөрөнгө оруулалтанд зарцуулсан байна (Хүснэгт 57).

Суурь судалгаатай харьцуулахад БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулах шууд хувь нэмэр 1.7 дахин буюу 102.7 сая төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийн 79.1 сая нь судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумаас оролцсон БУЭ болон АМХЭ-дийн хувь нэмэр бол үлдсэн 23.7 сая төгрөг нь судалгаанд хамрагдсан БУЭ болон АМХЭ-дийн тооны өөрчлөлт, тэдгээрийн дундаж орлогын өөрчлөлт, худалдан авалтын өөрчлөлтөөс үүдэн бий болжээ.

### Хүснэгт 57 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд хувь нэмэр, судалгаанд оролцогчдын түвшинд

Байршил		Давтан судалгаа-2016					
		Ажил эрхлэлт		Худалдан авалт (мянган төг/сар)	Татвар, хураамж (мянган төг/сар)	Нийт дүн (мянган төг/сар)	Нийгмийн хөрөнгө оруулалт (мянган төг/сар)
Аймаг	Сум	Ажлын байр	БУ-н үйл ажиллагааны цэвэр орлого (мянган төг/сар)				
Баянхонгор	Баян-Овоо	11	4,135.3	1,745.3	438.4	6,318.9	2,255.0
	Бөмбөгөр	11	3,363.0	2,352.2	534.9	6,250.1	252.0
Говь-Алтай	Есөнбулаг	23	12,061.9	11,980.9	688.0	24,730.8	2,054.0
Дорноговь	Айраг	22	12,738.8	13,567.8	561.1	26,867.6	46,580.0
Дундговь	Хулд	11	9,626.3	1,832.5	678.8	12,137.6	4,100.0
	Өлзийт	11	10,054.0	3,533.8	896.2	14,484.0	4,900.0
Дархан-Уул	Шарын гол	11	3,716.8	2,858.9	109.5	6,685.2	502.0
Сэлэнгэ	Мандал	12	11,590.5	4,017.0	113.2	15,720.7	35.0
Төв	Заамар	10	9,705.8	21,769.2	439.2	31,914.1	13,460.0
	Борнуур	10	4,609.5	8,409.7	51.0	13,070.2	62,125.0
<b>Дэд нийлбэр<sup>40</sup></b>		<b>132</b>	<b>81,601.9</b>	<b>72,067.3</b>	<b>4,510.3</b>	<b>15,8179.2</b>	<b>13,6263</b>
Ховд	Булган	7	5,443.1	6,823.3	313.0	12,579.4	4,300.0
	Үенч	7	8,566.3	5,880.0	288.6	14,734.9	3,500.0
	Цэцэг	7	16,881.3	6,441.7	118.7	23,441.6	800.0
Увс	Тариалан	11	7,910.8	4,374.8	405.3	12,691.0	913.0
	Өмнөговь	11	9,923.9	5,533.3	197.7	15,654.9	423.0
<b>Дэд нийлбэр<sup>41</sup></b>		<b>43</b>	<b>48,725.4</b>	<b>29,053.1</b>	<b>13,23.3</b>	<b>79,101.8</b>	<b>9,936</b>
<b>Нийт дүн</b>		<b>175</b>	<b>130,327.3</b>	<b>101,120.3</b>	<b>5,833.6</b>	<b>237,281.1</b>	<b>146,199.0</b>

40

41

Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

**Сумын түвшинд.** Хүснэгт 58-д судалгаанд хамрагдсан сумдад үйл ажиллагаагаа явуулж буй нийт БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шүүд хувь нэмрийг сум бүрээр нэгтгэн харууллаа. Давтан судалгаанд хамрагдсан 15 суманд үйл ажиллагаагаа явуулж байгаа нийт БУЭ-д болон АМХЭ-д 8988 ажлын байр бий болгож, сард ойролцоогоор 5.8 тэрбум төгрөгийн орлогыг БУ-н үйл ажиллагаанаас олж, 4.8 тэрбум төгрөгийг худалдан авалтанд зарцуулж, 196 сая төгрөгийн татвар төлж байна. Нийтдээ 10.9 тэрбум төгрөгийн шүүд хувь нэмрийг эдийн засагт оруулж байна (Хүснэгт 58).

Суурь судалгаатай харьцуулахад БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулах шүүд хувь нэмэр сумдын түвшинд 1.7 дахин буюу 4.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийн 3 тэрбум нь судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумдын БУЭ болон АМХЭ-дийн хувь нэмэр бол үлдсэн 1.5 тэрбум нь суурь судалгаанд хамрагдсан сумдын БУЭ болон АМХЭ-дийн тооны өөрчлөлт болон тэдгээрийн эдийн засагт оруулж буй шүүд хувь нэмрийн өөрчлөлтөөс үүдэлтэй (Хүснэгт 58).

**Хүснэгт 58 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шүүд хувь нэмэр, сумдын түвшинд**

Байршил		Давтан судалгаа-2016				
		Ажил эрхлэлт		Худалдан авалт (мянган төг/сар)	Татвар, хураамж (мянган төг/сар)	Нийт дүн (мянган төг/сар)
Аймаг	Сум	Ажлын байр	БУ-н үйл ажиллагааны цэвэр орлого (мянган төг/сар)			
Баянхонгор	Баян-Овоо	1027	394,269	176,313	36,348.1	606,930
	Бөмбөгөр	98	26,471	30,907	4,656.0	62,034
Говь-Алтай	Есөнбулаг	1057	547,116	591,267	28,393.2	1,166,776
Дорноговь	Айраг	169	96,157	113,198	2,189.5	211,545
Дундговь	Хулд	381	184,037	75,884	23,612.2	283,533
	Өлзийт	121	80,032	30,305	8,368.0	118,705
Дархан-Уул	Шарын гол	706	2,205,705	1,281,542	9,903.3	3,497,150
Сэлэнгэ	Мандал	3005	206,294	279,312	19,093.0	504,699
Төв	Заамар	388	292,173	797,073	16,161.1	1,105,407
	Борнуур	308	120,676	187,369	1,223.9	309,269
<b>Дэд нийлбэр<sup>42</sup></b>		<b>7,260</b>	<b>4,152,930</b>	<b>3,563,170</b>	<b>149,948</b>	<b>7,866,048</b>
Ховд	Булган	355	427,500	370,383	13,764.7	811,648
	Үенч	176	119,834	148,850	7,894.0	276,577
	Цэцэг	708	933,197	596,596	14,002.7	1,543,795
Увс	Тариалан	154	61,554	53,281	5,344.9	120,180
	Өмнөговь	335	145,816	159,189	5,485.4	310,490
<b>Дэд нийлбэр<sup>43</sup></b>		<b>1,728</b>	<b>1,687,901</b>	<b>1,328,299</b>	<b>46,491.7</b>	<b>3,062,690</b>
<b>Нийт дүн</b>		<b>8988</b>	<b>5,840,831</b>	<b>4,891,469</b>	<b>196,439.8</b>	<b>10,928,740</b>

Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

**Дүгнэлт:** Дараах хүснэгтэнд БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт үзүүлж буй шүүд нөлөөг тоймлон харууллаа. Давтан судалгаанд хамрагдсан 15 суманд үйл ажиллагаагаа явуулж буй нийт БУЭ болон АМХЭ-д сард ойролцоогоор 10.9 тэрбум төгрөгийн шүүд хувь нэмрийг эдийн засагт оруулж байна. Үүнээс ойролцоогоор 8.9 тэрбум нь орон нутгийн эдийн засагт үлдэж байна (Хүснэгт 58).

42 Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд

43 Давтан судалгаанд шинээр нэмэгдсэн сумдын хувьд

Харин судалгаанд хамрагдсан БУЭ болон АМХЭ-д нийтдээ 237.2 сая төгрөгийн шууд хувь нэмрийг сардаа эдийн засагт оруулж байна. Үүнээс 194.9 сая орчим нь орон нутгийн эдийн засагт үлдэж байна (Хүснэгт 59).

**Хүснэгт 59 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд хувь нэмрийн нэгдсэн дүн, суурь ба давтан судалгаагаар**

Тооцооллын түвшин	Суурь судалгаа-2015				Давтан судалгаа-2016	
	Ажлын байр	БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд хувь нэмэр		Ажлын байр	БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд хувь нэмэр	
		Нийт дүн (мянган төгрөг/сар)	Үүнээс сумын эдийн засагт үлдэж буй хэсэг (мянган төгрөг/сар)		Нийт дүн (мянган төгрөг/сар)	Үүнээс сумын эдийн засагт үлдэж буй хэсэг (мянган төгрөг/сар)
Сумын түвшинд	5802	6,356,693.5	5,080,411.9	8988	10,928,740	8,926,130
Судалгаанд оролцогчдын түвшинд	145	134,532.7	108,363.9	175	237,281.1	194,923.5

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

### 3 ЭДИЙН ЗАСГИЙН ШУУД БУС ХУВЬ НЭМЭР

Судалгааны энэ хэсэгт албан ба албан бус БУЭ-д болон АМХЭ-дийн орон нутгийн эдийн засагт оруулж байгаа шууд бус хувь нэмрийг тооцлоо. Эдийн засгийн шууд бус хувь нэмэр нь БУЭ болон АМХЭ-дэд бүтээгдэхүүн үйлчилгээгээ нийлүүлснээр ханган нийлүүлэгчид хичнээн ажлын байр шинээр бий болгов, хэдий хэмжээний татвар төлөв, хэдий хэмжээний худалдан авалтын зардал гаргав гэдгээр хэмжигдэнэ. Энэ судалгааны хүрээнд ханган нийлүүлэгчдээр тухайн суманд үйл ажиллагаагаа эрхэлж байгаа жижиг дунд бизнес эрхлэгчид болон малчдыг хамрууллаа. ЖДБ эрхлэгчдэд дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдийг хамрууллаа. Үүнд: хүнс, ундаа, тамхи голлосон төрөлжсөн бус барааны жижиглэн худалдаа, төрөлжсөн бус барааны бусад дэлгүүрийн жижиглэн худалдаа, хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, ундааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, тамхины төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, ресторан ба хүнсний явуулын үйлчилгээ.

Нөгөө талаас бизнес эрхлэгчид болон малчдын БУЭ-с олж буй орлогын нийлбэр нь БУЭ болон АМХЭ-дийн шууд бус хувь нэмрээс хэтрэхгүй байх ёстой юм.

Доорх зурагт эдийн засгийн шууд бус нөлөөг тооцох бүрэлдэхүүн хэсгүүд болон тэдгээрийг тооцоход шаардагдах хүчин зүйлсийг нэгтгэн харууллаа.

#### Дүрс 37 Эдийн засгийн шууд бус нөлөө ба түүний бүрэлдэхүүн хэсгүүд

-	-	

Эдийн засгийн шууд бус хувь нэмрийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг дараах дэд бүлгүүдэд авч үзнэ.

#### Давтан судалгаанд хамрагдсан ханган нийлүүлэгчдийн талаарх тойм мэдээлэл

Давтан судалгаанд нийт 33 бизнес эрхлэгч, 50 малчин оролцсон бөгөөд нэг сумаас дунджаар 2 бизнес эрхлэгч, 4 малчин хамрагджээ. Бизнес эрхлэгчдийн 94% нь хүнс ба барааны худалдаа, 3% нь үйлчилгээ, 3% нь үйлдвэрлэл эрхэлдэг ажээ.

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид дунджаар 11 жил тухайн бизнесээ эрхэлж байгаа бол хамгийн ихдээ 30 жил, хамгийн багадаа 1 жил тухайн бизнесээ эрхэлж байгаа аж. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 30.3% нь 1-5 жил, 30.3% нь 6-10 жил, 30.3% нь 11-20 жил, 9.1% нь 20-иос дээш жил үйл ажиллагаагаа явуулж байна.

Түүнчлэн тэд дунджаар 8 жил БУЭ-дэд бараа, үйлчилгээгээ нийлүүлж байна. Бизнес эрхлэгчдийн 42.4% нь нь 1-5 жил, 36.4% нь 6-10 жил, 21.2% нь 10-аас дээш жил БУЭ-дэд бараа, үйлчилгээ нийлүүлж байгаа ажээ.

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн дундаж үйлчлүүлэгчдийн тоо өдөрт 61 орчим байдаг бол хамгийн ихдээ 200, хамгийн багадаа 5 үйлчлүүлэгч байдаг ажээ. Бизнес эрхлэгчдийн 88% нь нийт үйлчлүүлэгчдийнх нь 50 ба түүнээс доош хувь нь БУЭ-д байдаг гэсэн бол үлдсэн 12% нь нийт үйлчлүүлэгчдийнхээ 50-иас дээш хувийг БУЭ-д гэж үзжээ.

Судалгаанд оролцсон малчдын хувьд 66% нь БУЭ-дэд мах, сүү, сүүн бүтээгдэхүүнээ борлуулдаг бол үлдсэн 34% нь бүтээгдэхүүнээ борлуулдаггүй ажээ. Бүтээгдэхүүнээ борлуулдаг малчдын 67% нь мах, 33% нь сүү, сүүн бүтээгдэхүүнээ БУЭ-дэд борлуулдаг ажээ.

**Бизнес эрхлэгчид болон малчдын БУЭ-дэд бараа, үйлчилгээгээ борлуулснаас олох орлого**

Өмнө хэлсэнчлэн бизнес эрхлэгчид болон малчдын БУЭ-с олж буй орлогын нийлбэр нь БУЭ-дийн эдийн засагт үзүүлэх шууд бус хувь нэмрээс хэтрэхгүй байх ёстой юм. Иймд БУЭ-дийн эдийн засагт үзүүлэх шууд бус хувь нэмрийг тооцохоос өмнө бизнес эрхлэгчид болон малчид БУЭ-дэд бараа, үйлчилгээгээ борлуулснаар хичнээн хэмжээний орлого олдог болохыг авч үзье.


**Бизнес эрхлэгчид.** Давтан судалгаанд оролцсон бизнес эрхлэгчид бизнесээсээ сард дунджаар 5,256,771 төгрөгний орлого олдог бөгөөд хамгийн ихдээ 20 сая төгрөг, хамгийн багадаа 100,000 төгрөгний орлого олдог ажээ. Бизнес эрхлэгчдийн 15% нь сард 1 хүртэл сая төгрөг, 33% нь сард 1-3 сая төгрөг, 12% нь сард 3-5 сая төгрөг, 21% нь сард 5 саяас дээш төгрөгний орлогыг бизнесээсээ олж байна.

Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчид бизнесийн орлогынхоо дунджаар 34 орчим хувийг БУЭ-дээс олдог бөгөөд бүх орлогоо БУЭ-дээс олдог бизнес эрхлэгч ч судалгаанд хамрагджээ.

Тодруулбал, бизнес эрхлэгчид БУЭ-дээс сард дунджаар 1.85 сая төгрөгний орлого олж байгаа бол хамгийн ихдээ сард 12.9 сая төгрөг, хамгийн багадаа 30,000 төгрөгний орлого олж байна.

Дараах зурагт судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн бизнесийн нийт орлого болон тэдний БУЭ-дээс олдог орлогыг үзүүлээ.

**Дүрс 38 Бизнесийн нийт орлого ба БУЭ-дийн оруулж буй орлого**



Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

Давтан судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид нийтдээ 168.2 сая төгрөгийн орлогыг бизнесээсээ сард олдог бөгөөд үүний 59.3 сая төгрөгийг БУЭ болон АМХЭ-дээс олдог байна. Хулд, Шарын гол, Булган сумын бизнес эрхлэгчид БУЭ-дээс нийт орлогынхоо 60-аас дээш хувийг бүрдүүлдэг ажээ.

Харин Үенч сумын бизнес эрхлэгчид БУЭ-дээс нийт орлогынхоо зөвхөн 10 хувийг бүрдүүлдэг байна (Хүснэгт 60).

### Хүснэгт 60 Бизнесийн нийт орлого ба БУЭ-дийн оруулж буй нийт орлого, сумдаар

Аймаг	Сум	Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн тоо	Бизнесийн нийт орлого (төгрөг/сар)	БУЭ-дээс олж буй орлого (төгрөг/сар)	БУЭ-дийн оруулж буй орлогын бизнесийн нийт орлогод эзлэх хувь
Баянхонгор	Баян-Овоо	2	1,200,000	360,000	30%
	Бөмбөгөр	2	25,000,000	6,100,000	24%
Говь-Алтай	Есөнбулаг	4	8,600,000	1,510,000	18%
Дорноговь	Айраг	4	20,500,000	4,700,000	23%
Дундговь	Хулд	2	18,500,000	13,835,000	75%
	Өлзийт	2	10,000,000	2,900,000	29%
Дархан-Уул	Шарын гол	3	12,000,000	7,800,000	65%
Сэлэнгэ	Мандал	2	6,500,000	950,000	15%
Төв	Заамар	2	14,416,000	3,983,200	28%
	Борнуур	2	7,500,000	1,125,000	15%
Ховд	Булган	1	11,000,000	6,600,000	60%
	Үенч	1	1,000,000	100,000	10%
	Цэцэг	2	7,500,000	2,145,000	29%
Увс	Тариалан	2	17,500,000	4,750,000	27%
	Өмнөговь	2	7,000,000	2,500,000	36%
<b>Нийт дүн</b>		<b>33</b>	<b>168,216,000</b>	<b>59,358,200</b>	-

Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн зөвхөн 6% нь өнгөрсөн онтой харьцуулахад бизнесийн орлого нь өссөн гэж үзсэн бол 60% нь буурсан, 33% нь өөрчлөгдөөгүй гэжээ. Орлого нь өөрчлөгдсөн бизнес эрхлэгчдийн 1/3 нь БУЭ-дийн худалдан авах чадварын өөрчлөлтөөс шалтгаалж тэдний бизнесийн орлого өөрчлөгдсөн гэж үзэж байна.


Бичил уурхай эрхлэгчид бизнес эрхлэгчдээс худалдан авсан бараа, үйлчилгээнийхээ төлбөрийг ихэвчлэн бэлэн мөнгөөр хийдэг гэж олонх бизнес эрхлэгчдэд хэлж байна.

Ашигт малтмалаас хамааралтай сумдад аливаа үйл ажиллагаа улирлаас нэлээдгүй хамааралтай болох нь ажиглагдаж байна. Бизнес эрхлэгчид үйл ажиллагаанд нь улирал хэрхэн нөлөөлдгийг үнэлсэн бөгөөд үүнийг Дүрс 39-д харуулав. Энэхүү үнэлгээнээс дүгнэхэд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны улирлын мөчлөгийн үнэлгээ БУЭ болон АМХЭ-дийн үйл ажиллагааны улирлын мөчлөгийн үнэлгээтэй бараг давхцаж байгаа бөгөөд бизнесийн үйл ажиллагаа нь олборлолтын нэгэн адил зун эрчимжиж, намар тогтворжиж, өвөл зогсож, хавар саардаг гэсэн дүр зураг ажиглагдаж байна.

Бизнесийн үйл ажиллагаа нь эрчимждэгийн гол шалтгаанаар БУ-н олборлолт ихэсдэг, үйл ажиллагаа нь саардагийн гол шалтгаанаар БУ-н олборлолт буурдаг хэмээн бизнес эрхлэгчдийн олонх нь хариулжээ.



### Дүрс 39 БУ-н олборлолт ба АМХ-ны улирлын мөчлөг




Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

Малчин өрх. Давтан судалгаанд хамрагдсан малчин өрхийн сарын дундаж орлого 554,000 төгрөг байв. Малчин өрхийн 28% нь 300,000 төгрөг ба түүнээс доош хэмжээний сарын орлоготой, 28% нь 300-500 мянган төгрөгний сарын орлоготой, 18% нь 500-700 мянган төгрөгний сарын орлоготой, 12% нь 700-900 мянган төгрөгний сарын орлоготой бол үлдсэн 14% нь 900 мянган төгрөгөөс дээш сарын орлоготой байна. Судалгаанд хамрагдсан малчдын 66% нь бичил үүрхай эрхлэгчдэд бүтээгдэхүүнээ борлуулдаг бол 34% нь бүтээгдэхүүнээ борлуулдаггүй ажээ.

БУЭ-дэд бүтээгдэхүүнээ борлуулдаг малчдын 67% нь мах, 33% нь сүү, сүүн бүтээгдэхүүнээ нийлүүлж байна. БУЭ-дийг голдуу төлбөрөө бэлэн мөнгөөр хийдэг талаар малчид хэлж байлаа. Тодруулбал, малчдын 88% нь БУЭ-дийг төлбөрөө бэлэн мөнгөөр хийдэг, 12% нь богино хугацааны зээлээр төлдөг хэмээн хариулжээ. Эдгээр малчид дунджаар 2 жил, хамгийн ихдээ 10 жил, хамгийн багадаа 1 сар БУЭ-дэд бүтээгдэхүүнээ борлуулж байгаа ажээ.

БУЭ-дэд бүтээгдэхүүнээ борлуулдаг малчид өрхийн орлогынхоо дунджаар 28 орчим хувийг БУЭ-дээс олдог бөгөөд бүх орлогоо БУЭ-дээс олдог малчид ч судалгаанд хамрагджээ. Тодруулбал, малчид БУЭ-дээс сард дунджаар 183,454 төгрөгний орлого олж байгаа бол хамгийн ихдээ сард 600,000 төгрөг, хамгийн багадаа 5,500 төгрөгний орлого олж байна. Дараах зурагт БУЭ-дэд бүтээгдэхүүнээ борлуулдаг малчдын өрхийн сарын орлого болон тэдний БУЭ-дээс олдог орлогыг үзүүлээ.

**Дүрс 40 Малчин өрхийн орлого ба БУЭ-дээс олж буй орлого**



Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

Давтан судалгаанд хамрагдсан БУЭ-дэд бүтээгдэхүүнээ нийлүүлдэг малчид нийтдээ 27.7 сая төгрөгийн өрхийн орлоготой бөгөөд үүний 6.7 сая төгрөгийг БУЭ-дээс олж байна. Цэцэг, Мандал сумын малчид БУЭ-дээс өрхийн сарын орлогынхоо 50-иас дээш хувийг бүрдүүлдэг ажээ. Харин Борнуур сумын малчид БУЭ-дээс өрхийн сарын орлогынхоо зөвхөн 1 хувийг бүрдүүлдэг байна (Хүснэгт 61).

**Хүснэгт 61 Малчин өрхүүдийн сарын нийт орлого ба БУЭ-дийн оруулж буй нийт орлого, сумдаар**

Аймаг	Сум	Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тоо	Өрхийн сарын нийт орлого (төгрөг)	БУЭ-дээс олж буй нийт орлого (төгрөг/сар)	БУЭ-дийн оруулж буй орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувь
Баянхонгор	Баян-Овоо	3	2,350,000	470,000	20%
	Бөмбөгөр	3	1,000,000	120,000	12%
Говь-Алтай	Есөнбулаг	6	2,400,000	144,000	6%
Дорноговь	Айраг	6	4,350,000	870,000	20%
Дундговь	Хулд	3	1,600,000	144,000	9%
	Өлзийт	3	2,300,000	322,000	14%
Дархан-Уул	Шарын гол	4	1,110,000	399,600	36%
Сэлэнгэ	Мандал	4	3,000,000	1,500,000	50%
Төв	Заамар	3	2,650,000	662,500	25%
	Борнуур	3	1,050,000	10,500	1%
Ховд	Булган	2	530,000	159,000	30%
	Үенч	2	1,010,000	-	-
	Цэцэг	2	1,200,000	804,000	67%
Увс	Тариалан	3	2,050,000	615,000	30%
	Өмнөговь	3	1,100,000	495,000	45%
<b>Нийт дүн</b>		<b>50</b>	<b>27,700,000</b>	<b>6,715,600</b>	-

Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан малчдын 12% нь өнгөрсөн онтой харьцуулахад өрхийн орлого нь өссөн гэж үзсэн бол 26% нь буурсан, 62% нь өөрчлөгдөөгүй гэжээ. БУЭ-дэд бүтээгдэхүүн нийлүүлдэг, орлого нь өөрчлөгдсөн малчдын 50% нь БУЭ-дийн худалдан авах чадварын өөрчлөлтөөс шалтгаалж тэдний орлого өөрчлөгдсөн гэж үзжээ.

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид болон малчдын БУЭ-дээс олж буй нийт орлого нь сард 66 сая төгрөг байна.

## Хүснэгт 62 Бизнес эрхлэгч ба малчин өрхийн БУЭ-дээс олж буй нийт орлого

Аймаг	Сум	Бизнес эрхлэгчдийн БУЭ-дээс олж буй нийт орлого (төгрөг/сар)	Малчин өрхийн БУЭ-дээс олж буй нийт орлого (төгрөг/сар)	Нийт орлого (төгрөг/сар)
Баянхонгор	Баян-Овоо	360,000	470,000	830,000
	Бөмбөгөр	6,100,000	120,000	6,220,000
Говь-Алтай	Есөнбулаг	1,510,000	144,000	1,654,000
Дорноговь	Айраг	4,700,000	870,000	5,570,000
Дундговь	Хулд	13,835,000	144,000	13,979,000
	Өлзийт	2,900,000	322,000	3,222,000
Дархан-Уул	Шарын гол	7,800,000	399,600	8,199,600
Сэлэнгэ	Мандал	950,000	1,500,000	2,450,000
Төв	Заамар	3,983,200	662,500	4,645,700
	Борнуур	1,125,000	10,500	1,135,500
Ховд	Булган	6,600,000	159,000	6,759,000
	Үенч	100,000	-	100,000
	Цэцэг	2,145,000	804,000	2,949,000
Увс	Тариалан	4,750,000	615,000	5,365,000
	Өмнөговь	2,500,000	495,000	2,995,000
<b>Нийт дүн</b>		<b>59,358,200</b>	<b>6,715,600</b>	<b>66,073,800</b>

Эх сурвалж: Давтан судалгааны үр дүн

**Дүгнэлт.** Энэ хэсгийн гол үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэвэл:

- )] Давтан судалгаанд оролцсон бизнес эрхлэгчид бизнесээсээ сард дунджаар 5,2 сая төгрөгний орлого олдог бөгөөд хамгийн ихдээ 20 сая төгрөг, хамгийн багадаа 100,000 төгрөгний орлого олдог ажээ. Судалгаанд оролцсон бизнес эрхлэгчид бизнесийн орлогынхоо дунджаар 34 орчим хувийг БУЭ-дээс олж байна. Тодруулбал, бизнес эрхлэгчид БУЭ-дээс сард дунджаар 1.85 сая төгрөгний орлого олж байгаа бол хамгийн ихдээ сард 12.9 сая төгрөг, хамгийн багадаа 30,000 төгрөгний орлого олж байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид нийтдээ 168.2 сая төгрөгийн орлогыг бизнесээсээ сард олдог бөгөөд үүний 59.3 сая төгрөгийг БУЭ-дээс олж байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан малчин өрхийн сарын дундаж орлого 554,000 төгрөг байв. Судалгаанд хамрагдсан малчдын 66% нь БУЭ-дэд бүтээгдэхүүнээ борлуулдаг бол 34% нь бүтээгдэхүүнээ борлуулдаггүй байна.
- )] БУЭ-дэд бүтээгдэхүүнээ борлуулдаг малчид өрхийн орлогынхоо дунджаар 28 орчим хувийг БУЭ-дээс олж байна. Тодруулбал, малчид БУЭ-дээс сард дунджаар 138,454 төгрөгний орлого олж байгаа бол хамгийн ихдээ сард 600,000 төгрөг, хамгийн багадаа 5,500 төгрөгний орлого олж байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан БУЭ-дэд бүтээгдэхүүнээ нийлүүлдэг 50 малчин нийтдээ 27.7 сая төгрөгийн өрхийн орлоготой бөгөөд үүний 6.7 сая төгрөгийг БУЭ-дээс олж байна.
- )] Бизнес эрхлэгчид болон малчдын БУЭ-дээс олж буй нийт орлого нь сард 66 сая төгрөг байна.

### 3.1 Ажил эрхлэлт

Ажил эрхлэлтээс үүдэлтэй эдийн засгийн шууд бус нөлөө нь БУЭ-дэд бараа, үйлчилгээ нийлүүлдэг болсноор бизнес эрхлэгчдийн бий болгосон ажлын байрны тоо болон тэдгээрийн ажил эрхлэлтэд гаргасан цалингийн зардлаар хэмжигдэнэ.

Давтан судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 79% нь өөрөөсөө гадна нийт 57 ажилчинтай ажээ. Эдгээр ажилчдын 48 нь бүтэн цагаар ажилладаг бол 9 нь хагас цагаар ажилладаг байна. Иймд судалгаанд оролцсон 33 бизнес эрхлэгч нийтдээ 90 ажлын байр,<sup>44</sup> нэг бизнес эрхлэгч дунджаар 2.7 ажлын байрыг бий болгожээ.

Харин суурь судалгаанд хамрагдсан 15 бизнес эрхлэгч нийт 71 ажлын байр, нэг бизнес эрхлэгч дунджаар 4.7 ажлын байр бий болгож байжээ. Суурь судалгаатай харьцуулахад нэг бизнес эрхлэгчийн бий болгосон ажлын байр дунджаар хоёроор бүүрсан байна. Энэ нь үүсээд буй эдийн засгийн хямралтай холбоотой байж болох юм. Ажилчдын 90% нь тухайн сумын иргэн, 7% нь аймгийн төвийн иргэн, 3% нь Улаанбаатар хотын иргэн ажээ.

Түүнчлэн давтан судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ажилчдын сарын дундаж цалин 327,273 төгрөг бөгөөд хамгийн ихдээ 600,000 төгрөг, хамгийн багадаа 180,000 төгрөг байна. Судалгаанд хамрагдсан 33 бизнес эрхлэгч нийтдээ 29.1 сая төгрөгийг цалингийн зардалд сард зарцуулж байна. Үүнийг суурь судалгаатай харьцуулахад 20 сая төгрөгөөр өссөн бөгөөд 7.4 сая нь давтан судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумаас хамрагдсан бизнес эрхлэгчдийн цалингийн зардал юм. Харин үлдсэн 12.6 сая төгрөг нь суурь судалгаанд хамрагдаж байсан сумдаас оролцсон бизнес эрхлэгчдийн тоо болон дундаж цалингийн зардлын өөрчлөлтөөс үүдэлтэй. Түүнчлэн суурь судалгаанд оролцож байсан бизнес эрхлэгчид цалингийн зардлынхаа мэдээллийг тэр бүр тодорхой өгөөгүйтэй холбоотой юм (Хүснэгт 63).

Одоо бизнес эрхлэгчдийн зарцуулж буй цалингийн зардлын хичнээн нь БУЭ-дийн оруулсан орлогоос үүдэлтэй болохыг авч үзье. Үүнийг тооцохдоо БУЭ-дийн бизнесийн орлогод оруулж буй хувийг цалингийн нийт зардлаар үржүүлж тооцлоо. Судалгаанд хамрагдсан 33 бизнес эрхлэгч сард 29.6 сая төгрөгийн цалингийн зардал гаргадаг бөгөөд үүний 8.9 сая нь БУЭ-дийн оруулсан орлогоос үүдэлтэй гэж дүгнэж болохоор байна. Үүнийг суурь судалгаатай харьцуулахад 5.8 сая төгрөгөөр өссөн бөгөөд 2.4 сая нь давтан судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумаас хамрагдсан бизнес эрхлэгчдийн БУЭ-дээс үүдэлтэй цалингийн зардал юм. Харин үлдсэн 3.4 сая төгрөг нь суурь судалгаанд хамрагдаж байсан сумдаас оролцсон бизнес эрхлэгчдийн тоо, дундаж цалингийн зардал, БУЭ-дийн оруулж буй орлогын өөрчлөлтөөс үүдэлтэй (Хүснэгт 63).

---

<sup>44</sup> 57 +33 =90

**Хүснэгт 63 Бизнес эрхлэгчдийн бий болгосон ажлын байрны тоо болон цалингийн зардал, судалгаанд оролцогчдын түвшинд**

Байршил		Суурь судалгаа-2015 (ТХ=24)			Давтан судалгаа-2016 (ТХ=33)			
		Ажлын байр(а)	Цалингийн нийт зардал (т)	БУЭ-чдээс цалингийн зардал	Ажлын байр(а)	Сарын дундаж цалин (т)	Цалингийн нийт зардал (т)	БУЭ-чдээс цалингийн зардал
Аймаг	Сум							
Баянхонгор	Баян-Овоо	1	0	0	4	300,000	1,200,000	360,000
	Бөмбөгөр	6	950,000	152,000	6	475,000	2,850,000	695,400
Говь-Алтай	Есөнбулаг	2	0	0	10	200,000	2,000,000	351163
	Бигэр	3	200,000	50,000	-	-	-	-
Дорноговь	Айраг	16	900,000	382,500	10	270,000	2,700,000	619024.4
Дундговь	Хулд	5	1,920,000	748,800	4	500,000	2,000,000	1495676
	Өлзийт	7	0	0	3	220,000	660,000	191,400
Дархан-Уул	Шарынгол	5	192,000	86,400	6	300,000	1,800,000	1,170,000
Сэлэнгэ	Мандал	3	500,000	350,000	6	300,000	1,800,000	263,077
	Орхонтуул	2	483,000	144,900	-	-	-	-
Төв	Заамар	8	1,000,000	150,000	10	325,000	3,250,000	897,988
	Борнуур	13	3,000,000	1,050,000	10	350000	3,500,000	525,000
<b>Дэд нийлбэр<sup>45</sup></b>		<b>71</b>	<b>9,145,000</b>	<b>3,114,600</b>	<b>69</b>	<b>309,000</b>	<b>21,760,000</b>	<b>6,568,728</b>
Ховд	Булган	-	-	-	4	300000	1,200,000	720,000
	Үенч	-	-	-	3	300000	900,000	90,000
	Цэцэг	-	-	-	6	275000	1,650,000	471,900
Увс	Тариалан	-	-	-	6	425000	2,550,000	692,143
	Өмнөговь	-	-	-	2	550000	1,100,000	392,857
<b>Дэд нийлбэр<sup>46</sup></b>		<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>21</b>	<b>375,000</b>	<b>7,400,000</b>	<b>2,366,900</b>
<b>Нийт дүн</b>		<b>71</b>	<b>9,145,000</b>	<b>3,114,600</b>	<b>90</b>	<b>327,272</b>	<b>29,160,000</b>	<b>8,935,628</b>

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

Тайлбар: ■ -дундаж утга; (а)-судалгаанд хамрагдсан 33 бизнес эрхлэгчийг оруулав.

Давтан судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 12% нь БУЭ-дэд бараа, үйлчилгээ нийлүүлдэг болсноор ажлын байр шинээр нэмэгдсэн гэж үзсэн бол үлдсэн 88% нь нэмэгдээгүй гэжээ. БУЭ-дтэй холбоотой ажлын байр шинээр нэмэгдсэн гэж үзсэн бизнес эрхлэгчид 6 ажлын байр шинээр нэмэгдсэн гэж үзжээ.

Судалгаанд хамрагдсан сумдын нийт бизнес эрхлэгчдийн бий болгосон ажлын байрны тоо болон цалингийн зардал. Энэ хэсэгт сумын түвшинд буюу сумын бүх бизнес эрхлэгчдийн бий болгосон ажлын байрны тоо болон тэдгээрт гаргаж буй цалингийн зардлын тойм тооцооллыг авч үзнэ. Ялангуяа бизнес эрхлэгчдийн гаргаж буй цалингийн зардлын хичнээн нь БУЭ-дийн оруулсан орлогоос үүдэлтэй болохыг авч үзнэ.

45 Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд

46 Давтан судалгаанд шинээр нэмэгдсэн сумдын хувьд

Ингэхдээ бизнес эрхлэгчдийн ажилчиддаа төлж буй цалингийн дундаж зардал, сумын бизнес эрхлэгчдийн бий болгосон ажлын байрны тоо, БУЭ-ийн оруулж буй орлогын бизнесийн нийт орлогод эзэлж буй хувьд үндэслэн цалингийн зардлыг сум тус бүрээр тооцлоо.

Хүснэгт 64-д үзүүлснээр давтан судалгаанд хамрагдсан 15 суманд үйл ажиллагаагаа эрхэлж байгаа 375 ААН<sup>47</sup> нийтдээ 1013 ажлын байрыг бий болгож, 297.2 сая төгрөгийг ажилчдынхаа цалинд зарцуулж байна. Үүнээс ойролцоогоор 91.3 сая төгрөг нь БУЭ-дийн орлогоос үүдэлтэй ажээ.

#### Хүснэгт 64 Бизнес эрхлэгчдийн бий болгосон ажлын байрны тоо болон цалингийн зардал, сумын түвшинд

Байршил		Суурь судалгаа-2015		Давтан судалгаа-2016				
		Ажлын байр(а)	БУЭ-чдээс үүдэлтэй нийт цалингийн зардал (төгрөг/сар)	ААН-ийн тоо	Ажлын байр(а)	Сарын дундаж цалин (төгрөг)	Цалингийн нийт зардал (төгрөг/сар)	БУЭ-чдээс үүдэлтэй нийт цалингийн зардал (төгрөг/сар)
Аймаг	Сум							
Баянхонгор	Баян-Овоо	1	-	2	5	300,000	1,620,000	486,000
	Бөмбөгөр	6	304,000	5	14	475,000	6,412,500	1,564,650
Говь-Алтай	Есөнбулаг	199	2,865,600	75	203	200,000	40,500,000	7,111,047
	Бигэр	20	500,000	-	-	-	-	-
Дорноговь	Айраг	36	3,442,500	15	41	270,000	10,935,000	2,507,049
Дундговь	Хулд	16	5,990,400	5	14	500,000	6,750,000	5,047,905
	Өлзийт	12	-	4	11	220,000	2,376,000	689,040
Дархан-Уул	Шарын гол	48	2,073,600	34	92	300,000	27,540,000	17,901,000
Сэлэнгэ	Мандал	170	59,500,000	90	243	300,000	72,900,000	10,654,615
	Орхонтуул	24	3,477,600	-	-	-	-	-
Төв	Заамар	32	2,400,000	11	30	325,000	9,652,500	2,667,025
	Борнуур	8	4,200,000	4	11	350,000	3,780,000	567,000
Ховд	Булган	-	-	45	122	300,000	36,450,000	21,870,000
	Үенч	-	-	25	68	300,000	20,250,000	2,025,000
	Цэцэг	-	-	40	108	275,000	29,700,000	8,494,200
Увс	Тариалан	-	-	4	11	425,000	4,590,000	1,245,857
	Өмнөговь	-	-	16	43	550,000	23,760,000	8,485,714
<b>Нийт дүн</b>		<b>572</b>	<b>84,753,700</b>	<b>375</b>	<b>1,013</b>	<b>327,272</b>	<b>297,216,000</b>	<b>91,316,103</b>

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

Тайлбар: ■ -дундаж утга;

(а)-сумын түвшинд бизнес эрхлэгчдийн бий болгосон ажлын байрны тоо=сумын ААН-ийн тоогхнэг ААН-ийн дунджаар бий болгож байгаа ажлын байрны тоо. Энд: сумын ААН-ийн тоог УСХ-ны бизнес регистрийн сангийн мэдээллээс, нэг ААН-ийн дунджаар бий болгож буй ажлын байрны тоог давтан судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн мэдээллээс тус тус авч ашиглав.

**Дүгнэлт.** Энэ хэсгийн гол үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэвэл:

- ) Давтан судалгаанд оролцсон бизнес эрхлэгчид нийтдээ 90 ажлын байр, нэг бизнес эрхлэгч дунджаар 2.7 ажлын байрыг бий болгожээ.

47 Хүнс, ундаа, тамхи голлосон төрөлжсөн бус барааны жижиглэн худалдаа, төрөлжсөн бус барааны бусад дэлгүүрийн жижиглэн худалдаа, хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, ундааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, тамхины төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа, ресторан ба хүнсний явуулын үйлчилгээ эрхэлдэг ААН-үүдийг орууллаа.

- )] Давтан судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ажилчдын сарын дундаж цалин 327,273 төгрөг бөгөөд хамгийн ихдээ 600,000 төгрөг, хамгийн багадаа 180,000 төгрөг байна. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид нийтдээ 29.1 сая төгрөгийг цалингийн зардалд сард зарцуулж байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан 33 бизнес эрхлэгч сард 29.1 сая төгрөгний цалингийн зардал гаргадаг бөгөөд үүний ойролцоогоор 8.9 сая нь БУЭ-дийн оруулсан орлогоос үүдэлтэй ажээ.
- )] 15 суманд үйл ажиллагаагаа явуулж буй бизнес эрхлэгчид нийтдээ 1013 ажлын байрыг бий болгож, 297.2 сая төгрөгийг ажилчдынхаа цалинд зарцуулж байна. Үүнээс ойролцоогоор 91.3 сая төгрөг нь БУЭ-дийн орлогоос үүдэлтэй ажээ.

### **3.2 Худалдан авалт**

Худалдан авалтаас үүдэлтэй эдийн засгийн шууд бус нөлөө нь БУЭ-дэд бараа, үйлчилгээ нийлүүлдэг болсноор бизнес эрхлэгчид хичнээн хэмжээний худалдан авалтын зардал гаргав гэдгээр хэмжигдэнэ. Давтан судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн худалдан авалтыг бараа татан авалтын зардал, үйл ажиллагааны зардал, элэгдлийн зардал, хөрөнгө оруулалтын зардлаар тооцлоо. Харин суурь судалгаанд зөвхөн үйл ажиллагааны зардлыг авч үзсэн.

Бизнес эрхлэгчдийн худалдан авалтын зардлыг Хүснэгт 64-д дэлгэрэнгүй харууллаа. Судалгаанд хамрагдсан 33 бизнес эрхлэгчийн сарын зардал нь нийтдээ 150.9 сая төгрөг бөгөөд үүний 62% нь бараа татан авалтанд, 35% нь үйл ажиллагаад, 3% нь хөрөнгө оруулалтанд, 2% нь элэгдэлд зарцуулагддаг ажээ.

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид бараа татан авалтанд сард дунджаар 2.9 сая төгрөг, хамгийн ихдээ 10 сая, хамгийн багадаа 100 мянган төгрөгийг зарцуулж байна. Бизнес эрхлэгчдийн 18% нь 1 саяас доош төгрөгөөр, 39% нь 1-2.5 сая төгрөгөөр, 18% нь 2.5-4 сая төгрөгөөр, 9% нь 4-5.5 сая төгрөгөөр, 12% нь 5.5 саяас дээш төгрөгөөр бараа татан авалт хийж байна. Нийт дүнгээр нь авч үзвэл судалгаанд хамрагдсан 33 бизнес эрхлэгч нийтдээ 92.9 сая төгрөгийг бараа татан авалтанд зарцуулж байгаа бөгөөд үүний 22.6 сая төгрөг нь БУЭ-дийн оруулсан орлогоос үүдэлтэй ажээ.

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн бараа татан авалтын 58% нь Улаанбаатар хотоос, 37% нь аймгийн төвөөс, 5% нь сумаас хийгддэг байна. Иймд БУЭ-дийн оруулсан орлогоос үүдэлтэйгээр бизнес эрхлэгчийн бараа татан авалтанд зарцуулж байгаа 22.6 сая төгрөгний 13.1 сая төгрөг нь Улаанбаатарын эдийн засагт, 8.3 сая төгрөг нь аймгийн төвийн эдийн засагт, 1.2 сая төгрөг нь сумын эдийн засагт шингэж байна.

Үйл ажиллагааны зардалд түрээс, зээл, тээвэр, шатахуун, цахилгаан, ус, дулаан, удирдлагын зардлыг хамруулан авч үзсэн. Эдгээрээс зээлийн эргэн төлөлтөнд хамгийн их зардлыг гаргаж байна. Тодруулбал, судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид зээлийн эргэн төлөлтөнд нийт зардлынхаа 12%-ийг зарцуулж байна. Үйл ажиллагааны бусад зардлууд нь нийт зардлын 1%-3%-ийг эзэлж байна.

Бизнес эрхлэгчид үйл ажиллагааны зардалд сард дунджаар 1.6 сая төгрөг зарцуулж байгаа бол судалгаанд оролцсон 33 бизнес эрхлэгч нийтдээ 53.1 сая төгрөгийг зарцуулж байна. Үүнийг суурь судалгаатай харьцуулахад 39 сая төгрөгөөр буюу 3.76 дахин өсжээ. Энэхүү өсөлтийн 12.3 сая төгрөг нь давтан судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумаас оролцсон бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны зардал бол үлдсэн 26.7 сая төгрөг нь үйл ажиллагааны зардлын төрлийг нэмэгдүүлсэн, судалгаанд оролцогчдын тоо өссөн, үйл ажиллагааны дундаж зардал нэмэгдсэнтэй холбоотой юм (Хүснэгт 64).

Иймд судалгаанд хамрагдсан 33 бизнес эрхлэгч сард 150.9 сая төгрөгийг бараа татан авалт, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, элэгдлийн зардалд зарцуулж байгаа бөгөөд үүний 36.3 сая төгрөг нь БУЭ-дийн оруулсан орлогоос үүдэлтэй гэж дүгнэж болохоор байна.



**Хүснэгт 65 Бизнес эрхлэгчдийн худалдан авалтын зардал, судалгаанд оролцогчдын түвшинд, мянган төгрөг**

Байршил		Суурь судалгаа -2015	Давтан судалгаа-2016												
Аймаг	Сум	Ү ажиллагааны зардал	Бараа татан авалтын зардал	Үйл ажиллагааны зардал								Х оруулалтын зардал	Элэгдлийн зардал	Нийт зардал (b)	БУЭ-дээс үүдэлтэй нийт зардал
				Түрээс	Зээл	Тээвэр	Шатах уун	Цахилгаан, ус	Дулаан	Удирдлагын зардал	Нийт(а)				
Баянхонгор	Баян-Овоо	700.0	3,000	-	1,000.0	75.0	140.0	40.0	165.0	-	1420	-	80.0	4,420	1,326
	Бөмбөгөр	1,295.5	15,000	-	10,000.0	1,650.0	350.0	225.0	300.0	6.0	12531	-	200.0	27,531	5,506
Говь-Алтай	Есөнбулаг	2,160.0	2,750	400	1,950.0	400.0	185.0	1,790	500.0	-	5225	-	155.0	7,975	1,436
	Бигэр	353.0	-	-	-	-	-	-	-	-	0	-	-	-	-
Дорноговь	Айраг	1,281.2	11,850	270	4,169.0	1,300.0	150.0	435.0	1,600	550.0	8474	2,550.0	1,480.0	22,874	5,261
Дундговь	Хулд	1,695.8	8,750	-	1,000.0	1,000.0	400.0	190.0	30.0	-	2620	-	-	11,370	3,411
	Өлзийт	549.0	5,000	-	1,400.0	-	700.0	190.0	235.0	-	2525	320.0	260.0	7,845	2,275
Дархан-Уул	Шарын гол	470.0	8,000	-	3,480.0	500.0	370.0	80.0	600.0	-	5030	-	-	13,030	3,909
Сэлэнгэ	Мандал	1,297.0	2,600	300	400.0	60.0	170.0	130.0	-	-	1060	1,500.0	-	5,160	774
	Орхонтуул	490.0	-	-	-	-	-	-	-	-	0	-	-	-	-
Төв	Заамар	1,475.0	7,750	-	-	-	600.0	435.0	100.0	200.0	1335	400.0	-	9,485	2,656
	Борнуур	2,350.0	6,250	-	-	-	280.0	180.0	100.0	10.0	570	-	-	6,820	1,023
Дэд нийлбэр <sup>48</sup>		14,116.5	70,950	970	23,399	4,985	3,345	3,695	3,630	766	40,790	4,770	2,175	116,510	27,577
Ховд	Булган	-	1,000	-	2,500.0	300.0	200.0	110.0	120.0	-	3230	100.0	80.0	4,330	1,299
	Үенч	-	4,000	-	760.0	300.0	300.0	100.0	1,000	-	2460	-	50.0	6,460	646
	Цэцэг	-	6,000	-	60.0	1,300.0	300.0	75.0	300.0	-	2035	-	50.0	8,035	2,330
Увс	Тариалан	-	5,500	-	2,000.0	110.0	110.0	120.0	295.0	-	2635	-	50.0	8,135	2,196
	Өмнөговь	-	5,500	-	600.0	500.0	600.0	50.0	275.0	-	2025	-	45.0	7,525	2,258
Дэд нийлбэр <sup>49</sup>		-	22,000	0	5,920	2,510	1,510	455	1,990	0	12,385	100	275	34,485	8,729

48 Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд

49 Давтан судалгаанд шинээр хамрагдсан сумдын хувьд

Нийт дүн	14,116.5	92,950	970	29,319.0	7,495.0	4,855.0	4,150	5,620	766.0	53,175	4,870.0	2,450.0	150,995	36,306
Нийт зардалд эзлэх хувь	-	62%	1%	19%	5%	3%	3%	4%	1%		3%	2%	100%	-

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

Тайлбар: (a)-үйл ажиллагааны зардлын нийлбэр; (b)-бараа татан авалт, үйл ажиллагааны зардлын нийлбэр, хөрөнгө оруулалт, элэгдлийн зардлын нийлбэр

Судалгаанд хамрагдсан сумдын нийт бизнес эрхлэгчдийн худалдан авалтын зардал. Энэ хэсэгт сумын түвшинд буюу сумын бүх бизнес эрхлэгчдийн худалдан авалтын зардлыг авч үзнэ. Түүнчлэн бизнес эрхлэгчдийн гаргаж буй худалдан авалтын зардлын хичнээн нь БУЭ-дийн оруулсан орлогоос үүдэлтэй болохыг авч үзнэ.

Ингэхдээ бизнес эрхлэгчдийн худалдан авалтын дундаж зардал, сумын бизнес эрхлэгчдийн тоонд үндэслэн худалдан авалтын зардлыг сум тус бүрээр тооцлоо.

Хүснэгт 66-д судалгаанд хамрагдсан сумдад үйл ажиллагаагаа явуулж байгаа нийт бизнес эрхлэгчдийн худалдан авалтын зардлыг харуулав. Давтан судалгаанд хамрагдсан 15 суманд үйл ажиллагаагаа эрхэлж байгаа 375 ААН сард ойролцоогоор 1.3 тэрбум төгрөгний худалдан авалтын зардал (бараа татан авалт, үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалт, элэгдэл) гаргаж байна. Үүнээс ойролцоогоор 218.7 сая төгрөгний худалдан авалтын зардал нь БУЭ-дийн орлогоос үүдэлтэй ажээ (Хүснэгт 66).

Харин 218.7 сая төгрөгний 126.9 сая төгрөг нь Улаанбаатарын эдийн засагт, 80.9 сая төгрөг нь аймгийн төвийн эдийн засагт, 10.9 сая төгрөг нь сумын эдийн засагт шингэж байна хэмээн дүгнэж болохоор байна.

### Хүснэгт 66 Бизнес эрхлэгчдийн худалдан авалтын зардал, сумдын түвшинд

Байршил		Суурь судалгаа-2015	Давтан судалгаа-2016			
			Нийт худалдан авалтын зардал (мянган төгрөг/сар)	ААН- ийн тоо	Худалдан авалтын дундаж зардал (мянган төгрөг/сар)	Худалдан авалтын нийт зардал (мянган төгрөг/сар)
Аймаг	Сум					
Баянхонгор	Баян-Овоо	630	2	2,210	4,420	884
	Бөмбөгөр	69	5	13,766	68,828	6,883
Говь-Алтай	Есөнбулаг	16,119	75	1,994	149,531	14,953
	Бигэр	441	-	-	-	-
Дорноговь	Айраг	2,450	15	5,719	85,778	11,151
Дундговь	Хулд	2,645	5	5,685	28,425	5,685
	Өлзийт	659	4	3,923	15,690	2,981
Дархан-Уул	Шарын гол	2,538	34	4,343	147,673	29,535
Сэлэнгэ	Мандал	77,171	90	2,580	232,200	34,830
	Орхонтүүл	1,764	-			
Төв	Заамар	1,770	11	4,743	52,168	9,390
	Борнуур	1,645	4	3,410	13,640	2,046
<b>Дэд нийлбэр<sup>50</sup></b>			<b>245</b>		<b>798,352</b>	<b>118,338</b>
Ховд	Булган	-	45	4,330	194,850	38,970
	Үенч	-	25	6,460	161,500	16,150
	Цэцэг	-	40	4,018	160,700	30,533
Увс	Тариалан	-	4	4,068	16,270	2,766
	Өмнөговь	-	16	3,763	60,200	12,040
<b>Дэд нийлбэр<sup>51</sup></b>		-	<b>130</b>	-	<b>593,520</b>	<b>100,459</b>
<b>Нийт дүн</b>		<b>107,902</b>	<b>375</b>	<b>4,632</b>	<b>1,391,872</b>	<b>218,797</b>

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн  
Тайлбар: ■ - дундаж утга

<sup>50</sup> Суурь судалгаанд хамрагдсан сумдын хувьд

<sup>51</sup> Давтан судалгаанд шинээр хамрагдсан сумдын хувьд

**Дүгнэлт.** Энэ хэсгийн гол үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэвэл:

- )] Давтан судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид бараа татан авалтанд сард дунджаар 2.9 сая төгрөг зарцуулж байна. Нийт дүнгээр нь авч үзвэл судалгаанд хамрагдсан 33 бизнес эрхлэгч нийтдээ 92.9 сая төгрөгийг бараа татан авалтанд сард зарцуулж байгаа бөгөөд үүний 22.6 сая төгрөг нь БУЭ-дийн оруулсан орлогоос үүдэлтэй ажээ. Энэхүү 22.6 сая төгрөгний 13.1 сая төгрөг нь Улаанбаатарын эдийн засагт, 8.3 сая төгрөг нь аймгийн төвийн эдийн засагт, 1.2 сая төгрөг нь сумын эдийн засагт шингэж байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид үйл ажиллагааны зардалд сард дунджаар 1.6 сая төгрөг зарцуулж байна. Нийт дүгнээр нь авч үзвэл судалгаанд оролцсон 33 бизнес эрхлэгч нийтдээ 53.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа сард зарцуулж байна.
- )] Давтан судалгаанд хамрагдсан 33 бизнес эрхлэгч сард 150.9 сая төгрөгийг нийт зардал болох бараа татан авалт, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, элэгдлийн зардалд зарцуулж байгаа бөгөөд үүний 36.3 сая төгрөг нь БУЭ-дийн оруулсан орлогоос үүдэлтэй ажээ.
- )] Давтан судалгаанд хамрагдсан 15 суманд үйл ажиллагаагаа эрхэлж байгаа 375 ААН сард ойролцоогоор 1.3 тэрбум төгрөгний худалдан авалтын зардал (бараа татан авалт, үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалт, элэгдэл) гаргаж байна. Үүнээс ойролцоогоор 218.7 сая төгрөгний худалдан авалтын зардал нь БУЭ-дийн орлогоос үүдэлтэй ажээ.
- )] Энэхүү 218.7 сая төгрөгний 126.9 сая төгрөг нь Улаанбаатарын эдийн засагт, 80.9 сая төгрөг нь аймгийн төвийн эдийн засагт, 10.9 сая төгрөг нь сумын эдийн засагт шингэж байна хэмээн дүгнэж болохоор байна.

### **3.3 Татвар, төлбөр хураамж**

Татвараас үүдэлтэй эдийн засгийн шүүд бус нөлөө нь БУЭ-дэд бараа, үйлчилгээ нийлүүлдэг болсноор бизнес эрхлэгчид хичнээн хэмжээний татварыг орон нутгийн засаг захиргааны байгууллагад төлөв гэдгээр хэмжигдэнэ.

Давтан судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн татварын зардалд ХАОАТ, НДШ, ААН-ийн орлогын албан татвар, НӨАТ, бусад татвар, хураамжийг хамруулан авч үзлээ. Судалгаанд хамрагдсан 33 бизнес эрхлэгч сард 2.7 сая төгрөгийг татварт төлж байгаа бөгөөд үүний 22% нь ХАОАТ, 22% нь үйл ажиллагаад, 44% нь НДШ-д, 11% нь ААН-ийн орлогын албан татвар, 12% нь бусад татвар хураамжид зарцуулагддаг ажээ.

### Хүснэгт 67 Бизнес эрхлэгчдийн татвар төлөлт, судалгаанд оролцогчдын түвшинд

Байршил		Суурь судалгаа- 2015	Давтан судалгаа-2016					Нийт дүн (төгрөг)
Аймаг	Сум		Татвар, хураамж (төгрөг)	ХАОАТ (т)	НДШ (т)	ААН-ийн орлогын албан татвар (т)	Н (т)	
Баянхонгор	Баян-Овоо	0	-	-	20,500	-	-	20,500
	Бөмбөгөр	133,966	-	4,000	-	-	-	4,000
Говь-Алтай	Есөнбулаг	235,500	74,000	174,500	6,667	-	50,000	305,167
	Бигэр	71,500	-	-	-	-	-	-
Дорноговь	Айраг	567,349	35,667	149,000	45,000	150,000	144,167	523,833
Дундговь	Хулд	665,333	30,000	223,040	-	-	-	253,040
	Өлзийт	431,993	33,333	123,750	10,000	58,333	-	225,417
Дархан-Уул Сэлэнгэ	Шарын гол	139,826	20,000	24,000	30,000	-	-	74,000
	Мандал	138,300	-	-	5,833	-	833	6,667
	Орхонтуул	106,000	-	-	-	-	-	-
Төв	Заамар	286,330	-	116,850	25,000	-	50,000	91,850
	Борнуур	343,300	240,000	-	-	-	10,000	250,000
Ховд	Булган	-	30,000	81,390	90,000	90,000	26,667	318,057
	Үенч	-	-	23,040	10,000	-	-	33,040
	Цэцэг	-	73,333	82,327	25,000	-	10,000	190,660
Увс	Тариалан	-	12,000	112,967	40,500	-	28,333	193,800
	Өмнөговь	-	54,792	79,127	13,333	-	-	147,252
<b>Нийт</b>		<b>3,119,397</b>	<b>603,125</b>	<b>1,193,900</b>	<b>321,833</b>	<b>298,333</b>	<b>320,000</b>	<b>2,737,282</b>

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдсан сумдын нийт бизнес эрхлэгчдийн татвар төлөлт. Энэ хэсэгт сумын түвшинд буюу сумын нийт бизнес эрхлэгчдийн татвар төлөлтийг авч үзнэ. Түүнчлэн бизнес эрхлэгчдийн төлж буй татварын хичнээн нь БУЭ-дийн оруулсан орлогоос үүдэлтэй болохыг авч үзнэ.

Ингэхдээ бизнес эрхлэгчдийн татвар төлөлтийн мэдээллийг сумын удирдлагаас авч ашиглалаа.

Давтан судалгаанд хамрагдсан 15 суманд үйл ажиллагаагаа эрхэлж байгаа 375 ААН сард ойролцоогоор 22.3 сая төгрөгний татварыг төлж байна. Үүнээс ойролцоогоор 7.4 сая төгрөгний татвар төлөлт нь БУЭ-дийн орлогоос үүдэлтэй ажээ.

### Хүснэгт 68 Бизнес эрхлэгчдийн татвар төлөлт, сумын түвшинд

Байршил		Суурь судалгаа-2015	Давтан судалгаа-2016	
			Татвар, хураамж төлөлт (төгрөг/сар)	Татвар, хураамж төлөлт (төгрөг/сар)
Аймаг	Сум			
Баянхонгор	Баян-Овоо	-	20,500.0	6,150.0
	Бөмбөгөр	7,145	60,000.0	14,640.0
Говь-Алтай	Есөнбулаг	1,757,419	5,721,875.0	1,004,654.8
	Бигэр	89,375	-	-
Дорноговь	Айраг	1,085,053	1,514,375.0	347,198.2
Дундговь	Хулд	1,037,921	632,600.0	473,082.2
	Өлзийт	518,393	450,833.3	130,741.7
Дархан-Уул	Шарын гол	755,060	838,666.7	545,133.3
Сэлэнгэ	Мандал	8,228,850	900,000.0	131,538.5
	Орхонтуул	381,600	-	-
Төв	Заамар	343,596	1,055,175.0	291,549.2
	Борнуур	240,310	500,000.0	75,000.0
Ховд	Булган	-	4,412,550.0	2,647,530.0
	Үенч	-	826,000.0	82,600.0
	Цэцэг	-	3,813,200.0	1,090,575.2
Увс	Тариалан	-	387,600.0	105,205.7
	Өмнөговь	-	1,178,013.3	420,719.0
<b>Нийт</b>		<b>14,444,722</b>	<b>22,311,388.3</b>	<b>7,366,317.8</b>

Эх сурвалж: Суурь ба давтан судалгааны үр дүн

### 3.4 Шууд бус нөлөөллийн тойм

Судалгаанд оролцогчдын түвшинд. БУЭ болон АМХЭ-дэд бүтээгдэхүүнээ нийлүүлснээр судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид 90 ажлын байр бий болгож, сард 8.9 сая төгрөгийг ажилчдынхаа цалинд зарцуулж, сард 36.3 сая төгрөгөөр худалдан авалт хийж, сард 2.7 сая төгрөгийг татварт төлж байна. Нийтдээ тэд сард 47.9 сая төгрөгийг зарцуулж байгаа бөгөөд энэ нь БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд бус хувь нэмэр юм. Дараах хүснэгтэнд БУ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд бус хувь нэмрийг судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн хувьд сум бүрээр нэгтгэн харууллаа.

Суурь судалгаатай харьцуулахад<sup>52</sup> БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулах шууд бус хувь нэмэр 3.7 дахин буюу 35.2 сая төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийн 11.9 сая нь судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумаас оролцсон бизнес эрхлэгчдийн зардал бол үлдсэн 23.3 сая төгрөг нь худалдан авалтын зардалд бараа татан авалтын зардлыг нэмж тооцсонтой холбоотой юм (Хүснэгт 69).

52 Суурь судалгаанд БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулах шууд хувь нэмэр 12.7 сая төгрөг байв. Хүснэгт 67-аас харна уу.

**Хүснэгт 69 БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд бус хувь нэмэр, судалгаанд оролцогчдын түвшинд**

Байршил		Давтан судалгаа-2016				
		Ажил эрхлэлт		Худалдан авалт (төгрөг/сар)	Татвар, хураамж (төгрөг/сар)	Нийт дүн (төгрөг/сар)
Аймаг	Сум	Ажлын байр	Цалингийн зардал (төгрөг/сар)			
Баянхонгор	Баян-Овоо	4	360,000	1,326,000	20,500	1,706,500
	Бөмбөгөр	6	695,400	5,506,000	4,000	6,205,400
Говь-Алтай	Есөнбулаг	10	351163	1,436,000	305,167	2,092,330
Дорноговь	Айраг	10	619024.4	5,261,000	523,833	6,403,857
Дундговь	Хулд	4	1495676	3,411,000	253,040	5,159,716
	Өлзийт	3	191,400	2,275,000	225,417	2,691,817
Дархан-Уул	Шарын гол	6	1,170,000	3,909,000	74,000	5,153,000
Сэлэнгэ	Мандал	6	263,077	774,000	6,667	1,043,744
Төв	Заамар	10	897,988	2,656,000	191,850	3,745,838
	Борнуур	10	525,000	1,023,000	250,000	1,798,000
